

ЭМНЕСТИ

ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2017/18

**ДЭЛХИЙ ДАХИНЫ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**



**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	2
АЗИ, НОМХОН ДАЛАЙН БУС НУТГИЙН ТОЙМ	
Зүүн Ази	5
Өмнөд Ази	7
Зүүн өмнөд Ази ба Номхон далай	10
АМЕРИК ТИВИЙН БУС НУТГИЙН ТОЙМ	
Олон нийтийн аюулгүй байдал ба хүний эрх	16
Дүрвэгсэд, цагаачид болон харьяалалгүй хүмүүс	19
Уугуул иргэдийн эрх	20
Хүний эрхийн хамгаалагчид ба сэтгүүлчид	20
Охид, Эмэгтэйчүүдийн Эрх	21
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх	22
Лесбиян, гей, бисексуал, трансжендэр ба интерсекс хүмүүсийн эрх	23
Зэвсэгт мөргөлдөөн	23
АФРИК ТИВИЙН БУС НУТГИЙН ТОЙМ	
Өөрөөр сэтгэгчдийг дарамталсан нь	24
Зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл	27
Эрүү шүүлт, зүй бус харьцаа	28
Дүрвэж буй хүмүүс	28
Ял шийтгэлгүй өнгөрөөх нь	29
Ялгаварлан гадуурхалт	30
Албадан нүүлгэлт ба орон байртай байх эрх	31
Бизнес болон корпорацийн хариуцлага	31
Цаашдын төлөв	32
ЕВРОП, ТӨВ АЗИЙН БУС НУТГИЙН ТОЙМ	
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	34
Хязгаарласан хуулиуд	35
Эвлэлдэн нэгдэх, цуглах эрх чөлөө	35
Аюулаас хамгаалах ба Терроризмийн эсрэг арга хэмжээ	35
Дүрвэгч, цагаачид	36
Хуучин Югослав дахь ял шийтгэлгүй өнгөрөөх, хариуцлага тооцох байдал	38
Ялгаварлан гадуурхалт	39
ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БУС НУТГИЙН ТОЙМ	
Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө	41
Шашин шүтэх эрх чөлөө	43
Эмэгтэйчүүдийн эрх	43
ЛГБТИ хүмүүсийн эрх	44
Хөдөлмөрлөх эрх	44
Орон байртай байх, усаар хангагдах болон эрүүл мэндээ хамгаалуулах эрх	45
Терроризмтэй тэмцэх үйл ажиллагаа ба аюулгүй байдал	45
Цаазаар авах ял	46
Зэвсэгт мөргөлдөөн	46
Ял шийтгэлгүй үлдэх	48

ӨМНӨХ ҮГ

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдаад 70 жилийн ой болж буй энэ өндөрлөгөөс харахад заяамал эрхээ эдлэх бүрэн баталгаа өнөөдөр хүртэл бидний хэнд ч алга байна”

САЛИЛ ШЕТТИ, ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

2017 оны турш дэлхий даяар ад үзэх, адлах бодлого дэлгэрч, гашуун үрийг нь сая сая хүмүүс амсаж байна. Мьянмар улсын цэрэг Рохинга нутгийн хүн зоньг аймаглан устгасан хядлага, түүний уршиг нь үүнийг тод томруун харуулж байна. Үүнээс болж, хөрш Бангладеш улс руу долоохон хоногийн дотор 620 000 хүн дайжин очсон нь дүрвэгсдээс болж тохиосон 2017 оны хамгийн том хямрал болов. Энэ явдлын уршиг ужгирсаар байгаа боловч дэлхийн олон удирдагч асуудлыг оновчтой шийдэж чадахгүй мунгинасаар, он улирах энэ мөчид ч байдал дээрдэнэ гэх найдвар харагдахгүй л байна.

Олноор нь хэрцгийлсэн гэмт хэрэг гарах хөрсийг арилгаж чадалгүй, сүйрэлд хүргэсэн жишээ болж энэ үйл явдал дэлхийн түүхнээ тэмдэглэгдэв. Мьянмарт ийм зүйл тохиолдох дохио эртнээс илэрч байсан. Апартейд тогтсон энэ нийгэмд хажиглах, гадуурхах явдал хэвийн үзэгдэл болж, Рохинга нутгийн хүн зоньг нийтээр нь олон жил адлаж, хүн шиг амьдрах наад захын нөхцлийг олгож байсангүй. Хажиглах, адлах явдал олныг хамарч хядлага болон даамжирахыг бид өмнө нь ч харамсан харж байсан, уршигийг нь арилгах амаргүй гэдгийг ч мэднэ.

Рохингад болсон шударга бус явдал 2017 онд тод томруун илэрсэн ганц тохиолдол төдий бөгөөд улстөрчид адлах үзлийг дэвэргэн, хэсэг хүнийг онцлог шинжээр нь хажиглах явдал дэлхий даяар ажиглагдах болов. Адлах бодлого ердийн хэрэг болбол хүний эрхийг ноцтой хөсөрдүүлдэг болохыг өнгөрсөн жил бидэнд дахин санууллаа.

2018 он гарч, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдаад 70 жилийн ой болж буй энэ өндөрлөгөөс харахад заяамал эрхээ эдлэх бүрэн баталгаа өнөөдөр хүртэл бидний хэнд ч алга л байна. Засгийн газраа шүүмжлэх буюу эсэргүүцэх гэж цуглах эрх чөлөө маань баталгаажаагүй байна. Бид хөгширч, чадваргүй болох үедээ нийгмийн хамгаалал хүртэж чадахгүй, үр хүүхэд минь цэвэр, амьсгалах агаартай хотод өсөж, залуус нь сургуулиа төгсөөд орон байраа худалдаж авах ажилтай ч болж чадахгүй байна.

Хүний эрхийн төлөө тэмцэл хаана ч хэзээ ч төгс ялж байсангүй. Урагшлах тусам хүрэх газар маань алсалж, солигдож, хэзээ ч бид очих газраа очиж байсангүй. Хүний эрхийн түүх ч хаа хүрэх нь тодорхойгүй хэвээр үлдэх биз ээ. Гэхдээ л, хүн төрөлхтөн элдэв шинэ сорилт, бэрхшээлтэй дэлхий даяар тулгарч байсан ч шударга ёс, нэр төр, тэгш эрхийн төлөөх эрмэлзэл нь огт бөхөж байсангүй, харин ч энэ эрмэлзлийнхээ төлөө зүтгэн, хатуу төлөөс удаа дараа төлж байсан ч шантралгүй, ахин дахин зүтгэсээр байна. Энэ үнэ цэнийн төлөөх эрмэлзэл 2017 онд бүр ч хүчтэй бадамласан.

Хүний эрхийн наад захын үнэ цэнийг — хүн бүр нэр төртэй, эрх тэгш гэдгийг хүртэл — үгүйсгэх явдал дэндүү газар авлаа. Олон улсын зэвсгийн наймаа элдэв зэвсэгт мөргөлдөөнийг улам дэвэргэж, хоморгондоо энгийн номхон хүн амыг санаатайгаар хядах явдал нэмэгдсээр байна. Йеменд хүмүүнлэгийн хувьд сүйрэл болж, Саудын Арабын хориг арга хэмжээ түүнд нь нэрмээс болж байхад ч; Ирак болон Сири улсыг самарч байгаа Исламын улс гэж өөрсдийгөө өргөмжилсөн зэвсэгт бүлэглэл энгийн хүн амаар бамбай хийж, олон улсын нэгдсэн хүчнийхэн түүнийг нь мэдсээр байж автгайруулан хядаж байхад ч; Өмнөд Суданд олон улсын шуулийг зөрчиж, энэ гэмт хэргээс үй олон хүн дүрвэж байхад ч — мөргөлдөөнд оролцож байгаа нэг ч тал энгийн иргэнийг хамгаалах үүргээ биелүүлсэнгүй, биелүүлэх гэж

оролдсон ч үгүй.

Тив дамнансан дүрвэгсдийн урсгал чинээлэг орнуудын нийгмийг нэрвэж, энэ хямралыг зохистой шийдэхээс удирдагчид нь зайлсхийж, дүрвэгчийг эрх төгс хүн гэж үзэлгүй, асуудал таригч хэмээн хажиглаж байна. АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп зарлиг гаргаж, хүн амын олонх нь исламын шашин шүтдэг хэд хэдэн улсаас ирсэн хүмүүсийг иргэнийх нь харьяалаас болж хил нэвтрүүлэхийг хориглосон. Энэ бол эрээ цээргүй, илт гадуурхсан үйлдэл мөн. Европын ихэнх орны удирдагч сорилт бэрхшээлтэй нүүр тулан, дүрвэгсдийн хямралыг хууль ёсны дагуу тайван замаар шийдэх гэж хичээсэнгүй, харин ч бүр Европ тивийн хаяанаас холхон зайлуулахын тулд юу ч хийхэд бэлэн байна. Ливийн дүрвэгсдийг хэлмэгдүүлсэн балмад явдал нь асуудлыг мэдсээр байж юу ч хийхийг хүсээгүй Европын удирдагчдын увайгүй хандлагын уршиг гарцаагүй мөн.

Европ, Африкийн зарим орны сонгуулийн үеэр үзэн ядах, айдас төрүүлэх явдал аюултай түвшинд очив. Австри, Франц, Герман, Голландад зарим нэр дэвшигч нийгэм, эдийн засгийн бүхимдлыг цагаач, дүрвэгч, шашны цөөнх рүү чиглүүлж, нийгэмд айдас, жигшүүр төрүүлэхийг эрмэлзэж байв. Кени улсад 8, 10 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгууль үндэстний гарал зэргээс үүдсэн хүчирхийлэл, сүрдүүлгээр дүүрэн байлаа.

Эрхийнхээ төлөө, даян дэлхийд тогтоосой гэсэн үнэ цэнийнхээ төлөө тэмцсэн хүмүүсийн мохошгүй хүслийг 2017 он мөн харууллаа. Шинэ шинэ, ширүүн ширүүн занал, сорилт эсэргүүцлийн галыг ч өрдөж байна. Польш улсад шүүх байгууллагын хараат бус байдалд халдах гэсэн ноцтой оролдлогыг эсэргүүцэж, гудамж дүүрэн хүн жагсаав. Зимбабве улсад, 11-р сард мянга мянган хүн жагсаж, ганц овгор улстөрд давамгайлж 10 гаруй жил ноёрхсоныг эсэргүүцэж, хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж болохуйц шударга, жинхэнэ сонгууль 2018 онд явуулахыг шаардав. Энэтхэг улсад лалын шашнаас жийрхэж (исламофобия), лал болон далит шашинтныг зоргоороо хөнөөдөг болсон явдлыг хүмүүс эгдүүцэн жагсаж, “Миний нэрийн өмнөөс лав биш” хэмээн хашгирч байв. Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр болсон жагсаал АНУ-д төвлөрч, бусад хэд хэдэн оронд салбарласан нь түүхэнд хамгийн том эсэргүүцлийн жагсаал боллоо. #MeToo (Би ч бас) үзэгдэл бэлгийн хүчирхийлэл, хавчлага аймшигт түвшинд очсоныг дэлхий дахины анхааралд аваачсан юм.

Гэхдээ, шударга бус явдлын эсрэг дуугарсны төлөөх төлөөс нэмэгдсээр байна. Турк улсад 2016 онд төрийн эргэлт нурснаас хойш иргэний нийгэм рүү балмад, дур зоргоор халдан, Туркийн Эмнести Интернэшнлийн даргыг мянга мянган хүний хамт зайлуулж байна. Хятадад “үндэстний аюулгүй байдал” нэрээр засгийн газрыг шүүмжилсэн байгууллага, хувь хүмүүсийг урьд байгаагүй ихээр хавчиж байна. Орос даяар өрнөсөн эсэргүүцлийн дараа жагсаалд оролцсон, хажууд нь зогссон, сурвалжилсан гэх мэт зуу зуун хүнийг хоморголон баривчилж, тэднээс олон хүнтэй зүй бус харьцаж, зоргоороо саатуулж, шударга бусаар шүүж, хүнд торгууль оноожээ. Африкийн орнуудад олон нийтийн эсэргүүцлийг ихээхэн дарамтлах болсон нь цочирдмоор байна. Ангол, Чад улсад зоргоороо шууд хориглож, БН Ардчилсан Конго Улс, Сьерра Леон, Того, Уганда улсад хүч хэрэглэн тараалаа. Венесуэлд инфляц нэмэгдэж, хүнс, эмнэлгийн хэрэгсэл дутагдаж, үүнийг эсэргүүцсэн өргөн олны тэмцлийн хариуд аюулгүйн хүчнийхэн зуу зуун хүнийг дур зоргоороо саатуулж, олон хүнийг хүч хэтрүүлэн хэрэглэж зовоолоо. Египетэд эрх баригчид ТББ-уудыг хаах, хөрөнгийг царцаах, засгийн газрын зөвшөөрөлгүйгээр судалгаа хэвлэвэл 5 жил хорих ялаар шийтгэх, сэтгүүлч, улс төрийн сөрөг хүчнийг хорихоор яллах зэрэг хууль батлан засгийн газрыг шүүмжлэх эрх чөлөөг эрс хумьж байна. Оны эцсээр 2009 оноос хойш анх удаа улсынхаа улстөрийн үндсийг шинэчлэх (anti-establishment) хөдөлгөөн Иранд гарав. Аюулаас хамгаалах хүчин галт зэвсэг, хүч хэтрүүлэн хэрэглэж зэвсэггүй жагсагчдыг хороож, шархдуулсан тухай мэдээлж байна. Зуу зуугаараа баривчлагдаж, эрүү шүүлт, зүй бус харьцаан дор хоригдож байна.

2018 он хүний эрхийн төлөө зогссон хүн бүрийг хамгаалах, дэмжих, урамшуулах тухай заасан Хүний Эрхийг Хамгаалагчдын тухай тунхаглалыг НҮБ санал нэгтэй

баталсны 20 жил болно. Хорин жил өнгөрсөн хэдий ч хүний эрхийг хамгаалсан хүмүүс хамгийн хатуу харгислалыг амсаар байна. Нобелийн энх тайвны шагналт, Хятадын зохиолч Лью Шиаобо 2017 онд эмгэнэлтэйгээр үрэгдсэн явдал улс улсын засгийн газар хүний эрхийн хамгаалагчийг төдийлөн таашаахгүй байгаагийн илэрхийлэл болов. Тэрээр элэгний хавдраас болж, хорионд байхдаа 7-р сарын 13-нд өнгөрсөн бөгөөд Хятадын засгийн газар эмнэлгийн тусламж үзүүлэхээс татгалзсан юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах, терроризмтэй тэмцэх тухай хүүрнэж, үүнийгээ хүний эрх, эрх чөлөөгөөр төрийн эрх мэдлийг хязгаарлан тэнцүүлдэг зарчмыг цуцлах шалтаг болгож, бусармаг үйл ажиллагаагаа зөвтгөх гэж засгийн газрууд оролдож байна. Террорист халдлага, хүчирхийлсэн үйлдлээс иргэнээ хамгаалах явдал төрийн үүрэг зайлшгүй мөн. Гэхдээ энэ үүргээ хүний эрхийг хамгаалж биш, хязгаарлаж хэрэгжүүлж байна. Аюулгүй байдал гэдэг Европт бараг л байнгын асуудал болж уруудах шинжтэй. Франц улсад онц байдлыг 11-р сард цуцалмагц терроризмын эсрэг шинэ хууль хүчин төгөлдөр болж, энэ хуулиар онц байдлын үеийн олон заалтыг тайван цагт ч хэрэглэхээр болжээ.

Хүний эрхэд ийнхүү илэрхий халдан заналхийлж байгаа ч хүний нэр төр, тэгш эрхийн үнэ цэнийн төлөө бид дэлхий даяар тэмцэж, “дарангүй төр - дэг журамтай хүн” гэсэн хялбаршуулсан ямар ч тэнцэтгэлийг үргэлж эсэргүүцнэ. Олон нийт өнөөдөр улстөржсөн хоёр туйл руу татагдаж байна. Польш, АНУ-д хүний эрхийг хамгаалах явдлыг дордуулахгүй байхыг уриалж зарим нь жагсаж байхад Варшавт фашистууд, Шарлотсвилд арьсны үзэлтнүүд жагсаж хүний эрхийг хамгаалахын эсрэг ярьж байна. Тодорхой бүлэг хүнийг гадуурхах, хүний эрхийг нь үгүйсгэх харгис бодлогыг зарим оронд нийтээрээ дэмжих болов.

Хамгийн чухал олон нийтийн орон зай маань өнөөдөр ихэнхдээ онлайн орчинд оршиж байгаа боловч тэнд тэмцлийн боломж хязгаарлагдмал, шинээр үүсч буй сорилтуудыг шийдэхэд хүрэлцэхгүй байна. Ялангуяа эмэгтйчүүдийг, нийгмийн цөөнхийг ад үзсэн, турхирсан онлайн хүчирхийллийн шуурганд социал мэдээллийн компанийн армаг сармаг хариу, засгийн газрын аргацаасан арга хэмжээ нөлөөлж чадахгүй байна. “Худлаа мэдээ”-г ашиглан олон нийтийн үзэл бодолд хэрхэн нөлөөлдөг тухай 2017 оны турш ярилцсан. Үнэн, үлгэр хоёрын ялгааг бүдгэрүүлэх технологийн чадал ирээдүйд нэмэгдэх хандлагатай байна. Энэ байдал хүмүүс үнэн зөв мэдээлэл авахад ноцтой бэрхшээл үүсгэнэ. Үүнээс гадна, онлайн орчинд хүмүүс үзэж байгаа мэдээллийг цөөн хэдхэн компани зонхилон төвлөрүүлсэн бөгөөд асар их мэдээллийг эзэмшиж байгаа компани, засгийн газрын түншлэл, тэдгээр мэдээллийг үзэж байгаа хувь хүн хоёрын хооронд тэгш харьцаа огт үүсэхгүй билээ. Олон нийтийн бодол санаанд нөлөөлөх боломж, бололцоо ч өөр өөр байх нь дамжиггүй, үнэндээ ад үзэх, хүчирхийлэлд уриалсан мэдээллийг хяналтгүй тарааж, ашиглах өргөн боломж төрд бүрэн байна.

2018 оны 12 дугаар сард тохиох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 70 жилийн ой дөхөж буй энэ үед ирээдүйн сорилт тодорхой байна. Хүн бүр нэр төртэй, эрх тэгш тухай үзэл санааг өргөх, үнэ цэнийг нь нандигнах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тэдгээрийг баримтлахыг шаардах явдалд энэ сорилтын зорилго оршино. Адлах бодлого хүмүүсийг зохиомлоор хувааж, дунд нь хана босгож, хооронд нь хэмлэлдүүлж, өөрөөсөө бусдыг үл ойшоож, бусдын гасланг хонжиж харанхуй руу хүн төрөлхтнийг хөтөлнө. Дэлхийн олон удирдагч завшаан хайж, өрөөсгөл бодлого томъёолж, өөр боломжийг төсөөлж ч чадахгүй байна.

Үүнийг өөрчлөх цаг боллоо. Адлах үзлийн хүүрнэлд автахгүйгээр эвлэх соёлыг бүтээх ёстой. Бусдад өгөөмөр зангаа дэлгэх хэрэгтэй. Өөрийнхөө амьдрах нийгмийг өөрөө оролцон байгуулах эрхтэй, бүх хүний энэ эрхийг бид тэтгэх ёстой. Буруутныг хайсан бухимдал, хилэн жийрхэн адлах бодлогын үндэс болж байгааг анхаарч, тэдгээрийг сэнхрүүлж, хүний эрхийг дээдэлсэн бодлогын оновчтой хариулт бодож олох ёстой.

Ямар нийгэмд амьдармаар байгаагаа өөрөөсөө асууж, хүний эрхийн үзэл санаанд итгэл төгс байгаагаа дахин нотлох чухал боломж хойтон бидэнд тохионо. Энэ тохиолыг бид адлах учиргүй.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ази, номхон далайн бүсийн хүний эрхийн асуудал нь ихэвчлэн засгийн газрын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байна. Гэсэн хэдий ч нөгөө талд нь хүний эрхийн хамгаалагч, идэвхтнүүдийн хөдөлгөөн хүчтэй өрнөн тэлж байна.

Олон оронд иргэний нийгмийн орон зай улам бүр хумигдлаа. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэзээ ч байгаагүйгээр дарангуйлж буй Хятадаас эхлээд олон ургальч үзлийг нухчин дарах гэсэн Камбож, Тайланд хүмүүсийг хүчээр ор сураггүй болгож буй Бангладеш, Пакистан гээд хаа сайгүй төрийн зүгээс хүний эрхийн хамгаалагч, хуульч, сэтгүүлч болон бусад хүмүүст дарамт шахалт үзүүлж байна.

Шийтгэл, хариуцлагаас мултрах явдал хавтгайрсан нь Мьянмар, Афганистан зэрэг оронд хууль бус аллага, эрүүдэн шүүлт гэх мэт хэрцгийллийг өөгшүүлж, сая сая хүмүүсийг хохирлоо төлүүлэх аргагүй болгож, хүн төрөлхтний эсрэг болон дайны гэмт хэрэг гарах үндэс болсоор.

Дэлхийн дүрвэгсдийн хямрал улам гүнзгийрэв. Энэ бүс нутгийн хэдэн зуун мянган иргэн гэр орноосоо зугтаж, цаашид улам л эрхээ зөрчүүлэхээр байна. Мьянмарын цэргүүд хойд Рахине мужид хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэнээр дүрвэгсдийн тоог улам хөөрөгдсөн юм. Тэд Рохинга иргэдийн тосгоныг түймэрдэж, томчууд хүүхдүүдийг алж, эмэгтэйчүүд, охидыг хүчирхийлсэн билээ. Энэ хэрцгийллээс болж 655,000 Рохинга амар тайвныг эрэн Бангладеш руу зугтсан. Үлдсэн хэсэг нь амьдралынх нь бүх нөхцөлийг боомилж, нийгмээс үндсэнд нь тусгаарласан алагч тогтолцоонд амьдарсаар байна.

2017 оны байдлаар Филиппинээр удирдуулж буй АСЕАН-ын 50 жилийн ой энэ жил тохиож байгаа билээ. Харин АСЕАН-ын орнууд Филиппин, Мьянмар тэргүүтэй улсуудад болж байгаа аймшигт хэрцгийллийг дуугүй харсаар байв.

Энэ бүх уналтын эсрэг Ази, Номхон далайн бүс нутагт хүний эрхийг хүндлэх, хамгаалах санаачилга, дуу хоолой ялангуяа залуусын дунд улам нэмэгдэж байгаа нь итгэл найдвар төрүүллээ. БНСУ (Өмнөд Солонгос)-т корпорацийн хариуцлагыг сахиулах тал дээр, Тайваньд гэр бүлийн гишүүдийн эрх тэгш байдлын тухайд, Энэтхэгт хувийн орон зайтай байх эрхийн тухай асуудалд ахиц дэвшил гарсан нь харагдаж байна.

ЗҮҮН АЗИ

Япон, Монгол, Өмнөд Солонгосын эрх баригчид хүний эрхийн төлөө тэмцэгчдийг зохих ёсоор хамгаалж чадсангүй. Ялангуяа Хятадад хүний эрх хамгаалагчид аюултай нөхцөлд байна. Иргэний нийгмийн орон зай Хятадад мэдэгдэхүйцээр буурч, цаашлаад Хонг Конг, Японд ч яах бол гэсэн айдас төрүүлж байгаа юм. Иргэний нийгэм болон эрдэмтэд ихээхэн шүүмжилсээр байхад "терроризм" болон бусад ноцтой гэмт хэрэгт чиглэсэн маш өргөн агуулгатай хууль парламентаас баталсан нь хүний эрхийн төлөө тэмцлийг сулруулсан шийдвэр болов. Энэ хуулийн дагуу эрх мэдэлтнүүд өргөн хүрээнд хянах боломжтой болсон нь хүний эрхтэй зөрчилдөж байна.

Өмнөд Солонгост засгийн газрын өөрчлөлтөөс хамааран тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө бүхлээр нь чөлөөтэй эдлэх боломжийг бий болгохын тулд хэв журам сахиулах аргадаа өөрчлөлт оруулах саналыг үндэсний цагдаагийн газар нь хүлээн зөвшөөрсөн байдаг. Түүнчлэн Өмнөд Солонгост, зуу зуун шударга тэмцэгчид баривчлагдсан ч доод шатны шүүхээс эдгээр тэмцлийн арга хэмжээг авах эрхийг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргасан. Улмаар ажлын байран дахь өвчлөл болон нас баралтанд олон улсын корпорациуд хариуцлага хүлээх ёстойг тодотгосон шийдвэр гаргасан.

Си Зиньпинийг олон жилийн турш Хятадын хамгийн хүчирхэг удирдагч хэмээн тахин шүтсэн нь мэдээллийн болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөргөөр нөлөөлсөн. Хүний эрхийг боох, идэвхтнүүдийг хорих явдлаа "үндэсний аюулгүй

байдал" гэдэг үгээр зөвтгөдөг. Энэ нь Шинжан Уйгурын Автономит Муж (ШУАМ)-д бүс нутгийн Коммунист Намын нарийн бичгийн дарга Чен Чуангуогийн удирдлагаар тагнах техникийг нэмэгдүүлж, гудамжны эргүүлүүд, хяналтын цэгүүдийг зэвсэглэж, хүний эрхийг зөрчсөн хэд хэдэн бодлого хэрэгжүүлэхдээ "нийгмийн тогтвортой байдал" гэсэн шалтгаанаар зөвтгөсөнтэй яг адил арга барил байлаа. Эрх баригчид "Экстремизмийн эсрэг төв", "Улс төрийн судалгааны төв", "боловсролын төв" гэх мэт нэрийн доор ШУАМ-д хорих, саатуулах байгууламжуудыг байгуулж, түүндээ иргэдийг тодорхойгүй хугацаанд, үндэслэлгүйгээр саатуулж, Хятадын хууль журам бодлогыг хүчээр судлуулдаг байжээ.

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсын иргэд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлогдсон хүний эрхийн ноцтой зөрчилд өртсөөр байна. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө хаагдмал бөгөөд албадан хөдөлмөр эрхлэлт, эрүү шүүлт, зүй бусаар харьцах явдлын үүр уурхай болсон улс төрийн хорих лагерт 120,000 гаруй хүн үндэслэлгүй хоригдож байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Хятадын эрх баригчид үндэслэлгүй баривчилгаа, саатуулалт, хорио, эрүү шүүлт, зүй бусаар харьцах зэргийг аймшиггүйгээр ашиглан хүний эрхийн хуульчид, идэвхтнүүдийг нухчин дарах оролдлого өмнө байгаагүй хэмжээнд хүрэв. "Тодорхойлсон байршилд оршин суух газрын хяналт хийх" гэдэг үндэслэл нь цагдаа нар т хувь хүнийг саатуулах эрхгүйн үндэслэлээс гадуур, өмгөөлөгч, гэр бүлийнхэн болон бусадтай харьцах боломжгүйгээр зургаан сар хүртэл хугацаанд хорих явдал нь эрүү шүүлт болон бусад хэрцгий байдалд оруулж буй эрсдэлийг бий болгож байна. Энэ төрлийн саатуулах аргыг хуульчид, идэвхтнүүд, шашны зүтгэлтнүүд гэх мэт хүний эрхийн хамгаалагчид дээр ашигласаар иржээ.

Бээжин хотын нийслэл Тянь Ань Мэн талбайд 1989 оны 6 дугаар сарын 3-4-ний хооронд Ардын Чөлөөлөх Арми зэвсэггүй иргэд рүүгээ гал нээж, мянгаар биш юмаа гэхэд зуугаар тоологдох тэмцэгчид амь насаа алдсан буюу хүндээр гэмтсэн үйл явдлын дурсгалыг хүндэтгэх, сэргээх гэсэн хүмүүсийг баривчилсан хэвээр байна. Нобелын Шагналт Лью Шиабо долдугаар сард хорионд байхдаа нас баржээ.

Хүчээ авсан Ардчилалын төлөөх хөдөлгөөний хүмүүст хилс хэрэг тулгасан нь эрх баригчдын зүгээс ардчиллыг дэмжиж, эрх баригчдыг сөрсөн нэгнийг шийтгэж, анхааруулга өгөх арга байсан нь харагдаж байна.

ИРГЭДИЙН НҮҮДЭЛ

Япон улсад орогнол хүссэн иргэдийн тоо нэмэгдсээр байна. Япон улсын засгийн газар 2-р сард хийсэн мэдэгдэлдээ 2016 онд орогнол хүссэн 10,901 хүнээс 28-ийг нь хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь өмнөх оныхтой харьцуулахад 44 хувиар нэмэгдсэн гэжээ. Үүний зэрэгцээ ажиллах хүчний хэрэгцээг хангахын тулд хөдөлмөрийн цагаачлалын хөтөлбөрийн дагуу Вьетнамаас гурван жилийн дотор авах 10,000 ажилтнуудын эхний ээлжийг оруулж ирсэн нь хүний эрхийн олон янзын зөрчилд хүргэж байгааг хүний эрхийн хамгаалагчид шүүмжилсэн байдаг.

Өмнөд Солонгост цагаач ажилтнууд нас барж байгаа нь ажлын байрны аюулгүй байдлын асуудлыг хөндөхөд хүргэсэн. Хэдий зарим орон тус улсын пуужингийн туршилтын эсрэг НҮБ-аас Хойд Солонгосын эдийн засгийн үйл ажиллагаанд тавьсан хоригийн дагуу Хойд Солонгосын иргэдийн ажлын визийг сунгах, шинээр олгохыг зогсоогоод байгаа ч Хойд Солонгосоос Хятад, Орос руу ажиллагсад илгээсээр байна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Хятадын хувьд ШУАМ болон Түвд иргэд амьдардаг газруудад шашны дарлал маш ноцтой хэвээр байна. Өмнөд Солонгост ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал зонхилсоор байна. Цэргийн алба хаах үед гей хүмүүсийг дээрэлхэх, үг хэлээр

доромжилдог байна. Мөн нэг сонсогчийг ижил хүйстэнтэйгээ бэлгийн харьцаанд орсон гэх үндэслэлээр буруутгажээ.

Жинхэнэ бөгөөд хийсвэр бэлгийн чиг баримжаа, жендэрийн тодорхойлолтоосоо болж алагчлагдах явдал Японд хэвээр боловч орон нутгийн хэмжээнд зарим ахиц гаржээ. Осака хотод анх удаа ижил хүйстэй хосод хүүхэд үрчлүүлэх шийдвэр гарч, өөр хоёр мужид ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх тал дээр нааштай өөрчлөлт болов.

Тайваний дээд шүүхийн нэгэн онцгой шийдвэр нь тус улс Азидаа анх удаа ижил хүйстний гэрлэлтийг зөвшөөрсөн улс болж, бүс нутагтаа ЛГБТИ эрхийн түүхээ болох магадлалыг бий болголоо. Шүүгчид тус улсын гэрлэлтийн тухай хууль нь ижил хүйстэй хосуудыг ялгаварлан гадуурхсанаараа үндсэн хуульд нийцэхгүй гэж үзээд хууль тогтоогчдод энэ асуудлыг хоёр жилийн дотор цэгцлэхийг даалгасан. Тайвань улс одоогоор ижил хүйстний гэрлэлтийг зөвшөөрөх тухай эрхзүйн баримт бичиг дээр ажиллаж байна.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Ялын дээд хэмжээний тухай тоо баримтыг улсын нууцад хамааруулдаг Хятад улс цаазаар авах ял хэрэгжүүлэлтээрээ дэлхийд тэргүүлсэн хэвээр байна.

Тайваний Дээд Шүүхээс Тайваний орчин үеийн түүхэн дэх хамгийн урт хугацаанд буюу 1989 оноос хойш хоригдож байгаа цаазаар авахуулах ялтай Чиоу Хо-Шуний байцаагдаж байхдаа эрүүдэн шүүгдэж, хүчээр хэргээ “хүлээсэн” гэсэн үндэслэлийн дагуу Ерөнхий Прокурорын хэргийг дахин хянах хүсэлтийг буцаасан байна.

Долдугаар сард Монгол улс бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оноохыг зогсоосон дэлхийн 105 дахь орон болсон боловч хүчиндэж, амь насыг хохироосон жигшүүрт гэмт хэргүүдийн дараагаар уг ялыг сэргээх саналыг Ерөнхийлөгч Хууль зүйн яаманд хүргүүлэв.

ӨМНӨД АЗИ

Өмнөд Ази даяар засгийн газрууд шашны цөөнх рүү халдах, үзэл бодлоо илэрхийлэх явдлыг буруутгах, хүчээр ор сураггүй болгох, цаазаар авах ялыг ёс бусаар хэрэглэх, дүрвэгсдийн эрхэд халдах зэргээр хууль ёс, эмх журам, үндэсний аюулгүй байдал, шашин шүтэх эрхийг уландаа гишгэж байна. Ял завших явдал ч хавтгайрчээ.

Өмнөд Ази даяар үзэл бодлоо илэрхийлэх эрх шахалтанд оржээ. “Үндэсний ашиг сонирхол” гэх мэт хоосон ойлголтоор шалтаглан сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагч нар зөвхөн үзэл бодлоо тайвнаар илэрхийлсний төлөө засгийн газрын бай болсоор байна.

Үзэл бодлоо онлайнд илэрхийлэх эрхийг буруутгах шинэ чиг хандлага ч ажиглагдав. Бангладешт блоггерууд зэвсэгт хүчнийг шүүмжлэх эсвэл “Исламын ёсонд нийцэхгүй” үзэл бодолтой байсныхаа төлөө хүчээр ор сураггүй алга болох эсвэл баривчлагдах боллоо. Бангладешийн засгийн газар буюу Ерөнхий Сайдын гэр бүлийг шүүмжилвэл мөн л шууд хэрэг үүсгэж байна. Засгийн газраас Дижитал Аюулгүй Байдлын тухай хууль санаачилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам боогдуулж, ял зэмийг нь ч хүндрүүлэхээр байна. Үүнээс гадна засгийн газрыг шүүмжилдэг хоёр блоггерыг зориудаар ор сураггүй болгожээ. Ази Номхон далайн бүс нутагтаа интернэтийн нэвтрэлт хамгийн бага улс болох Афганистанд кибер гэмт хэргийн тухай хууль гарсан нь үзэл бодлоо илэрхийлэх явдлыг буруутгахаар болсон байна.

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийг хангах тал дээр ч урагш ахисангүй. Пакистан улс хуулиа олон улсын стандартад нийцүүлээгүйн улмаас хүн ам нь ялгаварлан гадуурхалт ажиллагчийн эрхийн доголдол, нийгмийн аюулгүй байдал хангалтгүй нөхцөлд амьдарч байна. Энэтхэг улс хүүхдийн хөдөлмөрийн тухай ОУХБ-ын гол хоёр конвенцийг соёрхон баталсан ч хүүхдийн хөдөлмөрийн тухай хуулиндаа хүүхдийг гэр бүлийн компанидаа ажиллаж болно гэж оруулсныг идэвхтнүүд шүүмжилж байна. Балбад аймшигт газар хөдлөлт болсноос хоёр жилийн дараа түр оромжинд амьдарсаар байгаа, газар хөдлөлтөөс амьд гарсан мянга мянган иргэнийхээ асуудлыг шийдэж чадаагүй л байна.

Аравдугаар сард Пакистан улс хүний эрхийн асуудалд хувь нэмрээ оруулахаа амлан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн гишүүн болсон. Гэтэл хүчээр ор сураггүй болгох, цаазаар авах, буруу номтныг шийтгэх, иргэний хэргийг цэргийн шүүхээр шүүх, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлууд, хүний эрх хамгаалагчдын асуудалд саад болж буй зүйлс гээд өөрийнхөө оронд болж буй хүний эрхийн асуудлуудаа ч шууд шийдэж чадаагүй байна.

Афганистан, Бангладеш, Энэтхэг, Пакистан гэх мэт орнуудад зэвсэгт бүлэглэлүүд хүний амь хороох, хулгайлах гээд олон янзаар хүний эрхийг зөрчиж байна. Афганистанд ялангуяа шашны цөөнхөд хамаарах иргэд аюултай байдалд байна. Пакистанд зэвсэгт бүлэглэлүүд Шийтүүдэд халдаж, Кветта дахь Шийт сүмийг бөмбөгдөн, дор хаяж 18 хүний аминд хүрчээ.

Балбын дотоод сонгуулийг будлиантуулсан түүхэн жишээнээс дурдвал дур зоргоор баривчлах, сонгуулийг эсэргүүцсэн жагсагчид руу аюулгүйн албаныхан гал нээсэн зэрэг байна.

Энэтхэгийн Жамму болон Кашмир мужид аюулгүйн албаныхан парламентын нөхөн сонгуулийн үеэрх жагсаалаас болж найман хүний аминд хүрснээс гадна нэг сонгогчийг армийнхан зодож, цэргийн жийп машины урд хүлээд бусад тэмцэгчдэд анхааруулга болгох маягаар таван цаг гаруй явжээ. Мөн тэдгээр аюулгүйн албаныхан задардаг үрлэн сумаар буудсанаар хэд хэдэн хүнийг хараагүй, эрэмдэг болгожээ.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧИД

Энэтхэг улсад эрх баригчид хүний эрхийн төлөө тэмцэгчдэд илт шүүмжлэлтэй хандаж, тэдний эсрэг таагүй уур амьсгал үүсгэж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дарангуй хуулиар шахаж, сэтгүүлчид, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд дарамт учруулсаар байгаа юм.

Афганистан дахь хүний эрх хамгаалагчдын амьдрал, аюулгүй байдалд зэвсэгт бүлэглэл байнга аюул учруулж, сэтгүүлчид хэрцгийллийн бай болжээ.

Пакистаны эрх баригчид байнгын дарамт, заналхийлэл, өдөөн хатгалга, засгийн газрын бус тоглогчдын дайралтын бай болж буй сэтгүүлч, блогч, иргэний нийгэм, идэвхтнүүдээ хамгаалж чадахгүй байна. Харин ч өнөөх эрх баригчид чамгүй олон ТББ-ын үйл ажиллагаанд хязгаарлалт хийж, олон идэвхтнийг эрүүдэн шүүх, хүчээр ор сураггүй болгох зэрэг дайралтын бай болгосон байдаг.

Бангладешт засгийн газар олон нийтийн хэлэлцүүлэг, шүүмжийг нухчин дарах оролдлого эрчимжүүлжээ. Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг дарамталж, зүй бус хуулиар ял шийтгэл оногдуулж байна. Зарим шашингүй үзэлтэй блоггерийн амь насыг хөнөөсөн ажиллагааг гардан явуулсан зэвсэгт бүлэглэлтэй засгийн газраас хариуцлага тооцож чадсангүй. Идэвхитнүүд байнга амь насанд нь аюул учруулах сүрдүүлэг, улс орныг нь орхиж явах шаардлага дунд амьдардаг.

Мальдивт олон нийтийн мэтгэлцээнийг улам хатуу хорих болов. Эрх баригчид сэтгүүлчид, идэвхтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагуудад дарамт үзүүлж эхэлжээ. Засгийн газарт шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах санаархал байгаа нь илэрхий харагдах болов.

ЯЛ ЗАВШИХ

Өмнөд Азид ял завших явдал хавтгайрч бугшсан байдалтай байна. Харин Балбад дүүргийн шүүхээс 2004 онд 15 настай Майна Сунуварын амь насыг хороосон хэргээр армийн гурван офицерт бүх насаар нь хорих ял оногдуулсан юм. 2006 онд эцэслэсэн Маоистууд болон засгийн газрын хоорондох арваад жилийн тэмцлийн үед тэр охин цэргийн хоригонд байхдаа эрүүдэн шүүгдсэний улмаас амиа алдсан юм. Энэ шийдвэр нь мөргөлдөөний хүнд үеийн зөрчлүүдийг шийдэх хууль зүйн системийн чадавхи сайжирч, хохирогчдод шударгаар хандах эхний дохио болж чадсан.

Энэтхэг улсад Дээд шүүхээс Төв Мөрдөх Товчоонд 1979-2012 оны хооронд Манипур мужид цагдаа болон аюулгүйн албаныхны үйлдсэн гэх шүүхээс гадуур

цаазаар авах ял гүйцэтгэсэн 80 гаруй тохиолдлыг мөрдөх даалгавар өгсөн байна. Он удаан жил болсон нь хэрэг хаагдсан гэсэн үг биш гэж тэд үзсэн юм.

ХҮЧЭЭР СУРАГГҮЙ АЛГА БОЛГОХ ЯВДАЛ

Пакистанд хүчээр сураггүй болгох явдал үргэлжилсээр, хохирогчдыг эрүүдэн шүүх зэргээр зүй бусаар харьцах, улмаар амь насыг нь хохироож байна. Найм, арван нэгдүгээр сарын хооронд Хүчээр сураггүй болгох асуудлаарх өргөдөл хүлээн авах хороонд 300 орчим хэрэг ирсэн байна. Харин сүүлийн жилүүдэд гарсан нийт зуу зуу, магадгүй мянга мянган хэргийн аль нэгэнд нь хариуцлага хүлээсэн хүн одоогоор үгүй байна.

Шри Ланкын засгийн газар зэвсэгт мөргөлдөөний хохирогчдод шударга ёсыг хангах, нөхөн төлбөр олгох, зөрчлөөс сэргийлэх амлалт 2015 онд өгсөн ч ахиц удаан байна. Хүчээр ор сураггүй алга болгох хэрэгт ял завших нь хэвийн үзэгдэл хэвээр. Ганцаарчлан болон нууцаар хорьж саатуулах эрхзүйн үндэслэл болдог Терроризмоос Сэргийлэх тухай хуулиа эргүүлэн татах асуудлаар Засгийн газар хөдлөөгүй ч парламентаас сураггүй болсон хамаатнаа хайхад ар гэрийнхэнд нь туслах зорилготой Сураггүй Болсон Иргэдийн Албаны тухай хууль баталжээ.

Бангладешт хэд хэдэн хүчээр ор сураггүй болгох тохиолдол гарсан бөгөөд хохирогчид нь голдуу улс төрийн сөрөг хүчнийхэн байв.

ИРГЭДИЙН НҮҮДЭЛ

Өмнөд Азийн энд тэнд дүрвэгсэд болон цагаачдын эрх боомилогдсон байдалтай байна.

Мьянмарт болсон үндэстний цэвэрлэгээнээс зугтаж ирсэн Рохинга гаралтай 655,000 иргэнд Бангладеш хилээ нээсэн. Гэвч хэрэв тэдгээр Рохинга иргэдийг Мьянмар руу хүчээр буцаалаа гэхэд өнөөх л цэргүүд угтах бөгөөд тэдний оршихуйг эмзэг болгох хэмжээнд хүрсэн ялгаварлан гадуурхалт, тусгаарлах үзэл бугшсан системдээ эргэж очихоор байна.

Афганистаны дотоодын дүрвэгсдийн тоо 2 сая, харин улсаас гадна оршиж буй Афгани дүрвэгсдийн тоо 2.6 сая орчим болжээ.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Өмнөд Азид олон ургальч үзэлтнүүд, шашны цөөнхийн гишүүд олон нийтийн дайралтанд өртөх аюул өндөр байна. Энэтхэгт Лалын шашинтнуудын дур зоргоороо шүүсэн хэд хэдэн тохиолдол гарсан нь Хинду үндэсний үзэлтэй засгийн газрын үйл ажиллагааны үрээр бүрэлдэж буй исламафобиагийн эсрэг урсгалд хүч нэмэв. Хэд хэдэн хотод Лалуудад халдаж байгааг эсэргүүцсэн хөдөлгөөн өрнөсөн ч засгийн газраас энэ асуудлыг няцаасан, буруутгасан ямар ч үйлдэл хийсэнгүй.

Энэтхэгийн уугуул Адиваси иргэд аж үйлдвэрийн төслүүдээс болоод төрөлх газраасаа хөөгдсөөр байна.

Бангладешт шашны цөөнхөд халдсан тохиолдлуудад Засгийн газар бараг буруу хараад өнгөрөх болов. Аюул заналд өртмөгцөө эрх баригчдад хандсан хүмүүсийн асуудлыг шийдэлгүй буцааж байна.

Христийн болон Лалын шашинтнуудад халдах зэргээр илэрч буй Буддын шашны үндэсний үзэл Шри Ланкад давамгайлж ирэв. Сөрөг хүчний гишүүдэд халдах, цаазаар авах ялыг сэргээх төлөвлөгөө зэрэг дарангуй арга хэмжээгээ шашнаар зөвтгөж байна.

Хүйс, шашин, яс үндэс, бэлгийн чиг баримжаа илэрхийлэл, жендэрийн тодорхойлолтоосоо болж гадуурхагдсан нийгмийн бүлгүүдэд Пакистаны хууль, бодлого, түүний хэрэгжүүлэлт тэгш бус үйлчилдэг. "Номлогч Мухаммедын эсрэг буруу номлол"-д цаазаар авах ял оноодог Пакистаны хууль нь олон эрхийг шууд зөрчиж байгаа юм. Энэ хууль нь шашны цөөнхүүдэд тэгш бус үйлчилж, энэ хуулиар буруутгагдсан тохиолдлууд нь голдуу үндэслэлгүйгээс гадна олон улсын хүний эрхийн хуулийг зөрчсөн байдаг. Нэг хүн Фэйсбүүктээ "буруу номын" гэгдэх зүйл бичсэнээсээ болоод цаазаар авах ял авсан нь одоогоор цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудалд өгөгдсөн хамгийн их хэмжээний ял юм.

ЖЕНДЭРИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Талак (гэр бүл шууд салах Лал ёс) ёсыг Энэтхэгийн Дээд Шүүхээс хориглосон ч шүүхийн бусад шийдвэр эмэгтэйчүүдийн эрхийг боогдуулсаар байна. Гэрлэлтийн асуудал хүний эрхийн зөрчилд хүргэхээс эмэгтэйчүүдийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлийг Дээд Шүүхээс сулруулсан. Хүчингийн хэргийн хохирогч эмэгтэйчүүд Энэтхэгийн хуулийн дагуу 20 долоо хоногоос хэтэрсэн ургаа авахуулах хүсэлтээр шүүхэд хандахад заримыг нь зөвшөөрчээ. Төв засгийн газраас мужуудад ийм хэргийг шуурхай шийдэхийн тулд байнгын эрүүл мэндийн зөвлөл байгуулах чиглэл өгсөн байдаг.

Пакистанд тосгоны зөвлөл гэх этгээдүүд ахын үйлдсэн хүчингийн хэрэгт "хариу" болгож дүү охиныг хүчирхийлэх шийдвэр гаргасан нь үүнтэй төстэй аймшигт зүйлсийн зөвхөн нэг нь байв. Тэр зөвлөлийнхөн хүчингийн хэрэгт турхирснаараа баривчлагдсан ч эрх баригчид бэлгийн хүчирхийллээс ял завших явдлыг эцэслэх, энэ мэт "хариу" авах шийдвэр гаргадаг тосгоны зөвлөл гэдэг зүйлийг алга болгох тал дээр хангалтгүй ажиллаж байна. Мөн ижил хүйстний харилцаа Пакистанд хууль бус хэвээр.

Афганистанд эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл буурсангүй. Харин ч Шариа хуулийн нэрээр зэвсэгт бүлэглэлүүдэд олон нийтийн өмнө шийтгэгдсэн эмэгтэйчүүдийн тоо өссөн тухай мэдээ байна.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Улс төрийн хямрал улам гүнзгийрч байгаа үедээ Мальдивын эрх баригчид 60 жил ашиглагдаагүй цаазын ялыг сэргээх тухай ярьж эхэлжээ. Энэ оны эцсийн байдлаар хэрэгжүүлсэн тохиолдол хараахан үгүй байна.

Шүүхээс олон улсын хуулийг зөрчин сэтгэцийн өвчтэй хүмүүс болон 18-аас доош настай хүмүүст цаазаар авах ял оноосон.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Афганистанд нөхцөл улам дордсоор байна. Энгийн иргэд амь насаа алдах нь ихэсч, дотоодын нүүдэл гаарч, Талибанчууд 2001 оноос хойш хамгийн ихээр хүчээ авч, ихээхэн хэмжээний газар нутгийг хяналтандаа байлгах болов. 2014 оноос хойш Пакистан, Иран, Европын Холбооны орнуудаас хэдэн арван мянган Афганичууд хүчээр нутаг буцсан байдаг.

Иргэдийн гачигдалд Афганистаны засгийн газар ч, олон улсын нийгэмлэг ч төдийлөн анхаарал хандуулахгүй байна. Тавдугаар сарын 31-нд Кабул хотыг бөмбөгдөж 150 хүний амь эрсдэж, хэдэн зуун хүн шархадсан аймшигт хэргийн дараа энэхүү хэрцгийлэл, аюул заналын эсрэг тэмцэл хийсэн жагсагчдын өөдөөс аюулгүйн албаныхан гал нээж, хэд хэдэн жагсагч амиа алджээ.

Нааштай өөрчлөлт гэвэл Олон Улсын Эрүүгийн Шүүхийн прокуророос Афганистанд болж буй зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын үйлдсэн байж болзошгүй гэмт хэргийг шалгах урьдчилсан мөрдлөг явуулах санал гаргасан. Энэ шийдвэр нь 2003 оноос хойших олон улсын хуулийн зөрчилд хариуцлага тооцох, хохирогчдыг үнэн мөн, шударга ёсоор хангах, нөхөн төлбөр олгуулахад чухал алхам болсон юм.

ЗҮҮН ӨМНӨД АЗИ БА НОМХОН ДАЛАЙ

Хүний эрхийг хүндэлж, зөрчилд хариуцлага хүлээлгэхийг шаардсан хэн ч жигшигдэн, буруутгагдаж улмаар иргэний нийгмийн орон зайг хумиж байна. Цагдаа, аюулгүйн албаныхан хүний эрхийн хамгаалагчдыг хавчин шахсаар байгаа аж. Ял завших явдал хэвээр учир шүүхийн бус аллага, эрүү шүүлт болон зүй бусаар харьцах, зориудаар ор сураггүй болгох хэргүүд улам хавтгайрч байна.

Мьянмарын аюулгүй албанаас хойд Рахине мужийн Рохинга иргэдийн эсрэг хэрцгийлэх ажиллагаа явуулсан нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн хэмжээнд хүрч, тус улс болон хөрш Бангладеш улсад хүний эрхийн болон хүмүүнлэгийн гамшиг нүүрлэв.

Филиппинд хууль ёсыг үгүйсгэж, хэрцгийлэл улам газар авчээ. Ерөнхийлөгчийн "хар тамхитай хийх дайн" нь хүний эрхийг уламдаа гишгэж, хоморголон устгах хэлбэрт орлоо. Үүндээ голдуу буурай болон гадуурхагдсан бүлгийг сонгодог ба хүүхдүүдийг ч ялгадаггүй. Энэ аллагын цар хүрээ, ял завшиж буй байдлаас харахад үүнийг олон улсын түвшинд мөрдөх шаардлагатай болоод байна. Арван хоёрдугаар сард өмнөд Минданао аймагт зарласан онц байдлыг сунгаснаар цаашлаад хүний эрхийн зөрчилд цэргийн дэглэмийг шалтаг болгох вий гэсэн сэжиг төрүүлж байгаа юм. Мөн энэ улс цаазаар авах ялыг сэргээхээр ажиллаж байна.

Индонез улсад хар тамхины наймааны сэжигтнүүдийг цагдаа нар хороох явдал огцом өсөв.

Орогнол хайгчид, дүрвэгсдэд хэрцгий, хүний ёсноос гажууд, доромж байдлаар харьцсанаараа Австрали улс хүний эрхийг сахиж чадахгүй байгаагаа харууллаа.

Зүүн Өмнөд Ази, Номхон далайн орнуудын засгийн газраас эдийн засаг, нийгэм соёлын эрхийг хамгаалах тал дээр хангалтгүй ажиллаж байна. Лаос улсад тосгоны иргэд бүтээн байгуулалтаас болоод байршлаа солих шаардлагатай болжээ. Камбож улсад орон байртай байх эрх нь газрын наймаанаас болон хохирч байна. ТББ-уудаас Сингапур улсад ажиллаж буй гадаадын ажилчдын орон байрны асуудал тун хэцүү гэж дүгнэсэн байдаг.

Папуа Шинэ Гвиней улсад үндэсний сонгууль нь хээл хахууль, хэрцгийлэл, дур зоргоор баривчлах зэрэг эрх баригчдын хүч хэрэглэлтэн дунд болж өнгөрөв.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Хүний эрхийн хамгаалагчид, тайван замаар улс төрийн тэмцэл хийж буй идэвхтнүүд, шашны дагагсдыг үндэслэлгүйгээр саатуулах зэрэг зөрчлийн хохирогч болж байна. Тэдэнд тааруухан найруулсан, ойлгомжтой хэрэг тулгаж, олон улсын шударга ёсны хэм хэмжээнд нийцээгүй шүүн таслах ажиллагаагаар ял оноожээ. Үзэл бодлоосоо болж хоригдож буй хоригдлуудыг эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр тэдэнтэй зүй бус харьцаж байна.

2018 оны нийтийн сонгуулийг угтаад Камбож улсад иргэний нийгмийн байгууллага, улс төрийн идэвхтнүүдийг нухчин дарах гэсэн засгийн газрын ажиллагаа улам ширүүсэв. Хүний эрхийн хамгаалагчдыг хянаж цагдан, баривчлан хорьж, хэвлэл мэдээллийг хааж, эрүүгийн хуулийн тогтолцоог гуйвуулан иргэний нийгмийн байгууллагыг хавчих нь ихэсч, шинэ хууль баталсан нь улс төрийн намуудыг зохицуулах эрх мэдлийг засгийн газарт олгожээ. Шүүх нь олон ургальч үзлийг дарах арга хэрэгсэл болон хувирч, илтэд улс төрийн дарангуйллын шинжтэй үйлдэл гаргаж Дээд Шүүхээс сонгуулийн өмнө гол сөрөг хүчний намыг тараах шийдвэр гаргасан байна.

Тайландын цэрэгжсэн засгийн газар олон ургальч үзлийг системтэйгээр дарах, иргэдийг тайван замаар дуу хоолойгоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэхээс сэргийлэх, иргэний нийгмийг буруутган яллах ажиллагаагаа үргэлжлүүлсээр байгаа юм. Хэдэн арван хүний эрхийн төлөө тэмцэгч, ардчиллын төлөө идэвхтнүүд болон бусад хүмүүс зүй бус хууль, журмын дагуу шалгагдан, хэрэгт татагдаж, олонхи нь цэргийн шүүхийн шударга бус, урт удаан ажиллагааг дамжиж байна.

Малайзын засгийн газраас иргэний болон улс төрийн эрхийг нухчин дарах явдал нь хориглосон зохицуулалт бүхий хуулиудыг ашиглан дарамт үзүүлэх, шүүмжлэгчдийг саатуулан хорих, хилээр нэвтрэх хоригийг хугацаагүй, үндэслэлгүй тавьж хүний эрх хамгаалагчдын чөлөөтэй зорчих эрх чөлөөг боомилох, уугуул иргэдийн эрхийн төлөө тэмцэгчид, сэтгүүлчид зөрчлийг мэдээлснийх нь төлөө мөрдөн баривчлах зэргээр үргэлжилж байна.

Фижигийн засгийн газраас дарангуй хуулиар хэвлэл мэдээллийг хавчих, үзэл бодлоо илэрхийлэх болон тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг боомилж байна. *Фижи Таймс*-ын ажилчдын эсрэг үүсгэсэн хэрэг нь өөрчлөгдөж, үймээн самуунд турхирсан болж хувирсан нь тус орны цөөн хэдэн хараат бус хэвлэлийг дуугүй болгох гэсэн улс төрийн зорилготой үйлдэл юм.

Сингапурын Нийтийн Хэв Журмын тухай хуулийн нэмэлт эрх баригчдад нийтийн эвлэлдэн нэгдэх явдлыг хязгаарлах буюу хориглох боломж гаргаж, тайван замаар жагссаных нь төлөө хүний эрхийн хамгаалагч нарыг цагдаа нар мөрдөж байна. Шүүх байгууллагыг шүүмжилсэн хуульч, эрдэмтдийн эсрэг хэрэг үүсгэж, хэвлэлийн эрх чөлөөнд хязгаарлалт хийв.

Лаос улсад үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх онцгой хавчигдаж, тайван жамаар эсэргүүцэгчдэд эрүүгийн хуулийн дагуу ял оноосон байна.

Вьетнамд олон ургальч үзлийг нухчин дарах явдал хурцадсанаар олон олон идэвхтнүүд улсаасаа зугтахад хүргэжээ. Мьянмарт чөлөөт хэвлэлийн орон зай улам хумигдаж, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийнхэн ажлаасаа болоод дарамт шахалтанд өртөх, зарим үед баривчлагдан, хэрэгт орж байна.

ЯЛ ЗАВШИХ

Баривчилгааны үеэр амь насаа алдах болон галт зэвсгийг шаардлагагүй үед хэтрүүлэн ашиглах явдал Малайзад үргэлжилсээр байна. Баривчилгааны үед амь насаа алдсан тохиолдол хэд хэдэн удаа бүртгэгдсэний нэг нь байцаалтын үеэр цагдаа нарт зодуулсан гэх С.Баламурганы хэрэг юм.

Индонезийн Папуа мужид олон нийтийн жагсаалын үеэр болон бусад аюулгүй байдлыг хангах ажиллагааны үеэр шаардлагагүй их хэмжээний хүч ашигласан тал дээр хариуцлага хүлээлгэх нь хангалтгүй байна. Фижигийн засгийн газраас хоригдлуудыг аюулгүйн албаныхан эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцаж буй тал дээр хариуцлагад татаж чадаагүй л байна.

РОХИНГА ИРГЭДИЙН ЭСРЭГ МЬЯНМАРЫН ХЭРЦГИЙ АЖИЛЛАГАА

Аюулгүйн албаныхан хойд Рахине муж дахь Рохинга хүмүүсийн эсрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдохуйц хэмжээнд шүүхийн бус аллага, хүчирхийлэл, тосгодыг шатаах тэргүүтэй үндэстнийг цэвэрлэх ажиллагааг гүйцэтгэсэн. Наймдугаар сард зэвсэглэсэн Рохинга бүлэглэл шалган нэвтрүүлэх постууд руу дайрсны эсрэг авсан энэ хэтийдсэн аймшигт арга хэмжээ нь Зүүн Өмнөд Азид сүүлийн хэдэн арван жилд үзэгдээгүй дүрвэгсдийн гамшгийг бий болгов. Рахине мужид байгаа тусламжийн байгууллагуудын үйл ажиллагаанд Мьянмарын засгийн газраас ноцтой хязгаарлалт хийснээр байдлыг улам хурцатгав.

Бангладеш улс руу 655,000 гаруй Рохинга иргэн зугтан оржээ. Оны эцэс гэхэд бараг 1 сая Рохинга дүрвэгсэд Бангладешийн Кокс Базар дүүргээр тарсан байсанд өмнөх хэрцгийллийн үед зугтсан хүмүүс ч байв. Мьянмартаа үлдсэн хэсэг нь хуулийн өмнө тэгш байх, чөлөөтэй зорчихоос гадна эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, ажил хөдөлмөр эрхлэх эрх нь хүртэл ноцтой хязгаарлагдсан дэглэмд өдөр хоногийг өнгөрөөж байна.

Мьянмарын аюулгүйн албаныхан Рохингагийн эсрэг энэ хэрцгийллийн гол буруутан мөн. Гэвч Ан Сан Су Чигийн толгойлсон иргэний удирдлага үүнд саад хийж, дуу хоолойгоо илэрхийлж чадаагүй. Харин ч тэнд болж буй хэрцгийллийг хаацайлж, үгүйсгэхийн зэрэгцээ хүмүүнлэгийн ажилтнуудыг "террористуудад" тусласан гэж буруутгасан юм.

Мьянмарт болж буй энэ аймшигт хэргийн талаар нотлох баримт цугларсаар байхад олон улсын нийгэмлэг, тэр дундаа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс шийдвэртэй арга хэмжээ авах буюу цэргийнхний үйлдэж байгаа хүн төрөлхтний эсрэг хэрэгт хариуцлага нэхэх тухай тодорхой мэдэгдэл хийсэнгүй өдий хүрлээ.

ИРГЭДИЙН НҮҮДЭЛ

Австрали улс Папуа Шинэ Гвиней болон Науру дахь оффшор төвүүддээ орогнол хайж буй зуу зуун хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх тухай хатуу бодлогоо

хэрэгжүүлж, Австрали руу завиар очих гэсэн нэгнийг буцааж байгаа нь олон улсын өмнө тэднийг хамгаалахаар хүлээсэн үүргээ доголдуулж байна.

Дүрвэгсэд болон орогнол хайгчдыг Австралийн засгийн газар дөрвөөс илүү жилийн өмнөөс хүчээр Науруд аваачин хашдаг болсон. Гэвч тэнд биеийн, сэтгэлзүйн болон бэлгийн дарамт байдаг тухай олон баримт мэдээлэл байдаг юм. Оффшор төвд амьдарч буй хэдэн зуун хүн, тэдний дотор хүүхдүүд хэрцгийлэл, доромжлолыг амсч, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ хангалттай авч чадахгүй байна. Мөн тэр хавьд байгаа өөр 800 хүн аюулгүй байдал хангалтгүй, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, ажиллах боломжоор хангагдаагүй орчинд амьдардаг.

Фижи улс дүрвэгсдийг ноцтой хүнд байдал учирч мэдэх байтал эх нутагт нь буцаасаар. Камбож улс Монтагнард үндэсний 29 орогнол хайгчид дүрвэгчийн статус олгохоос татгалзаж, дарамтанд өртөх магадлалтай Вьетнам руу нь буцаажээ.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Австралийн хуульзүйн систем нь уугуул иргэдэд шударга бус үйлчилсэн хэвээр. Ялангуяа хүүхдүүдийг ихээр хавчих, баривчилгааны үеэр халдсан, бүр амиа алдсан тохиолдол ч гарав. Хойд хэсгийн Уугуул иргэдийн хүүхдүүдтэй зүй бусаар харьцах, түүн дотор нулимс асгаруулах хий цацах, хоолойг нь боох, хүлэх, ганцаарчлан хорих зэрэг үйлдэл нь алдагдсан бичлэгээр ил болсон юм.

ЛГБТИ хүмүүс Малайз, Папуа Шинэ Гвиней, Сингапур улсуудад алагчлагдаж байна. Хариуцлагын арга хэмжээг шинээр танилцуулсан ч Австралийн ЛГБТИ нийгэмлэгийн эсрэг үзэн ядсан мэдэгдлүүд нэмэгджээ. Индонезид ижил хүйстний бэлгийн харьцаанд орсны төлөө хоёр эрэгтэйг олны өмнө 83 удаа саваадсан байна.

Хүний эрхийн төлөө тэмцэгч эмэгтэйчүүд дарамт, шахалт, хорио, хэрцгийллийн бай болжээ.

Папуа Шинэ Гвинейн эмэгтэйчүүд, охидын эсрэг хэрцгийллийн талаарх мэдээлэл улам нэмэгдэж, заримдаа хачирхалтайгаар ял зэмлэл хүлээж байгаагаараа эмэгтэйчүүдэд хамгийн ээлгүй орнуудын нэгт тооцогдож байна.

Индонезийн буруу номын тухай хуулиар өөрсдийнхөө шашны зан үйлийг тайвнаар хийж байсан шашны цөөнхөд хамаарах хүмүүсийг буруутгажээ.

Австралийн парламентаас 2018 оны 12 сард гэрлэлтийн тэгш байдлыг хангах хууль баталсан. Засгийн газраас явуулсан санал асуулгаар гэрлэлтийн тэгш байдал нь хүний эрх болохыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд улмаар хуваагдмал, ноцтой нийтийн мэтгэлцээн үүсгэсэн юм.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Малайзад дор хаяж дөрвөн удаа цаазаар авах ял гүйцэтгэсэн. Сингапурт хүн амины болон хар тамхи наймаалах хэрэгт дүүжлэн хороох ял оноосон хэвээр. Тэдний дотор Малайз үндэстэн Прабагаран Шривижаян байсан бөгөөд Малайзад давж заалдах шатны өргөдөл нь хүлээгдэж байхад ялыг нь гүйцэтгэсэн байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Рахине мужийн байдалтай харьцуулахад олон улсын анхааралд өртөөгүй л болохоос Мьянмарын цэргийнхэн хойд Мьянмарт төстэй үйл ажиллагаа явуулсан юм. Качин болон хойд Шан мужуудад иргэдийн эсрэг шүүхийн бус аллага, хүчээр ор сураггүй болгох, эрүүдэн шүүх, бөмбөгдөх, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүмүүнлэгийн тусламжаас таслах зэрэг хүний эрхийн зөрчил болон дайны гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Цөөнхийн зэвсэгт бүлэглэлүүд хүн хулгайлах, хүчээр цэрэгт дайчлах зэрэг зөрчил гаргасан. Засгийн газрын арми, зэвсэгт бүлэглэл хоёулаа газрын тэсрэх бөмбөг маягийн зүйл хэрэглэж иргэдэд хохирол учруулжээ.

Филиппиний Маравид цэрэг болон Исламын улс гэгдэх бүлэглэлтэй нэгдмэл ашиг сонирхолтой гэх Мауте бүлэглэлийн хооронд таван сар үргэлжилсэн дайнаас

болж хэдэн зуун мянган иргэн орогнох газраа, хэдэн арван иргэн амиа алдаж, орон гэр, дэд бүтэц үй олноороо сүйджээ.

КОРПОРАЦИЙН ХАРИУЦЛАГА

Мьянмарын Летпадаунгийн зэсний аварга уурхайг хаахыг ойролцоо амьдарч байгаа иргэд шаардсаар байгаа юм. Түүний ойр амьдарч байгаа мянга мянган айл өөрсдийн орон гэр, тариалангийн газраасаа хүчээр хөөгдөх эрсдэлд амьдарч, эрх баригчид дарангуй хуулиар түрий барин идэвхтнүүд болон тосгоны иргэдийг дарж байна.

Индонезид дэлхийн хамгийн том дал модны тос худалдаалагч Вилмар Интернэшнл компаний салбар болон бэлтгэн нийлүүлэгчдийн эзэмшдэг тариалангийн талбайд хөдөлмөрийн мөлжлөг явагдаж байжээ. Угийн бага цалингаа хасуулахгүйн тулд эмэгтэйчүүдийг уртасгасан цагаар ажиллуулах, бүр найман настай хүүхэд биеийн хүчний аюултай ажил хийх, ажилчид химийн бодист хордох зэргээр эрх нь зөрчигдөж байсан аж. Вилмар Интернэшнл нь ажилчдаа дарамтлан энэ мэдээллийг няцаалгах зэргээр зөрчлөө нуух гэж байгаа ч Индонезийн засгийн газар арга хэмжээ авч, нягтлахгүй байгаагаараа өөгшүүлж байна.

АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Тус тив даяар ялгаварлан гадуурхалт болон тэгш бус байдал хэвийн зүйл байсаар байна. Аллага, хүчээр сураггүй болгох болон дур зоргоор баривчлах явдал ар араасаа цуварч, бүс нутаг даяар хүчирхийллийн түвшин өндөр байлаа. Хүний эрхийг хамгаалагчид руу халдах нь нэмэгджээ. Ял завших явдал хаа сайгүй байна. Бусдыг ад зэтгэр гэж үзэх, хагалан бутаргах бодлого гаарлаа. Уугуул иргэдийг ялгаварлан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг нь зөрчих, түүний дотор газар эзэмших, амьдралд нь шууд нөлөөлөх төслийн талаар урьдчилан мэдээллээр хангагдсаны үндсэн дээр чөлөөтэй зөвшилцөх эрхийг нь эдлүүлэхгүй байна. Засгийн газрууд охид, эмэгтэйчүүд болон лесбиян, гей, бисексуал, трансжендэр ба интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн эрхийг хамгаалах талаар маш бага ахиц гаргав.

Америк тивийн бүс нутаг даяар хүн хууль эрх зүй, бодлого, практикт хүний эрхийн нөхцөл дордож, бусдыг ад зэтгэр гэж үзэх, хагалан бутаргах бодлогыг ихээр хэрэглэснээс хүний эрхийн гүнзгий хямралд өртлөө. Ийм ухралт олон оронд тархах эрсдэлтэй байна. Сонгууль, санал асуулгад оролцогчдын түвшин болон үндэсний хууль шүүхийн байгууллагад хандах явдал буурч байгаа нь эрх баригчдад итгэх итгэл буурснаар улам даамжирлаа.

Хүний эрхийг илүү шударга, тогтвортой ирээдүй цогцлоход ашиглахын оронд засгийн газрууд иргэдийг нухчин дарах тактикийг хэрэглэхийг илүүд үзэх болжээ. Аюулгүйн хүчнийхэн, хууль шүүхийн системийг өөрөөр сэтгэгчид, шүүмжлэгчдийн амыг барихад ашиглаж, газар авсан эрүү шүүлт, хүнлэг бусаар харьцааг ял шийтгэлгүй өнгөрөөж, авлигад хариуцлага тооцож, шударга ёсыг тогтоож чадахгүй байгаагаас тэгш бус байдал, ядуурал, ялгаварлан гадуурхалт улам даамжирсаар байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп хэд хэдэн захирамж, түүний дотор “Исламын шашинтнуудыг хориглох”, АНУ-ын Мексик улстай хиллэх хилийн дагуу хана босгох шийдвэр гаргасан нь хүний эрхэд томоохон ухралт боллоо.

Бразил, Эль Сальвадор, Гондурас, Мексик, Венесуэл зэрэг улсад хэт туйлширсан, уягирсан хүчирхийлэл түгээмэл байна. Тус бүс нутаг даяар хууль бус зэвсгийн тархалт, зохион байгуулалттай гэмт хэргийн өсөлтийн улмаас хүчирхийлэл даамжирч байна. ЛГБТИ хүмүүс, охид, эмэгтэйчүүд болон уугуул иргэдийн эсрэг хүчирхийлэл газар авчээ.

НҮБ-ын тайланд дурдсанаар Латин Америк ба Карибын бүс нутаг хатуу чанд хууль тогтоомжтой ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хамгийн их гардаг бүс нутаг юм. Энэ бүс нутаг эмэгтэйчүүдийн эсрэг ураг төрлийн бус хүний үйлдсэн хүчирхийллийн хэмжээгээр дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн хэмжээгээр хоёрдугаарт орж байна.

Мексик улсад сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчдын амь насыг бүрэлгэсэн хэрэг удаа дараа гарсан бол Венесуэл өнөө цагийн түүхэн дэх хүний эрхийн ноцтой зөрчил, хямралтай улс болоод байна. Колумби улсад уугуул иргэд болон Африк гаралтай удирдагчдын амийг хороосоор байгаа нь энхийн үйл явц хангалтгүй хэрэгжиж байгааг харууллаа.

Олон оронд газрын эрхийн төлөө тэмцэгчид хүчирхийлэл болон бусад эрхийн зөрчлийн золиос болов. Тус бүс нутагт хүний эрхийг хамгаалагчид, айл хотлын удирдагчид болон сэтгүүлчдийн эсрэг заналхийлэл, халдлага, түүний дотор хууль шүүхийн тогтолцоог буруугаар ашиглах явдал нэмэгдэж түгшүүртэй хэмжээнд хүрлээ.

Хүмүүс хэлмэгдүүлэлт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, ядуурлаас зугтан орон гэрээ орхин дүрвэсэн. Гэвч замдаа эсхүл очсон хойноо эрхийн зөрчилд өртсөөр байна.

Ял завшихын эсрэг тэмцэх, хохирогчдын эрхийг хүндэтгэх Перу улсын хүсэл эрмэлзэл 2009 онд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэний улмаас ял шийтгүүлсэн

Перу улсын ерөнхийлөгч асан Альберто Фужиморид өршөөл үзүүлснээр салхинд хийсэн одов. .

Улс орнууд хүний эрхийг хүндэтгэхгүй байгаа нь улс бус тоглогчдод олон улсын эрх зүйн гэмт хэрэг болон бусад зөрчил үйлдэх боломж олгож байна. Эдгээрт ихэнхдээ хүчний байгууллагуудтай хуйвалдан бүхэл бүтэн газар нутгийг хянаж байдаг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд багтдаг. Үндэсний болон үндэстэн дамнасан корпорациуд уугуул иргэд, мөн Перу, Никарагуа зэрэг улсын тариачдаас газар, нутаг дэвсгэрийнх нь хяналтыг авахыг санаархсаар байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлж чадаагүйгээс зовлон зүдгүүр даамжирч байна. АНУ-ын Ерөнхийлөгч Трамп бодлогын чиг шугамыг өөрчилснөөр тус улсын Конгресс Куба улсын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээг цуцлах хууль гаргах боломжгүй болж, эдийн засгийн хориг арга хэмжээний сөрөг үр нөлөө Куба улсыг туйлдуулсаар байна. Парагвай улсын эрх баригчид хүмүүсийг хүчээр нүүлгэн шилжүүлсний дараа шаардлага хангасан орон байртай байх эрхийг нь зөрчиж байна.

6-р сард Мексик улсын Канкун хотноо болсон Америкийн улсуудын байгууллагын (АУБ) Ерөнхий Ассемблей дээр тус бүс нутагт нэн тэргүүнд тулгамдаад байгаа хүний эрхийн асуудалд анхаарал хандуулах улс төрийн манлайлал дутагдаж байгаа нь тодорхой харагдсан юм. Хэсэг бүлэг улс орнууд хүний эрхийг хүндэтгэн сахиулах талаар өөрсдийн алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрөөгүй атлаа Венесуэл улсад болж буй хямралыг буруушаахыг эрмэлзсэн. Өнгөрсөн жилийн санхүүгийн хямралын дараа АУБ Америк хоорондын хүний эрхийн тогтолцооны төсвийг хоёр дахин нэмэгдүүлэх алхам хийсэн боловч санхүүжилтыг тодорхой шалгуураар олгохоор болсон нь Америк хоорондын Хүний эрхийн комисс болон Америк хоорондын Хүний эрхийн шүүхээс улс орнуудад хүний эрхийн зөрчил үйлдсэний төлөө хариуцлага хүлээлгэхэд саад болж магадгүй байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Трамп ялгаварлан гадуурхалт болон гадаадынхныг үзэн ядах үзлийг дэвэргэсэн үг яриагаа аль хэдийнэ үйл хэрэг болгож эхэлсэн бөгөөд тус улсын болон гадаадын олон сая хүний эрхэд заналхийлсэн захирамжид гарын үсэг зурсан нь шударга ёс ба эрх чөлөөнд ихээхэн ухралт боллоо. Тухайлбал орогнол эрэгчдийг баривчлан хорих зэрэг хүний эрх зөрчсөн АНУ-Мексикийн хил хамгаалалтын арга хэмжээ авах болсон; охид эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхэд хатуу хязгаарлалт тогтоосон; ЛГБТИ ажилчид болон трансжендэр оюутнуудын хамгаалалтыг цуцласан; Дакотагийн хийн хоолойн ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосноор Standing Rock Sioux омог болон бусад уугуул иргэдийн усны эх үүсвэрт аюул учруулахын зэрэгцээ тэдний чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөх эрхийг зөрчиж байгаа зэргийг дурдаж болно.

Айлган сүрдүүлж, дарамталлаа ч тэмцэгчдийг зогсоож чадахгүй байна. Нийгмийн сэтгэл ханамжгүй байдал өссөнөөс, ард иргэд гудамжинд гарч, эрхийнхээ төлөө тэмцэж, хэлмэгдүүлэлт, гадуурхалт, шударга бус явдлыг таслан зогсоохыг шаардах боллоо. Тухайлбал, Аргентин улсын Мапуче хотноо болсон жагсаал цуглааныг цагдаа нар хүч хэрэглэн тараах үеэр сураггүй алга болсон идэвхтэн Сантьяго Малдонадог дэмжсэн олныг хамарсан жагсаал болов. Тус бүс нутгийн олон оронд охин ургийн амийг таслах, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг буруушаасан "Ni Una Menos" ("нэг ч гэсэн эмэгтэйгээр дутах ёсгүй") нийгмийн хөдөлгөөн өрнөснийг дурдаж болно.

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

ВЕНЕСУЭЛИЙН ХЯМРАЛ

Орчин үеийн түүхэндээ байгаагүйгээр Венесуэл улс хүний эрхийн хямралд өртөөд байгаа бөгөөд засгийн газрын дэмжлэгтэй хүчирхийлэл хямралыг улам өдөөж байна. Мөнгөний ханш улам унаж, хүнс, эм тарианы хомсдол нүүрлэж байгаагаас жагсаал цуглааны тоо өсчээ. Хууль сахиулагчид жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн

нулимс асгаруулагч, резинэн сумаар буудсаны улмаас 120 гаруй хүн амиа алдсан юм. Олон мянган хүнийг дур зоргоор баривчилснаас гадна эрүү шүүлт тулгаж, хүнлэг бусаар харьцсан баримт олон байна. Хууль шүүхийн тогтолцоог өөрөөр сэтгэгчдийн амыг барих, түүний дотор цэргийн шүүхээр энгийн иргэдийг яллах, хүний эрхийг хамгаалагчдыг онилон дарамтлахад ашиглаж байна.

МЕКСИК УЛС ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ БА ЯЛ ЗАВШИХ ЯВДАЛ

Мексик улсад хүний эрхийн хямрал үргэлжилсээр, хүчирхийлэл ба аллага, түүний дотор урьд өмнө байгаагүй олон тооны сэтгүүлчдийн амь насанд халдсан явдал байдлыг улам хурцатгаж байна. Дур зоргоор баривчлан хорих явдал түгээмэл байгаа нь хүний эрхийн зөрчил бусад зөрчил гарахад нөлөөлж, ихэнх тохиолдолд тэдгээрийг зохих ёсоор мөрдөн шалгахгүй орхиж байна. 34 000 гаруй хүн хүчээр сураггүй алга болоод байгаагаас гадна шүүхээс гадуур цаазлах явдал олонтаа гарлаа. Эрүү шүүлт ба бусад хүнлэг бус харьцаа түгээмэл байгаагаас гадна хүмүүсээс “гэм буруугаа хүлээсэн мэдэгдэл” хүчээр гаргуулсаар байгаа хүчний байгууллагын ажилтнууд ял завшсаар байна. Сенат хүчээр сураггүй алга болгосон 43 оюутны асуудлаар үндэсний хэмжээнд олон нийтийн эсэргүүцэл өрнөсний дараа хүчээр сураггүй алга болгохын эсрэг шинэ хууль баталсан нь нэг алхам урагшилсан ахиц хэдий ч, уг хуулийг хэрэгжүүлэх, шударга ёс, үнэнийг тогтоох, хохирлыг барагдуулахад улс төрийн ихээхэн хүчин чармайлт шаардлагатай байгаа юм. Түүнчлэн Конгресс эрүүдэн шүүхийн эсрэг ерөнхий хуулийг баталсан. Мөн зэвсэгт хүчээр цагдаагийн үүргийг удаан хугацаанд гүйцэтгүүлсэн, дотоодын аюулгүй байдлын тухай хууль баталсан нь илүү сэтгэл түгшээж байгаа бөгөөд ингэснээр хүний эрхийн зөрчлийг улам нэмэгдүүлсэн аж.

ХУУЛЬ БУС АЛЛАГА

Бразилын эрх баригчид хүний эрхийн хямрал гүнзгийрч буйг үл тоомсорлож байна. Рио де Жанейро хотод хүчирхийлэл өсөхийн хэрээр цагдаа нарын хууль бус аллага үйлдэх нь нэмэгджээ. Аллагын тоог бууруулах, цагдаагийн хүч хэрэглэх эрхэд хяналт тавих, уугуул иргэдийн эрхийг баталгаажуулах талаар ахиц гарсангүй. Бразил улсын замбараагүй, ачаалал нь хэтэрсэн, аюултай шоронгийн нөхцлөөс үүдэн гарсан бослогуудын үеэр 1-р сард гэхэд 120 хоригдол амиа алдсан баримт бий.

Гондурас улсад аллага буурсан, аюулгүй байдлын асуудал ноцтой сэтгэл түгшээж байгаа бөгөөд ял завших явдал түгээмэл байгаа нь олон нийтийн зүгээс эрх баригчид ба хууль шүүхийн тогтолцоонд итгэх итгэлийг хөсөрдүүлж байна. 11-р сард болсон ерөнхийлөгчийн сонгуулийн будлианыг эсэргүүцэж, улс орон даяар өрнөсөн олныг хамарсан жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараах үеэр дор хаяж 31 хүн алагдаж, олон арван хүнийг дур зоргоор баривчлан хорьж, нилээдгүй хүн шархадсан юм.

Доминиканы БНУ-д аюулгүйн хүчнийхний үйлдсэн олон арван хууль бус аллага бүртгэгдсэн нь тус улсад аллагын түвшин өндөр хэвээр байгааг харуулсан. Жамайка улсын цагдаа хууль бус аллага үйлдсээр байгаа бөгөөд тэдгээрийн зарим нь шүүхээс гадуур цаазлах шинжтэй боловч ямар ч хариуцлага хүлээхгүй, ял завшсаар байна.

ЖАГСААЛ ЦУГЛААН

Олон улс орон, түүний дотор Колумби, Парагвай, Пуэрто Рико улсын эрх баригчид жагсаал цуглааныг шаардлагагүй үед хүч хэтрүүлэн дарлаа.

Парагвай улсын сенатын гишүүд Үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулж, ерөнхийлөгчийн дахин сонгууль явуулах нууц оролдлого хийсэн нь илэрсний улмаас жагсаал цуглаан өрнөсөн. Конгрессын барилгад зарим жагсагчид гал тавьсан бөгөөд сөрөг хүчний идэвхтэн Родриго Квинтано цагдаад алуулсан. Олон арван хүн гэмтэж бэртэн, 200 гаруй хүнийг баривчлан хорьсноос гадна аюулгүйн хүчнийхэн хүмүүсийг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр хүнлэг бус харьцсан талаар олон нутгийн байгууллагууд мэдээлсэн.

Никарагуа улсад цагдаагийн ажилтнууд хөдөөгийн айл хотлууд болон уугуул иргэдийг Гранд Интересосеаик сувгийн барилгын ажлыг эсэргүүцэн тайван замаар жагсаал цуглаан хийхэд нь саад учруулсан.

Аргентин улсад идэвхтэн Сантиаго Мальдонадог алагдсаны дараа Буэнос Айрес хотноо болсон жагсаалд оролцсон 30 гаруй хүнийг цагдаа нар дур зоргоор баривчлан хорьжээ. Мөн 12-р сард тус хотод засгийн газрын шинэчлэлийн эсрэг хийсэн олныг хамарсан жагсаалын үеэр жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэсэн.

ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХ БА ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ УСТГАХЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ

Олон оронд ял завшуулсаар байгаа нь хүний эрхийн зөрчил газар авах гол шалтгаан болж байна.

Гватемал улсад ял завших явдал болон авлига гүнзгийрсээр байгаа нь олон нийтийн зүгээс эрх баригчдад итгэх итгэлийг сулруулж, шударга шүүхээр шүүлгэх эрхэд саад тотгор болж байна. Тус улсад 8-9-р сард томоохон жагсаал цуглаан өрнөсөн бөгөөд засгийн газрын зарим гишүүд Ерөнхийлөгч Жимми Моралес Гватемал улс дахь Ял завших явдлын эсрэг Олон улсын комиссын тэргүүнийг албадан гаргахыг завдсаныг эсэргүүцэн огцорсны улмаас улс төрийн хямрал нүүрлэсэн. Уг комиссыг 2006 онд Гватемал улсын засгийн газар болон НҮБ хямрал мөргөлдөөний дараа хуулийн засаглалыг бэхжүүлэх үүднээс байгуулж байсан юм.

Чили улсад өнгөрсөн ба одоо үед үйлдэгдсэн болон үйлдэгдэж буй хүний эрхийн зөрчилд хариуцлага тооцохгүй байгаа нь сэтгэл түгшээсэн хэвээр байна. Мапучегийн удирдагч Виктор Кейпулыг хулгайлж, эрүүдэн шүүсэн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг эрх баригчдын зүгээс хаасан нь тус улсын хүний эрхийг хамгаалагчдад түгшүүр төрүүлэв. Уг хэргийн талаар иж бүрэн, хараат бүс мөрдөн шалгах ажиллагаа огт хийгдсэнгүй. Уугуул иргэдийн удирдагч Мачи Франсиска Линконао болон Мапуче овгийн өөр 10 хүнийг 2013 оны 1-р сард хоёр хүний амийг бүрэлгэсэн террорист халдлагад холбогдуулан шалгасан ч нотлох баримт хангалтгүй хэмээн сулласан хэдий ч 12-р сард Давж заалдах шатны шүүх уг шийдвэрийг хүчингүй хэмээн зарлаж, 2018 онд шүүх хурал дахин явуулахаар болжээ.

ӨНГӨРСӨН ҮЕД ҮЙЛДЭГДСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛТЭЙ НҮҮР ТУЛАХ НЬ

Шийдвэрлэгдээгүй хүний эрхийн зөрчлийн талаарх хүчин чармайлт улс төрийн хүсэл эрмэлзэл дутмагаас шалтгаалан удаан хойрго байх нь олонтаа байна.

Перу улсын Ерөнхийлөгч Педро Пабло Кузински 2009 онд доод албан тушаалтнууд нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэний улмаас 25 жилийн хорих ялаар шийтгэгдээд байсан ерөнхийлөгч асан Альберта Фужиморид эрүүл мэндийн шалтгаанаар өршөөл үзүүлэх шийдвэр гаргасныг олон мянган хүмүүс эсэргүүцэн гудамжинд жагссан. Фужимори хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдож болзошгүй хүний эрхийн бусад зөрчил үйлдсэн хэрэгт мөн буруутгагдаад байсан юм.

Уругвай улсад цэргийн дэглэмийн үед (1973-1985) үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийг судалж байсан хүний эрхийг хамгаалагчдын амь насанд халдахаар заналхийлсэн ч эх сурвалжийг нь тодруулах мөрдөн шалгах ажиллагаа хийгдээгүй. 11-р сард Дээд шүүхээс цэргийн дэглэмийн үед үйлдэгдсэн гэмт хэргүүд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдох үндэслэлгүй учир хөөн хэлэлцэх хугацааг тооцох ёстой гэсэн шийдвэр гаргасан.

Гэвч зарим нэг ахиц дэвшил гарлаа. Аргентин улсад 1976-1983 онд цэргийн дэглэмийн үед хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэний учир 29 хүнд бүх насаар нь хорих ял оноосон бөгөөд холбооны шүүхээс тухайн үед хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэхэд хувь нэмэр оруулсан хэмээн үзэж шүүгчээр ажиллаж байсан 4 хүнд бүх насаар нь хорих ял оноох түүхэн шийдвэр гаргасан.

Беливи улсад 1964-1982 онд цэргийн засгийн газруудын үед үйлдэгдсэн хүний эрхийн ноцтой зөрчлийг мөрдөн шалгах зорилготой Үнэнийг тогтоох комисс байгуулсан.

Гватемал улсын дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр (1960-1996) үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг мөрдөн байцаах ажилд ахиц дэвшил гарч, цэргийн албан хаагч асан 5 хүнийг бусдыг хууль бусаар хорьсон, бэлгийн хүчирхийлэл болон бусад хэлбэрийн эрүү шүүлт үйлдсэн хэрэгт буруутган шүүхэд шилжүүлсэн. 2015 оноос хойш хэд хэдэн удаа бүтэлгүйтсэний эцэст төрийн тэргүүн асан цэргийн эрхтэн Хозе Эфрайн Риос Монт болон тагнуулын албаны дарга асан Хозе Родригез Санчес нарын шүүх хурал 10-р сард дахин эхлэв.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧИД БОЛОН ХАРЬАЛАЛГҮЙ ХҮМҮҮС

АНУ ХАМГААЛАХААС ТАТГАЛЗАВ

21 сая хүн дайн дажин, мөрдлөгө хавчлагаас зугтан орон гэрээ орхихоос аргагүй болсон дэлхий нийтийг хамарсан дүрвэгсдийн хямралын үед анхаарал халамж шаардлагатай байгаа тэдгээр хүмүүсийг хамгаалахаас АНУ татгалзан, туйлширсан арга хэмжээ авлаа. Ерөнхийлөгч Трамп засгийн эрхэнд гарсан эхний хэдэн долоо хоногтоо дүрвэгсдийг дахин суурьшуулах хөтөлбөрийг 120 хоногоор зогсоох, Сири улсаас ирсэн дүрвэгсдийг дахин суурьшуулах хөтөлбөрийг бүрмөсөн зогсоох, жил бүр хүлээн авах дүрвэгсдийн тоог 50000 болгон бууруулах тухай захирамж гаргасан.

Түүнчлэн Ерөнхийлөгч Трамп АНУ-Мексикийн хил дагуу хана босгох тухай захирамжид гарын үсэг зурсан. 5000 гаруй хил хамгаалалтын албан хаагчдыг нэмж ажиллуулах түүний тушаал нь илүү олон цагаачид, түүний дотор олон улсын хамгаалалт шаардлагатай олон цагаачдыг хууль бусаар, амь насанд нь халтай газар руу буцаах эрсдэл авчирч байгаа юм.

ДҮРВЭГСДИЙН ХЯМРАЛ

НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газрын үзэж байгаагаар Гондурас, Гватемал болон Эль Сальвадор улсын 57000 гаруй иргэн орогнол эрж бусад улс рүү дүрвээд байна. Тэднийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо байхгүй, зугтаж гарсантайгаа адилхан аюултай нөхцөл байдалтай тулгарсан учраас олон хүн буцахаас өөр аргагүй байдалд оржээ. Эдгээр улсын олон мянган гэр бүл болон асран хамгаалагчгүй хүүхдүүд Мексик улсаар дамжин АНУ руу цагаачлах замдаа АНУ-ын хил дээр саатуулагдсан.

Аргентин улсын орогнол эрэгчдийг хүлээн авах тогтолцоо удаан бөгөөд хангалтгүй, орогнол эрэгчид ба дүрвэгсдэд боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг үндсэн эрхийг эдлүүлэхэд туслах тодорхой төлөвлөгөө байхгүй байна.

Кубачууд цалин хөлс доогуур, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хязгаарлагдмал зэрэг шалтгаанаар улс орноо олон тоогоор орхин гарсаар байна.

ХАРЬАЛАЛГҮЙ БОЛОН ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШСАН ХҮМҮҮС

Доминиканы БНУ-д олныг хамарсан харьяалалгүй хүмүүсийн хямрал үргэлжилсээр байгаа бөгөөд тус улсад төрсөн 2013 онд Доминакан улсын харьяаллаа хууль бусаар алдсан Гайти гаралтай олон мянган хүн байна. Тэдгээр хүмүүс дээд боловсрол эзэмших, албан ёсны хөдөлмөр эрхлэх, шаардлага хангасан эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг хүний эрхээ эдлэж чадахгүй байна.

Гайти улсад 2010 оны газар хөдлөлтийн улмаас 38 000 орчим хүн дотооддоо шилжин суурьшсан. Доминакан –Гайти улсын хил дээр иргэдийг албадан гаргах явдал өсч байгаа талаар мэдээлэх болсон.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ

Уугуул иргэдийн эрх олон улс , түүний дотор Аргентин, Боливи, Канад, Чили, Колумби, Эквадор, Гондурас, Никарагуа, Перу зэрэг улсад зөрчигдсөөр байна.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Аргентин улсад уугуул иргэдийг гэмт хэрэгт татах, ялгаварлан гадуурхах явдал байсаар. Эрх баригчид хууль шүүхийг тэднийг дарамтлахад ашигладаг. Цагдаа уугуул иргэдийг зодож, айлган сүрдүүлсэн тохиолдлууд гарсан. 11-р сард хүчний байгууллагын явуулсан нүүлгэн шилжүүлэлтийн үеэр Мапуче овгийн Рафаэл Нахуэл алагдсан.

Колумби улсад зэвсэгт мөргөлдөөний золиос болсоор ирсэн уугуул иргэд аллагад өртсөөр байгаа нь Энхийн хэлэлцээр хэрэгжихгүй байгааг илтгэлээ. Каука мужийн Тимбио суурингийн Ките Киве Уугуул иргэдийн зөвлөлийн удирдагч Герсон Акостаг хурал тараад явж байхад нь хэд хэдэн удаа буудаж хөнөөсөн нь нутгийн удирдагчид болон бусад уугуул иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах талаар эрх баригчдын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүнд хүрэхгүй байгаагийн гунигт жишээ юм.

Америк хоорондын Хүний эрхийн комисс тус бүс нутгийн уугуул эмэгтэйчүүдэд тулгарч буй ялгаварлан гадуурхалтын олон хэлбэрийг баримтжуулсан бөгөөд тэднийг улс төр, нийгэм, эдийн засгийн хувьд шоовдорлон гадуурхаж байгаа нь хүчирхийлэлд өртөх эрсдлийг нь нэмэгдүүлж байна.

ГАЗРЫН ЭРХ

Перу улсад газар болон нутаг дэвсгэртэй холбоотой уугуул иргэдийн эрхийг шинэ баталсан хуулиараа сулруулж, чөлөөтэй, урьчилан мэдээлэл авч зөвшилцөх эрхийг нь хаан боогдуулж байна. Цорын ганц цэвэр усны эх үүсвэр нь хорт металлаар бохирдож, шаардлага хангасан эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй байгаа олон зуун уугуул иргэдийн эрүүл амьдрах эрхийг Засгийн газар үл тоомсорлож байна.

Эквадор улсад уугуул иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөх эрх зөрчигдсөн хэвээр байгаа бөгөөд төрийн зүгээс ирээдүйд газрын тос олборлох зорилгоор нутаг дэвсгэрт нь халдах болжээ.

Мөн Парагвай улсын уугуул иргэдийн газартай холбоотой эрх, амьдралд нь нөлөөлөх төслүүдийн талаар чөлөөтэй, урьчилан мэдээлэл авч зөвшилцөх эрх зөрчигдсөөр байна. Америк хоорондын Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг эс харгалзан засгийн газар Яке Акса омгийнхонд эх нутагтаа эргэн очих боломжийг хангаагүй төдийгүй Савхоямакса омгоос хурааж авсан газрын өмчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэж чадаагүй.

Гватемал улсын Дээд шүүх уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртсөн Шинка уугуул иргэдтэй хангалттай хэмжээнд урьдчилан зөвшилцөөгүй болохыг хүлээн зөвшөөрсөн.

Бразил улсад газрын маргаан мөргөлдөөн болон хууль бус мод огтлогчид, уурхайн ажилчид уугуул иргэдийн нутаг дэвсгэрт халдаж, уугуул иргэдийн эсрэг хүч хэрэглэжээ.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД БА СЭТГҮҮЛЧИД

Тус бүс нутгийн олон оронд хүний эрхийг хамгаалах нь туйлын эрсдэлтэй, аюултай зүйл бөгөөд Боливи улсад, Бразил, Чили, Эквадор, Гондурас, Мексик, Никарагуа, Парагвай улсад хүний эрхийн хамгаалагчид заналхийлэл, халдлага, дайралтад өртөж байна.

МЕКСИК УЛС ДАХЬ АЛЛАГА БА ХАЛДЛАГА

Мексик улсад хүний эрхийн хамгаалагчдыг заналхийлэх, халдлага үйлдэх, амь насыг нь хөнөөж байгаагийн зэрэгцээ цахимаар дайралт хийх, мөшгин хянах явдал түгээмэл байна. Жилийн дотор дор хаяж 12 сэтгүүлч алагдсан нь 2000 оноос хойш

бүртгэгдсэн хамгийн өндөр тоо бөгөөд тэдний олонх нь олон нийтийн газар, гэгээн цагаан өдөр амиа алджээ. Эрх баригчдын зүгээс гэм буруутныг мөрдөн шалгах, ял шийтгэл оногдуулах талаар олигтой ахиц дэвшил гаргахгүй байна. Хохилогчдын дотор 5-р сард өөрийн үндэслэн байгуулсан *Риодосе* сонин газрын ойролцоо алагдсан, нэр хүндтэй шагналын эзэн, сэтгүүлч Хавиер Валдез байв. Тодорхой хүмүүсийн сүлжээ Мексик даяар сэтгүүлчдийг заналхийлж, дарамтлахын тулд интернэтийг ашиглаж байгаа нь тодорхой болсон. Түүнчлэн засгийн газрын худалдаж авсан программ хангамжийг ашиглан сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчдыг мөшгин хянаж байгаа баримт нотолгоо олноор байна.

ГОНДУРАС УЛСЫН ЭРСДЭЛД БҮЙ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Гондурас улс хүний эрхийн хамгаалагчид, ялангуяа газар, нутаг дэвсгэр, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа хүмүүст тус бүс нутгийн хамгийн аюултай орны нэг юм. Тэднийг төр засаг болон улс бус тоглогчдын аль аль нь онилж, тэдний хийж буй ажлыг нь гутаан доромжлох кампанит ажил өрнүүлж, сүрдүүлж, заналхийлж, дайралт хийх нь ердийн зүйл болсон. Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг бүртгэгдсэн ихэнх халдлагад ял шийтгэл оногдуулдаггүй. 2016 оны 3-р сард алагдсан уугуул иргэдийн хүрээлэн буй орчныг хамгаалагч Берта Касерасын хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд ахиц дэвшил бага байна. Түүнийг алагдсаны дараа Гондурасын хэд хэдэн хүрээлэн буй орчны болон хүний эрхийн идэвхтнүүдэд халдаж, айлган сүрдүүлсэн.

КОЛУМБИ УЛСАД ХАЛДЛАГА ӨССӨӨР

Колумби улсад хүний эрхийн хамгаалагчид, ялангуяа нутгийн удирдагчид, газар, нутаг дэвсгэр, хүрээлэн буй орчныг хамгаалагчид болон Энхийн хэлэлцээрийг дэмжигчдийн эсрэг халдлагын тоо өслөө. НҮБ-ын Хүний эрхийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газрын мэдээгээр жилийн турш 100 гаруй хүний эрхийг хамгаалагчид амь насаа алджээ. Зэвсэгт бүлэглэлүүдийн зүгээс идэвхтнүүдийн амь насанд удаа дараа заналхийлсэн ихэнхдээ хэн аллага үйлдсэнийг эрх баригчид олж, тогтоож чадахгүй байна.

ДУР ЗОРГООР БАРИВЧЛАХ, ЗАНАЛХИЙЛЭХ, ДАРАМТЛАХ

Куба улсад олон тооны хүний эрхийн хамгаалагчид болон улс төрийн идэвхтнүүдийг дарамталж, айлган сүрдүүлж, төрийн албанаас халсаар байгаа бөгөөд шүүмжлэлийг дуугүй болгохын тулд үндэслэлгүйгээр баривчлан хорьж байна. Цахим болон цахим бус цензур тавьж байгаа нь боловсролын салбар урагшлахад саад болж байна. Үзэл санааны хоригдлуудын дотор ерөнхийлөгч асан Фидель Кастрог ил тодоор шүүмжилсний төлөө 3 жилийн хорих ял шийтгүүлсэн, ардчиллын төлөө Христийн чөлөөлөх хөдөлгөөний удирдагч Эдуардо Кардет Консепсионыг дурдаж болно.

Гватемал улсын хүний эрхийн хамгаалагчид, ялангуяа газар, нутаг дэвсгэр, хүрээлэн буй орчны асуудлаар ажилладаг хүмүүс заналхийлэл, халдлагад байнга өртөж, нэр төрийг нь гутаан доромжлох кампанит ажлын золиос болдог. Түүнчлэн хууль шүүхийн тогтолцоог хүний эрхийн хамгаалагчдыг онилох, дарамтлах, дуу хоолойг нь хорих зэрэгт ашиглах тохиолдол түгэмэл байна.

Перу улсын Дээд шүүх хүний эрхийн хамгаалагч Максима Акуна Аталаяг газар булаан авсан гэх үндэслэлгүй хэрэгт холбогдуулан 5 жилийн турш эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсныг хэргэсэхгүй болгосон нь хүрээлэн буй орчныг хамгаалагчдын хувьд түүхэн шийдвэр байв.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Тус бүс нутгийн охид, эмэгтэйчүүд өргөн хүрээтэй хүчирхийлэл, эрхийн зөрчил,

түүний дотор жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн зөрчлийн золиос болсоор байна.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл түгээмэл. Хүчин, аллага, заналхийлэл зэрэг хэрэгт ял завших явдал өргөн тархсан бөгөөд улс төрийн хүсэл эрмэлзэл сул, гэм буруутныг мөрдөн шалгах, шүүхэд шилжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал, эцгийн эрхт ёс давамгайлсан зэрэг нь байдлыг улам өөгшүүлж байна.

Доминиканы БНУ-д жендэрт суурилсан хүчирхийлэл гарсаар байгаагийн улмаас охид, эмэгтэйчүүд амь насаа алдах нь нэмэгдлээ. Мексик улсад охид, эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл ихээхэн сэтгэл түгшээж байгаа бол Никарагуа улсад байдал улам хурцадсан.

Ямайка улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд ба жендэрт суурилсан болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид уг гэмт хэрэгт ял завших явдлыг эсэргүүцэн жагслаа.

Колумби улсад манлайлагч эмэгтэйчүүдийн амийг хөнөөх явдал өссөн төдийгүй бэлгийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд шударга ёсыг тогтоох талаар тодорхой ахиц дэвшил гарсангүй. Эмэгтэйчүүдийн байгууллагуудын зүгээс Энхийн хэлэлцээрт бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийн хэргийг шилжилтийн шүүхээр шийдэх заалт оруулж чадсан.

Улс төрийн зорилгоор хоригдсон хоригдлуудын хамаатан садны бүлэг болох Цагаан хувцастай хатагтай нарын бүлгийг Куба улсын эрх баригчид хэлмэгдүүлэлтийн гол бай болгосон.

Канад улсын холбооны засгийн газар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх стратеги баталж, эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг гадаад бодлогынхоо гол цөм болголоо. Парагвай улс 12-р сард эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль хүчин төгөлдөр болсон боловч түүний хэрэгжилтийг хэрхэн санхүүжүүлэх нь тодорхойгүй байна.

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

АНУ-ЫН «GLOBAL GAG RULE»

1-р сард тэгш эрхийн төлөө, ялгаварлан гадуурхалтын эсрэг дэлхий даяар олон нийтийг хамарсан жагсаал цуглаанаас хойш хоёр хоногийн дараа АНУ-ын Ерөнхийлөгч Трамп дэлхийн олон сая охид, эмэгтэйчүүдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулсан “global gag rule” гэгчийг дахин сэргээлээ. Энэ нь үр хөндөлтийн тухай мэдээлэл өгөх, аюулгүй бөгөөд хууль ёсны үр хөндөлт хийлгэх боломж олгох буюу үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх, үр хөндөлтийн үйлчилгээг өргөтгөх нөлөөллийн ажил хийж буй аливаа эмнэлэг, байгууллагуудад үзүүлэх АНУ-ын санхүүгийн туслалцааг зогсоосон юм.

Зөвхөн Латин Америкт жил бүр 760 000 эмэгтэй аюултай үр хөндөлтөөс үүдсэн хүндрэлийн улмаас эмчлүүлж байгаа бөгөөд Ерөнхийлөгч Трампын байр суурь улам олон эмэгтэйчүүдийн амь насыг эрсдэлд оруулж байна.

ҮР ХӨНДӨЛТИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ

Чили улсын Үндсэн хуулийн шүүх зарим тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх шийдвэр гаргаснаар тухайн эмэгтэйн амь нас, эрүүл мэнд эрсдэлд орсон ч үр хөндөлтийг бүрмөсөн хориглодог улсын тоо 7 боллоо. Тэдгээр улсын 6 нь Доминиканы БНУ, Эль Сальвадор, Гайти, Гондурас, Никарагуа, Суринам зэрэг Америк тивийн улс орнууд юм.

Эль Сальвадор улсад хүчингийн гэмт хэргийн хохирогч 19 настай Эвелин Беатрис Хернандез Крузийг үр зулбаж, төрөхийн хүндрэлд орсных нь дараа хүн

амины хүндрүүлсэн хэрэгт буруутгаж, 30 жил хорих ял оноосон. Мөн 12-р сард шүүхээс 2007 онд амьгүй хүүхэд төрүүлсэн Теодора хэмээх эмэгтэйд 30 жил хорих ял оноожээ.

Доминиканы БНУ-ын Сенат зарим тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх хуулийн төслийг дэмжсэнгүй. Түүнчлэн Гондурас улсын конгресс бүх тохиолдолд үр хөндөлтийг хориглосон заалтыг шинэ Эрүүгийн хуульдаа хэвээр үлдээсэн.

Аргентин улсад охид, эмэгтэйчүүд жирэмслэлтээс үүдэн эрүүл мэндэд нь эрсдэл учирч байгаа болон хүчингийн хэргийн улмаас жирэмсэн болсон тохиолдолд ч хууль ёсоор үр хөндүүлэхэд саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг парламентаар хэлэлцэж байна. Уругвай улсын хөдөө орон нутагт бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байдгаас гадна үр хөндөлтийг эсэргүүцэгчид хууль ёсны үр хөндөлт хийлгэхэд ч саад тотгор учруулсаар байна.

10-р сард Парагвай улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам хүний эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, олон талт байдал зэргийн тухай үндсэн мэдээллийг сургалтын материалд оруулахыг хориглосон тогтоол гаргасан.

Эхийн эндэгдлийн голлох шалтгааны нэг нь аюултай үр хөндөлт байдаг Боливи улс Эрүүгийн хуулиндаа хууль ёсны үр хөндөлт хийлгэх боломжийг нэлээд өргөтгөсөн нэмэлт өөрчлөлт оруулсан.

ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР БА ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ

Тус бүс нутаг даяар, тэр дундаа Гайти, Гондурас, Ямайка улсад ЛГБТИ хүмүүс байнгын ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэлд өртсөөр байна.

Боливи улсын Үндсэн хуулийн шүүх бичиг баримтдаа хүйсээ солиулсан трансжендэр хүмүүст иргэний журмаар гэрлэх эрх олгосон хуулийн заалтыг хүчингүй болгох шийдвэр гаргасан. Тус улсын Омбудсман Эрүүгийн хуулинд ЛГБТИ хүмүүсийн эсрэг үзэн ядах гэмт хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгосон.

Доминиканы БНУ-д Руби Мори хэмээх трансжендэр эмэгтэйн мөчилж хаясан цогцос эзгүй газраас олдсон. Оны эцсийн байдлаар уг аллагыг үйлдсэн этгээдийг олж тогтоогоогүй байв.

Уругвай улсад ЛГБТИ хүмүүсийг сургууль, олон нийтийн газарт хүчирхийллээс хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжоор хангах тухай ялгаварлан гадуурхахын эсрэг цогц бодлого байхгүй байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Колумби улсад Энхийн хэлэлцээр байгуулагдсан хэдий ч дийлэнх зүйл заалт нь хэрэгжихгүй байгаа төдийгүй хямрал мөргөлдөөний үед үйлдэгдсэн гэмт хэрэгт ял завших явдал ихээхэн сэтгэл түгшээж байна.

Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл гарсаар байгаа нь Колумбийн Хувьсгалт Зэвсэгт хүчин (FARC) болон хүчний байгууллагуудын хоорондын дотоодын мөргөлдөөн зогсох болоогүй байгаа төдийгүй зарим газарт эрчимжиж байгааг харууллаа. Энгийн иргэнд, ялангуяа уугуул иргэд, Африк гаралтай хүмүүс, тариачид болон хүний эрхийн хамгаалагчид мөргөлдөөний гол золиос болсоор байна.

Оны эхэнд амь насаа алдсан хүний эрхийн идэвхтнүүдийн тоо асар ихээр өссөн нь Колумби улс дахь хүчирхийллийн тухай мэдээллийг түгээгчдэд учирдаг аюул занал ямар их байгааг харуулсан юм.

АФРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Африкийн хүний эрхийн байдал тайван замаар жагсагчдыг хүчирхийлэн нухчин дарж, улс төрийг эсэргүүцэгч, хүний эрхийн хамгаалагч, иргэний нийгмийнхэн рүү ноцтой халдаж байгаагаар дүрслэгдэх болжээ. Мөргөлдөөн хэт удаан үргэлжилж, түүнийг шийдвэрлэж чадаагүй улс төрийн мухардлаас болж иргэдийн эсрэг хүчирхийлэл улам ужгирч байна. Мөргөлдөөний үед үйлдэгдсэн хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл, олон улсын гэмт хэргийг ял шийтгэлгүй өнгөрөөх тойрог үргэлжилсээр.

Тайван замаар эсэргүүцэгчдийг үл хүлцэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө эдлэхийг үл тоомсорлон халдах нь хэвийн үзэгдэл болжээ. Засгийн газрууд өнгөрсөн алдаа, шударга бус үйлдлээсээ суралцах чадваргүй нь харагдаж байна. Ломегаос Фрийтаун, Картумаас Кампала, Киншасагаас Луанда хүртэл гудамжинд тайван замаар жагсагчдыг хоморголон баривчилж, зодож, хүч хэтрүүлэн хэрэглэж, зарим тохиолдолд аминд нь хүрчээ.

Удаан үргэлжилсэн мөргөлдөөн, улс төрийн мухардал, цаад учир шалтгааныг анхааран ажиллаагүй бүсийн болон олон улсын байгууллагуудын алдаа, энэ байдлыг хэвийн үзэгдэл болгож, ял шийтгэл оноохгүй байснаас хүчирхийлэл улам гүнзгийржээ.

Африкийн тогтвортой хөгжлийн талаарх тайланд нэн ядуу байдлыг бууруулах түвшин удаан, эмэгтэйчүүд, залуучууд ядууралд илүү нэрвэгдэж байна гэжээ.

Хавчлага дарамттай тулгарч байгаа ч шударга ёс, эрх тэгш байдал, хүний эрхэм чанарыг хамгаалахын төлөө дуу хоолойгоо өргөх энгийн хүмүүс, хүний эрхийн хамгаалагчдын эр зориг бага гэлтгүй дэлхийн нийтийн анхаарлыг татаж, ахиц дэвшил гарах итгэл төрүүлж байгаа юм. Тухайлбал, дэлхийн хамгийн том дүрвэгсдийн хуаран Дабаабыг засгийн газар хаахаар төлөвлөснийг Кени Улсын Дээд Шүүхээс хориг тавьсныг онцлууштай. Дээд шүүхийн тус шийдвэр Сомали улсын хоёр зуун тавь гаруй дүрвэгчийг нутаг буцан эрх нь ноцтой зөрчигдөх аюулаас хамгаалж чадсан юм. Нигери улсад хүчээр нүүлгэн шилжүүлэх нь хууль бус болохыг, хүчээр нүүлгэхдээ хэрцгий, хүнлэг бус, хүний эрхэм чанарыг доромжлон гутаасан болохыг шүүхийн хоёр шийдвэрээр тогтоож чадлаа.

Анголын Үндсэн Хуулийн Цэц иргэний нийгмийн байгууллагуудыг нухчин дарахаар боловсруулсан хууль нь Үндсэн хууль зөрчиж байгааг тогтоов. Буркина Фасогийн Үндсэн хуулийн төсөл нь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх заалтыг агуулж байхад Гамби улс Олон улсын эрүүгийн шүүхээс гарах шийдвэрээ цуцалж, улс төрийн хоригдлыг суллаж, цаазаар авах ялыг халахаа амлалаа.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ ДАРАМТАЛСАН НЬ

ЖАГСАГЧДЫГ НУХЧИН ДАРСАН НЬ

Тайван замаар эсэргүүцэл илэрхийлэх эрх чөлөөг 20 гаруй улсад хууль бусаар хориглох, заналхийлэх, жагсаалын үеэр хүч хэтрүүлэн хэрэглэх, үндэслэлгүйгээр баривчлах зэргээр үгүйсгэж байна. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хууль давсан журмаар хориглон гажуудуулж байна.

Ангол, Чад, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Этиоп, Судан, Того зэрэг улсад тайван замаар жагсахыг хууль бус хэмээн хуулийн, захиргааны болон бусад арга хэмжээг авч байна.

Анголд хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авахыг заагаагүй ч эрх баригчид тайван замаар жагсагчдыг удаа дараа хориглосоор байна. Чад улс наанадаж зургаан удаагийн тайван дугларалтыг хориглож зохион байгуулагч, оролцогч олон хүнийг баривчилжээ. БНАКУ тайван замаар жагсагчид, ялангуяа улс төрийн хямрал, ирэх сонгуультай холбоотой эсэргүүцэгчдийг хориглож, дарамталсан байна. Судан улсад

иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн сөрөг хүчин, Дарфурт оюутнуудын үйл ажиллагааг хоригложээ.

Олон улсад тайван замаар жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэж, хүчирхийлснээс жагсагчид амь насаа алдах, гэмтэж бэртэх, хууль бусаар баривчлагдах явдал гарлаа. Камерунд англи хэлээр ярьдаг бүсэд жагсаалыг хүчирхийллийн замаар зогсоожээ. Кенийн цагдаа сонгуулийн дараа сөрөг хүчинг дэмжигчид руу аминд хүрэх зэвсэг, нулимс асгаруулагч хэрэглэн, хүч хэтрүүлсний улмаас олон хүн амиа алдсан бөгөөд наад зах нь 33 хүн цагдаад буудуулсны хоёр нь хүүхэд байв.

Того улсад жагсагчдын эсрэг нулимс асгаруулагч цацаж, хүний аминд хүрэх зэвсэг хэрэглэж, тасралтгүй балбаснаас гурван хүүхэд, хоёр зэвсэгт хүчний гишүүн бүхий 10 хүн наанадаж амиа алдав. Сьерра Леоны хууль сахиулагчид Бо хотод багш нарынхаа ажил хаялтыг эсэргүүцэн жагссан оюутнуудын эсрэг гал нээснээс нэг хүн үрэгдэж бусад нь бэртжээ. Угандагийн засгийн газар Үндсэн хуулиас ерөнхийлөгчийн насны хязгаарыг болиулах төслийг эсэргүүцэн тайван замаар жагсах, эсэргүүцэгчдийг дуугүй болгох, зорилгоор баривчилж, сүрдүүлж, заналхийлсэн байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧ, СЭТГҮҮЛЧ, СӨРӨГ ХҮЧНИЙ ИДЭВХТНҮҮД РҮҮ ХАЛДСАН НЬ

Хүний эрхийн хамгаалагч, иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлч, блогчдод халдаж байгаа нь эсэргүүцэгчдийг нухчин дарах явдал түгээмэл болсныг илтгэнэ.

Камерунд иргэний нийгмийн зүтгэлтэн, сэтгүүлч, үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, багш нар хууль бусаар баривчлагдаж, зарим тохиолдолд цэргийн шүүхээр шийтгэгдсэн байна. Засгийн газар нь улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг хоригложээ. Олон хүн үндэсний аюулгүй байдалтай холбоотой хилс хэргээр хоригдсоор байна.

Чадны эрх баригчид засгийн газрыг шүүмжлэгч хүний эрхийн хамгаалагч, идэвхтэй тэмцэгч, сэтгүүлчдийг дуугүй болгох зорилгоор, баривчлан яллаад байна.

Экваторын Гвинейд эдийн засгийн хямралд бухимдсан олонд хариу барьж эсэргүүцэгчдийг сүрдүүлэх, дуугүй болгох гэсэн эрх баригчдын хууль зөрчсөн санаархлыг илчилсэн зүтгэлтнүүдийг баривчлан саатуулжээ.

Эритреад олон мянган үзэл санааны болон улс төрийн хоригдлууд шүүхээр хэргээ шийдвэрлүүлэхгүй, эсвэл гэр бүл өмгөөлөгчтэйгээ уулзахгүйгээр, ихэнх нь 10 гаруй жил хоригдсоор байна.

Этиоп улсад онц байдал зарласан нэрээр өнгөрсөн 6 дугаар сар хүртэл хууль бусаар баривчилсаар байв. 2016 онд онц байдлын улмаас баривчилсан 26000 хүнээс 10000 хүнийг нь суллахыг засгийн газар тушаасан. Гэвч засгийн газрыг шүүмжилдэг олон зуун хүнийг бүрхэг тодорхойлолттой Терроризмийн эсрэг Актын дагуу баривчилжээ.

Мавританд эх орноос урвасан хэмээн цаазын ялтай байсан Мухамед Мхаитир гэх блогч суллагдсан ч, боолчлолын эсрэг тэмцэгч хоёр зүтгэлтэн шоронд байсаар байна.

Мадагаскарын эрх баригчид сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагчдыг дуугүй болгохын тулд сүрдүүлж, заналхийлжээ. Хууль бусаар байгалийн нөөцийг олборлох, худалдаалахын эсрэг дуугарсан хүн бүхэн эрүүгийн хэрэг хүлээх нь нэмэгдэж байна.

Мозамбик улсад эсэргүүцлээ илэрхийлэгчдийг аюулгүйн хүчнийхэн болон үл танигдах этгээдүүд сүрдүүлж, заналхийлж, халдсан байна.

Суданы засгийн газар улс төрийн сөрөг хүчний намын гишүүн, хүний эрхийн хамгаалагч, үйлдвэрчний эвлэлийн идэвхитэн, оюутнуудыг нухчин дарахыг оролдсоор, хууль бусаар баривчлах, хуурамч ялаар хорих, эрүүдэн шүүх болон хэргийг харьцах нь ихсэж байна.

Замби улсад Олон нийтийн хэв журмын тогтоолыг үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар цугларах эрх чөлөөний, ялангуяа шүүмжлэгч иргэний нийгмийн зүтгэлтэн, сөрөг хүчний улс төрийн намын удирдагчдын эсрэг ашиглаж байна. Цагдаа эрх барих намыг дэмжигчид иргэний нийгмийн идэвхтнүүдийн эсрэг

хүчирхийлэл хэрэглэж байгааг үл анхаарах мөртлөө тайван замаар жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэжээ.

Зимбабвед #Thisflag (#Энэтүг) хөдөлгөөнийг үндэслэгч Эван Маварире номлогчид улс төрийн ял оноож 11 дүгээр сард засгийн газар солигдож суллагдтал нь хавчин гадуурхсаар байсан байна.

Угандагийн эрдэмтэн Стелла Ниянзи ерөнхийлөгч, түүний эхнэр, Боловсролын сайдыг Фэйсбүүкээр шүүмжилсний төлөө нэг сар гаруй хоригджээ.

ХУУЛИЙН ДОРОЙТОЛ, УЛС ТӨРИЙН ХУМИГДСАН ОРОН ЗАЙ

Зарим улсын засгийн газар хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлч, сөрөг хүчнийхний үйл ажиллагааг хязгаарлах шинэ хууль гаргах хандлагатай болжээ.

Анголын Парламент үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг ерөнхийд нь хянах эрх бүхий зохицуулах байгууллага бий болгох замаар хязгаарлах заалт агуулсан таван хууль баталжээ.

Зааны ясан эрэг улсад хууль тогтоох байгууллага Ерөнхийлөгчийг доромжилсон, худал мэдээ түгээсэн зэргээр гүтгэлэгтэй холбон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах заалт бүхий хууль баталлаа.

Нигери улсын Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл, Малави улсын нэмэлт өөрчлөлт ТББ-ын болон хүний эрхийн бүлгүүдийн үйл ажиллагаанд хэтрүүлэн халдаж, хууль бусаар хянахаар боловсруулагдсан байна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Мониторинг хийсэн улсуудын талаас илүү хувьд буюу наад зах нь 30 оронд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчдэд эрүүгийн ял тулгаж байна.

Ангол улсад засгийн газар нь эсэргүүцэгчдийг ялангуяа сэтгүүлч, эрдэмтдийг дуугүй болгож нухчин дарах зорилгоор гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэж шударга ёсны тогтолцоог буруугаар ашиглаж байна.

Стелла Ниянзиг дэмжсэний төлөө баривчлагдсан сэтгүүлч Гертруде Увитварег Угандад хорьсон нь Зүүн Африкт хэвлэл мэдээллийн эрх чөлөөг уруудаж байгааг илтгэнэ. Кенид эрх баригчид хэвлэл мэдээллийг дуугүй болгохын тулд заналхийлэл, сүрдүүлэг ашиглаж байна.

Ботсвана улсад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөө сэтгүүлчид сүрдүүлэг, заналхийлэлд өртөж байна. Гурван сэтгүүлчийг Ерөнхийлөгч Иан Камагийн амрах байр барьсныг эрэн сурвалжилсны дараа энгийн хувцастай хамгаалах албаныхан баривчилж, амь насанд нь заналхийлжээ.

Того улс сэтгүүлчдийн ажлаа хийхийг зогсоохоор интернэтийг блоклож, хэвлэл мэдээллийн худалдааны цэгийг хаажээ.

Сэтгүүлч, блогч зэрэг идэвхтнүүдийг Этиоп улсад хорьж, терроризмийн хэрэг үйлдсэн хэмээн бүрхэг тодорхойлсон Терроризмийн эсрэг Актын дагуу яллаж байна.

Камеруны цэргийн шүүх Радио Франс Интернэшнлийн сэтгүүлч Ахмед Аббаг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэснийх нь төлөө шударга бусаар шүүн 10 жилийн хорих ялаар шийтгэжээ. Давж заалдах шатны шүүхээс түүнд оногдуулсан ялыг 24 сар болгосны дараа арванхоёрдугаар сард суллагдсан байна.

СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ УЛС ТӨРИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА НУХЧИН ДАРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Айдас, сүрдүүлэг, хүчирхийлэл Кени улсын ерөнхийлөгчийн сонгуулийг гутаалаа. Сонгуулийн дараа эсэргүүцэн жагсагчдын эсрэг цагдаа хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас олон хүн амь үрэгдсэн ба тэдний 33 нь цагдаад буудуулсан байна. Дээд шүүхээс сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцсоны дараа шүүхийн хараат бус байдалд эрх баригч намын удирдах албан тушаалтнуудаас удаа дараа халдаж, заналхийлсэн байна. ТББ-ыг

зохицуулах зөвлөл сонгуулийн үйл явцыг шүүмжилсэн хүний эрхийн болон засаглалын байгууллагуудыг хаах, шийтгэлийн арга хэмжээ авахаар заналхийлжээ.

Руандагийн одоогийн ерөнхийлөгч Паул Кагаме Үндсэн хуульд өөртөө гурав дахь удаагаа сонгогдох эрх олгох өөрчлөлт оруулан 8 дугаар сарын ерөнхийлөгчийн сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулжээ. Сүүлийн хорь гаруй жил улс төрийн сөрөг хүчин, хараат бус хэвлэл мэдээлэл, хүний эрхийн хамгаалагчид руу халдан айлгасан уур амьсгалд сонгууль явагдлаа. Ерөнхийлөгчийн сонгуульд боломжит нэр дэвшигчдийг онилон гүжирдэх кампанит ажил явуулжээ.

Анголын 8 дугаар сарын сонгуулийн бэлтгэл үед авилга, хүний эрх зөрчсөнийг илчилсний төлөө сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагчдыг удаа дараа сүрдүүлсэн нь тэмдэглэгджээ. Жагсагчид цагдаагийн баривчилгаа, хүч хэтрүүлэн хэрэглэх явдалтай тулгарч байв.

Бурунди улсад хууль бус аллага, баривчилгаа, улс дамнуулан сураггүй алга болгох зэргээр улс төрийн дарангуйлал өргөн дэлгэрчээ.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН, ХҮЧИРХИЙЛЭЛ

Хэдийгээр Африкийн мөргөлдөөнүүд нь онцлог, явцын хувьд ялгаатай боловч хүний эрхийн хүчирхийлэл, олон улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдох үйлдэл бүхий олон улсын хүмүүнлэгийн хуулийн зөрчил их байгаа ерөнхий шинжтэй байна.

Улс төрийн мухардлыг шийдвэрлэх бүсийн байгууллага үлгэн салган арга хэмжээ авах зуур Өмнөд Суданы 14 жил үргэлжилсэн мөргөлдөөний улмаас олон сая хүн орон гэрээсээ дайжин амиа алдаж, ихээхэн хохироод байна. Дээд Нилийн бүсэд олон мянган иргэд армийнхан гэрийг нь шатааж, галдаж, зохион байгуулалттайгаар тонон дээрэмдэж, бэлгийн хүчирхийлэл үйлдэх нь багасаагүйн улмаас хүчээр шилжин суурьшихад хүрчээ.

Суданд Дарфур, Цэнхэр Нил, Өмнөд Кордофан мужуудад олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийг зөрчсөн, аюулгүй байдал, хүмүүнлэгийн нөхцөл байдал аймшигтай хэвээр байна.

Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ)-д мөргөлдөөн эргэн дэгдсэн нь хүний эрхийн зөрчил хүчирхийлэл, олон улсын хуулийн эсрэг гэмт хэрэг их гарахад хүргэв. Засгийн газрын хяналтанд байгаа нийслэлээс гадуур зэвсэгт хүчин олон зөрчил гаргаж, НҮБ-ын энхийг сахиулах цэрэг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл үйлдсэн тухай мэдээлэл гарсаар байна.

БНАКУ-д Касай мужид урьд үзэгдээгүй хүчирхийлэл гарснаар олон мянган хүн амь үрэгдэж, 1 сая хүн дотооддоо шилжин суурьшиж, 35000 хүн хөрш Ангол руу дайжихад хүрчээ. Конгын армийн цэргүүд Камуэна Нсапу, зэвсэгт босогчдын бүлгийн гишүүн, дэмжигч хэмээн сэжиглэн хүч хэтрүүлэх, аминд халдах зөрчил гаргасны хариуд босогчид хүүхдийг цэрэгт татан, иргэд, засгийн газрын хүчний эсрэг дайрч байна. Бана Мура гэх засгийн газрын итгэмжилсэн зэвсэгт бүлэг угсаатны эсрэг аллага, бэлгийн хүчирхийлэл, иргэний өмчийг сүйтгэсэн олон халдлагыг хариуцах ёстой.

Бого Харамын зэвсэгт бүлэг хүчирхийлэл, дайны гэмт хэрэг үйлдсээр байгаагийн хариуд Камерун, Нигерийн аюулаас хамгаалах хүчин хүний эрхийн зөрчил, олон улсын хуулиар гэмт хэрэг ихээр үйлдсээр байна. Үүнд шүүхээс гадуур цаазлах, хүчээр сураггүй алга болгох, хууль бус баривчилгаа, ганцаарчлан хорих, эрүүдэн шүүх, зүй бус харьцах, зарим тохиолдолд хорих газарт амиа алдахад хүргэх зэрэг зөрчил орно. Камерунд Бого Харамыг дэмжсэн хэмээн хүмүүсийг буруутган энэ онд гүйцэтгээгүй байгаа ч цэргийн шүүхээр шударга бусаар шүүн цаазаар авах ял оноогоод байна. Нигери улсад зэвсэгт хүчин олон мянган хүнийг хууль бусаар баривчлан, хүнд нөхцөлд ганцаарчлан хорьжээ. Нигерид Мали улстай хил залгаа баруун бүсэд онц байдал зарлаж, Диффа мужид онц байдлаа сэргээн Бого Харамын гишүүнээр сэжиглэн, 1300 гаруй хүний ихэнхийг өмгөөлөгчгүйгээр шүүжээ.

ЗЭВСЭГТ БҮЛЭГЛЭЛИЙН ХАЛДЛАГА

Ал-Шабааб, Боко Харам зэрэг зэвсэгт бүлэглэлүүд Камерун, ТАБНУ, БНАКУ, Мали, Нигер, Нигери, Сомали зэрэг улсад иргэдийн эсрэг хүчирхийлэл, халдлага үйлдсэн байна. Зарим тохиолдолд олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийг ноцтой зөрчжээ.

Чад нуурын сав газарт Боко Харам томоохон дайны гэмт хэрэг үйлджээ. Боко Харам иргэд рүү халдаж, аминд нь хүрч, улмаар иргэдийн шилжилт суурьшилтыг нэмэгдүүлээд байна. Камерун, Нигерид түгсэн халдлагаас олон зуун хүн амь үрэгдлээ. Нигерийн зүүн хойд Чибок нутгаас сургуулийн 82 охин хулгайлсан нь тавдугаар сард илэрснээс гадна олон мянган охид, эмэгтэйчүүд, залуус хулгайлагдаж бэлгийн хүчирхийлд өртөх зэргээр хүчирхийлүүлсэн явдал тоолшгүй их байна. 1,7 сая гаруй хүн Нигерийн зүүн хойд нутгаас дайжиж, өлбөрч үхэхийн даваанд хүрчээ.

Мали улсад иргэд, энхийг сахиулагчдын эсрэг зэвсэгт бүлэглэлийнхний халдлага хойноос төв нутаг хүртэл тархаж улсын хэмжээнд онц байдлыг 10 дугаар сар хүртэл дахин нэг жилээр сунгалаа.

10 дугаар сард ал-Шабааб одоогийн байдлаар Сомалийн нийслэл Могадишуд иргэдийн эсрэг халдлага үйлдэн 512 гаруй хүн нас барсан байна.

ЭРҮҮ ШҮҮЛТ, ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Эрүү шүүлт, зүй бус харьцаа Буркина Фасо, Камерун, Эритрея, Этиоп, Мавритан, Нигери, Судан зэрэг олон улсад бүртгэгдлээ.

Камеруны аюулаас хамгаалах хүчнийхэн Боко Харамыг дэмжсэн гэж үндэслэлгүйгээр хүмүүсийг сэжиглэн эрүүдэн шүүсэн нь дайны гэмт хэрэгт тооцогдох хүчирхийлэл бөгөөд эдгээр гэмт хэргийг ял шийтгэлгүй өнгөрөөж байна.

Этиоп улсад терроризмийн хэрэгт буруушаагдсан хоригдогсод мөрдөн байцаах явцад цагдаа эрүүдэн шүүж, хэрцгий харьцсан болохыг шүүхэд мэдүүлсэн байдаг. Шүүхээс зарим хэргийг Этиопын Хүний Эрхийн Комисс мөрдөн шалгахаар шийдвэрлэсэн ч мөрдөн шалгах үйл явц нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг мөрдөж чадсангүй. Арванхоёрдугаар сард гарсан нэгэн нааштай алхам бол Нигери Эрүүдэн шүүхийн эсрэг хууль баталсан явдал юм.

ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС

Урт удаан үргэлжилсэн мөргөлдөөн, ужгирсан хүмүүнлэгийн хямрал, хүний эрхийн зөрчлөөс олон сая хүн орон гэрээ орхин, хамгаалалт эрэн дайжиж байна. Дүрвэгч, цагаачид хүчирхийлэлд өртөж, эрхээ зөрчүүлэх нь түгээмэл. Африкийн улсуудад байрлах сая сая дүрвэгсэд олон улсын дэмжлэгийг зохистой хүртэхгүй байна.

НҮБ-ын Дээд Комиссарын газар, Дүрвэгсдийн байгууллагын мэдээлснээр Сомали улсад үргэлжлэх мөргөлдөөн, ган гачигаас тус улсын хүн амын тал хувьд хүмүүнлэгийн туслалцаа хэрэгтэй байна гэжээ. Энэ онд сая гаруй хүн мөргөлдөөн, ган гачигаас болж дотооддоо шилжин суурьшихад хүрсэн бөгөөд үүн дээр 1.1 сая хүн дотооддоо хамгаалалтгүй албан бус сууринд аюултай нөхцөлд амьдарч байна.

Кени улсад Сомалигаас ирсэн 285000 дүрвэгч, орогнол эрэгчдэд хамгаалалт яаралтай хэрэгтэй хэвээр байна. 2 дугаар сард Дээд Шүүхээс олон улсын хуулийг зөрчиж 260000 Сомали дүрвэгсдийг хүчээр нутаг буцаахад хүргэх үр дагавартай Дабаабын дүрвэгсдийн хуаранг хаах засгийн газрын бие даан гаргасан шийдвэрт хориг тавьжээ. Дабаабыг хаалгүй үлдээсэн ч Сомалигаас шинээр ирэгсдийг Кенийн засгийн газар бүртгэхээс татгалзаж байна. 74000 дүрвэгч 2014 оны 12 дугаар сараас 2017 оны 11 дүгээр сарын хугацаанд Дабаабаас Сомали улсад сайн дураараа эргэн очих үйл ажиллагааны хүрээнд нутаг буцжээ. Эх оронд нь буцаахдаа “сайн дураараа эргэн очих”, эргэн очиход Сомали улсад үргэлжилж байгаа мөргөлдөөн, ган гачгаас хамгаалагдсан, нэр төртэй байх нөхцлийг үл харгалзсан байна.

ТАБНУ—ын олон мянган хүн хөрш орнууд руугаа юмуу дотооддоо мөргөлдөөнөөс зугатан хамгаалалт эрэн дайжиж түр хуаранд амьдарч байна.

Чад нуурын сав газар дахь Боко Харамтай тэмцэх мөргөлдөөн, цэргийн үйл ажиллагаанаас олон сая хүн гэрээ орхиод хүрлээ. Нигерид наанадаж 1.7 сая хүн зүүн хойд нутгийн Борно, Ёбе, Адамава мужуудаас дотооддоо шилжин суурьшив. НҮБДКГ-аас зүүн хойд нутагт 5.2 сая хүнд яаралтай хүнсний тусламж хэрэгтэй, 450000 гаруй таваас доош насны хүүхдэд тэжээлийн тусламж шаардлагатай байгааг мэдээлжээ. Чад улсад ТАБНУ, БНАКУ, Нигери, Суданаас ирсэн 408000 гаруй дүрвэгч дүрвэгсдийн хуаранд хүнд нөхцөлд амьдарч байна.

Ботсвана дүрвэгсдийн шилжилт хөдөлгөөний эрх чөлөөг хязгаарлаж, хөдөлмөрлөхийг хориглон, орогнол эрэгсдийн статусыг тогтоохдоо удаж, саатуулж байна.

Үндэсний армид тодорхойгүйгээр алба хаахыг тулгах, хүний эрхийн нөхцөл таагүй байгаагаас олон мянган хүн Эритреаг орхин явсаар байна. Гэвч замдаа болон очсон улсдаа хүнд бэрх хүчирхийлэлтэй тулгарч, хууль бусаар хоригдож, Европ руу явах замдаа бэлгийн хүчирхийлэл, хэрцгийлэлд өртөж байна. Судан 8 дугаар сард 100 гаруй дүрвэгчийг хүний эрхийг ноцтой зөрчих, олон улсын хуулийг зөрчих эрсдэл бүхий Эритреа улсад буцаажээ.

Өмнөд Суданд, 1 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд өлсгөлөн, хэрцгийлэлд хүргэсэн Экваторийн бүсийн байлдаан хурцадмал болсноос 340000 орчим хүн дүрвэв. Ихэнхдээ засгийн газар, зарим тохиолдолд сөрөг хүчин өмнөд бүсэд иргэдийн эсрэг дайны гэмт хэрэг зэрэг ноцтой зөрчил, хүчирхийлэл, олон улсын гэмт хэрэг үйлджээ. 3.9 сая гаруй хүн, тус улсын гуравны нэг орчим нь 2013 оны 12 дугаар сард мөргөлдөөн эхэлснээс хойш дайжаад байна.

Өмнөд Суданы 2 сая гаруй дүрвэгсдэд хөрш орнууд маш бага туслалцаа үзүүлээ. Уганда 1 сая гаруй ихэнх нь хүүхэд дүрвэгчийг хүлээн авсан. Гэвч багассаар байгаа олон улсын санхүүжилтээс илүү өргөн хүрээнд дүрвэгчийг хүндлэх бодлогоо хэрэгжүүлэхэд бэршээлтэй тулгараад байна. Иймээс Угандагийн засгийн газар, НҮБДКГ, ТББ-ууд дүрвэгсдийн үндсэн хэрэгцээг хангахын тулд ихэд чармайх болоод байгаа юм.

ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ӨНГӨРӨӨХ НЬ

Шударга ёсыг тогтоохгүй, залруулахгүй, холбогдох гэмт этгээдэд хариуцлага тооцохгүй байгаа нь хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл газар авч байгаагийн гол хүчин зүйл болсоор байна.

ТАБНУ-д тус улсын 14 жилийн мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн олон улсын хуулийн эсрэг гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн байж болзошгүй хувь хүмүүсийг шүүх Эрүүгийн Тусгай Шүүхийг ажиллуулан зарим дэвшил гарав. Тусгай Шүүхийн Прокурор 5 дугаар сард ажлаа эхэлсэн ч шүүхийн үйл ажиллагаа явагдаагүй ял шийтгэлгүй үргэлжлэх явдал хэвээр байсаар байна.

Өмнөд Суданд 2015 онд энх тайвны гэрээгээр шударга ёсыг тогтоох шилжилтийн үеийн гурван байгууллагатай болохоор тогтсон ч одоо болтол байгуулагдаагүй байна. 7 дугаар сард Африкийн Холбоо (АХ) засгийн газар хоорондын гэрээгээр Өмнөд Суданы Холимог Шүүх байгуулах хамтын зураглалыг гаргаж, шүүхийг байгуулах арга хэрэгслийн талаар хэлэлцсэн ч албан ёсоор баталсан зүйлгүй байна.

Нигери улс Хүний эрхийн томоохон зөрчлийг шалгах Мөрдөн байцаах тусгай зөвлөлийг армиас байгуулж олон улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн цэргийн командлагчдыг тогтоосон ч хараат бус ба шударга байдлын хооронд гацжээ. Тайланг олон нийтэд ч танилцуулсангүй.

БНАКУ-д 3 дугаар сард Касай төв мужид НҮБ-ын хоёр шинжээчийг алж, Конго үндэстэн орчуулагч, гурван жолоочийг нь сураггүй алга болгосон нь тус бүс нутагт хүчирхийллийг яаралтай зогсоох шаардлагатайг илтгэнэ. Конгийн эрх баригчдын мөрдөн шалгах үйл ажиллагаа ил тод, итгэлтэй байсангүй. 6 дугаар сард НҮБ-

ын Хүний эрхийн зөвлөл БНАКУ-д мөрдөн шалгахад туслуулахаар олон улсын шинжээчдийн багийг илгээхээр шийдвэрлэсэн. 7 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар 2018 оны 6 дугаар сард тайлагнах гурван хүнтэй багийг томиллоо.

Этиопт 2015, 2016 онд үйлдсэн хэрэгтээ цагдаа, армийнхан ял завшсаар байна. Засгийн газар улсынхаа янз бүрийн мужуудад үйлдэгдсэн хүчирхийлэлд хараат бус шударга мөрдөн шалгалт явуулахаас татгалзлаа.

Сенегалд Африкийн Тусгай Шүүх Чадын ерөнхийлөгч асан Хиссене Хабрег дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, эрүүдэн шүүсэн гэмт хэрэгт буруутган бүх насаар нь хорих ял оноолоо.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ

Бурунди улс ОУЭШ-ийн Ромын дүрэмд нэгдсэнээсээ татгалзсан анхны улс боллоо. Гэхдээ 11 дүгээр сард ОУЭШ-ийн Прокурорт 2015 оны 4 дүгээр сараас 2017 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд Бурунди улсад үйлдэгдсэн хэргийг мөрдөн шалгах эрх олгож байгаагаа нээлттэй зарласан юм.

ОУЭШ-ээс татгалзах хоосон уриалгыг эс тооцвол Африкт ахиц гарч байна. Африкийн Холбооноос ОУЭШ болон бусад талтай хамтрах төлөвлөгөөг батлах шийдвэр гаргалаа. Бөөнөөр татгалзах хандлагын эсрэг Сенегал, Нигери, Кэйп Верде, Малави, Танзани, Тунис, Замби, Либерийн улс ОУЭШ-ийг дэмжиж байгаагаа илэрхийллээ.

Гамби улсын шинэ засгийн газар Ромын дүрмээс гарснаа буцаасан бол Ботсван улсын парламент дотоодын хуульдаа Ромын дүрмийг суулгасан хууль баталлаа.

3 дугаар сард Өмнөд Африкийн засгийн газар Хойд Гаутенгийн дээд шүүхээс парламенттай зөвлөлдөхгүйгээр ОУЭШ-ээс татгалзах шийдвэр гаргасан нь үндсэн хууль зөрчсөн тул хууль бус хэмээн тогтоосны дараа 2016 онд Ромын дүрмээс гарахыг санаархсан шийдвэрээ цуцалжээ.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Соёл уламжлалаас үүдэлтэй, шударга бус хууль тогтоосноос охид эмэгтэйчүүдийг ялгаварлах, гадуурхах явдал олон оронд оршсоор байна. Мөргөлдөөнтэй, дүрвэгчид болон дотооддоо шилжин суурьшигч ихтэй улсуудад охид эмэгтэйчүүд бэлгийн болон бусад хүчирхийллийн бай болж байна.

Сьерра Леон, Экваторын Гвиней улсад жирэмсэн охидыг сургуулиас гаргаж байна. 6 дугаар сард Танзанийн Ерөнхийлөгч жирэмсэн охидыг улсын сургуульд суухыг хориглож байгаагаа зарласан нь бэлгийн хүчирхийллийн хохирогч, охидыг улам ялгаварлах, ичгэвтэр байдалд оруулахад хүргэж байна.

Либерийн, Малави, Мозамбик, Өмнөд Африк, Свазиланд зэрэг хэд хэдэн улсад охид эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл түгээмэл болжээ.

Буркина Фасо зэрэг улсуудад эм, эмнэлгийн хэрэгсэл, мэргэжилтэн дутмагаас жирэмсэн эмэгтэй, охид төрөхийн хүндрэл, халдвар авах, амиа алдах өндөр эрсдэлтэй байна. Уламжлал нэрээр охидын бэлэг эрхтэнийг гэмтээх нь буурсан ч хуулиар хориглоогүй тул оршсоор байна.

Үр хөндөлтийн тухай хуульд ахиц гарч байгаа ч Өмнөд Африкт хуулийн дагуу үр хөндүүлэх үйлчилгээ авахад нь охид эмэгтэйчүүд хүндрэл учирдагаас аюултай нөхцөлд үр хөндүүлэн, эрүүл мэнд, амиа ч алдах эрсдэлд орж байна. Засгийн газар үр хөндөлт хийхээс татгалзсан эмч нарт анхаарал хандуулахгүй байна.

Африктаа эхийн эндэгдлээр хамгийн өндөр оронд Либерийн улс орж байгаагийн шалтгаан нь хүчирхийллийн хохирогчдод хэт үнэтэй, хүртээмжгүй байгаа байдал аж.

Анголд засгийн газар Эрүүгийн хуульдаа зарим тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөн барьсан ч парламентын санал хураалтаар тодорхойгүй хугацаагаар батлахыг хойшлуулжээ.

АЛБИНИЗМТАЙ ХҮМҮҮС

Цагаарсал буюу албанизмтай хүмүүсийн хар шидийн талаар мухар сүсэг тархсан байдгаас Малави, Мозамбик улсад тэдэн рүү халдах явдал хүчтэй байдаг бөгөөд хулгайлж, амийг нь хөнөөж байна. Мозамбик улсад долоон настай хүүг гэрээс нь хулгайлан үл таних хүмүүс хороожээ. Олон нийт эсэргүүцэж байгаа ч засгийн газар дорвитой алхам хийхгүй байна.

ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР, ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ

Сенегал, Гана, Малави, Нигери зэрэг орнуудад ЛГБТИ хүмүүс ялгаварлал, мөрдлөгтэй тулгарч, хүчирхийлэлд өртөж байна.

Либерид улсад 2016 онд нэгэн залуу эрүүгийн хуулиар ‘зориуд бэлгийн гаж харилцаа үйлдсэн’ гэж буруутгагдан баривчлагдаж шүүх хурлаа хүлээж байна. Нигерид бэлгийн чиг хандлагаас нь шалтгаалан баривчлах, олон нийтийн өмнө гутаан доромжлох, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах тохиолдлууд гардаг талаар мэдээлжээ.

Бостван улсын Дээд шүүх Засгийн газарт трансжендэр хүний бичиг баримт дээрх хүйсийн тэмдэглэгээг өөрчлөх шийдвэр гаргасан нь үндэслэлгүй бөгөөд хүний эрхийг зөрчсөн явдал болно хэмээн тогтоожээ.

АЛБАДАН НҮҮЛГЭЛТ БА ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Өсөн нэмэгдэж буй хотжилт, ажилгүйдэл, ядуурал, тэгш бус байдлын улмаас олон улс иргэдээ хүртээмжтэй, худалдаж авахуйц, амьдрахад тохиромжтой шаардлагатай орон байраар хангах чадахгүй байна.

Этиопын нийслэл хотын захын хогийн цэг дээрх овоолго нурснаас болж 115 гаруй хүн нас баржээ. Хохирогчдын ихэнх нь хогийн цэгний ойролцоо амьдарч байсан бөгөөд хог хаягдлаар амьдралаа залгуулдаг байжээ.

Гвиней улсад хогийн цэг дээрх овоолго нурснаас багадаа 2 хүүхэд бүхий 10 хүн, нас барсан байна.

Нигери улсын Лагос хотын удирдлагууд хөрш зэргэлдээ Отод-Гам, Илубрин боомтын дүүргээс 5000 гаруй хүнийг албадан нүүлгэж, аюулгүйн албаныхан нулимс асгаруулагч хий, сумаар буудсан байна. Энэ нь тус газрыг хориглосон Дээд шүүхийн шийдвэрийг эрх баригчид зөрчсөн явдал байлаа.

Нөгөөтэйгүүр Нигер улсын Дээд шүүхээс Абужа дахь Мпапе сууринг татан буулгах нь хууль бус гэж шийдвэрлэн хэдэн зуун мянган оршин суугчдад дэмжлэг үзүүлжээ. Шүүхээс эрх баригчдыг албадан нүүлгэх шийдвэрээ түдгэлзүүлэхийг үүрэг болгосон ба хүртээмжтэй, орон сууцтай байх эрхийг хангах бодлого боловсруулах шаардлагатайг сануулжээ.

БИЗНЕС БОЛОН КОРПОРАЦИЙН ХАРИУЦЛАГА

БНАКУ-д хүүхдүүд болон насанд хүрэгчид өдөрт нэг доллар олохын төлөө кобалтын уурхайд ажиллан амь нас, эрүүл мэндээ эрсдэлд оруулж байна. Өмнөд Африкт үйл ажиллагаа явуулдаг Их Британий Вант улсын Лонмин Пи-эл-си хэмээх асар том цагаан алтны уурхай 10 гаруй жилийн өмнөөс 5500 шинэ орон байр барих үүрэг даалгавартай байсан ч ажилтнууд нь Мариканад ядуу зүдүү амьдарсаар байна. 2012 онд уурхайн тааруу нөхцөлийг эсэргүүцсэн 34 хүний амиа алдсан явдалд хэн ч хариуцлага хүлээгээгүй аж.

Үүнтэй зэрэгцэн олон улс оронд корпорацийн хариуцлага шаардсан олон нийтийн шахалт, үйл ажиллагаа нэмэгдлээ.

Нидерландад Шелл корпорацийг 1995 онд Нигерийн армид хууль бусаар баривчлагдаж, цаазлагдсан Огони есийн хэрэгт хамтран оролцсон хэмээн

буруутгасан хэргийг 6 дугаар сард олон нийтэд дэлгэсэн нь онцлох явдал байлаа. 1990-ээд оны үед Огониланд дахь Нигерийн аюулаас хамгаалах хүчний үүрэг болгосон хүний эрхийн эдгээр ноцтой зөрчлийг мөрдөхийг олон улсын байгууллагуудаас Шеллд мөн уриалав.

Зарим засгийн газрууд эерэг алхам хийлээ. БНАКУ-ын засгийн газарт 2025 он гэхэд уул уурхайн салбарт хүүхэд хөдөлмөрлөх асуудлыг эцэслэхийг даалгасан нь долоо хүртэлх насны хүүхдийн хөдөлмөрийг уул уурхайн аюултай ажилд ашиглах явдлыг арилгахад чиглэсэн чухал алхам болох юм. Гана улс алтны бичил уурхайд мөнгөн ус ашиглахыг бууруулах НҮБ-ын мөнгөн усны Минаматагийн Конвенцийг соёрхон батлав.

ЦААШДЫН ТӨЛӨВ

2017 оныг харвал Африкт хүний эрхийн байдал урт хугацаанд ужирсан сорилттой тулгарч байгаа ч өөрчлөгдөх найдвар, боломж гарч ирж байна. Бүс нутаг даяар өөрсдийн амь нас, эрх чөлөөгөө үргэлж эрсдэлд оруулан байж хүний эрх, шударга ёсны төлөө тэмцсэн тоо томшгүй олон хүмүүс энэ найдварыг төрүүлэх үндэс болж байна.

Африкийн бүс нутгийн байгууллагууд эерэг өөрчлөлт бий болгох гол түлхүүр хэвээр, олон боломжийг бас дэлгэсэн юм. Африкийн Холбоо 2020 он гэхэд 'буун дуугүй' болгох эрмэлзэл ихтэй амлалтаа биелүүлэх төлөвлөгөөг жилийн туршид хэлэлцэн баталсан. Үүнд үйл ажиллагаандаа, энх тайван болон аюулгүй байдалд нөлөөлөхөд нөөцөө бүрэн дайчлах зэргийг агуулсан шинэчлэлийн томоохон төлөвлөгөө эхлүүлжээ. Асуудлыг бүхэлд нь харж, зөрчил үүсгэж буй үндсэн шалтгаануудад анхаарах Африкийн холбооны энэ эхлэл иргэдийг илүү сайн хамгаалах, хүний эрхийг хүндэтгэх, ял завших явдлыг зогсоох бодит боломж олгох юм.

Энэ жил мөн Африкийн хүний болон ард түмний эрхийн комисс байгуулагдсаны 30 жилийн ой тохиосон ба хэдийгээр олон сорилттой тулгарсан ч баримт бичгүүд, стандартын жагсаалтыг боловсруулсан нь хүний эрхийг хамгаалах, дэмжихэд чухал хувь нэмэр оруулсан билээ. Зөвхөн 2017 онд тус комисс 13 баримт бичиг баталсан бөгөөд Хүний болон Ард түмний эрхийн тухай Африкийн тунхаг бичиг, Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн талаарх Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн Тунхаг түүний протоколын ерөнхий тодорхойлолтыг илүү нарийвчилсан юм.

Тус комисс энэ амжилтандаа тулгуурлан үйл ажиллагаа, тогтолцоогоо шинэчилж бэхжүүлэхэд чиглэн ажиллах, улмаар Комиссын шийдвэр, зөвлөмжийг улс орнууд хэрхэн хэрэгжүүлэхэд баримтлах журам, нэгтгэсэн тайлан гаргах удирдамжийг нэг багц болгон боловсруулах шаардлагатай аж.

ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Иргэний нийгмийн орон зай Европ, Төв Азийн бүсэд улам хумигдсаар байна. Зүүн Европ, Төв Азид хүний эрхэд дайсагнасан явуулга түгээмэл байна. Хүний эрхийн хамгаалагч, идэвхитэн тэмцэгч, сэтгүүлчид, сөрөг хүчнийхэн эрх баригчдын бай болох нь олонтаа тохиолдож байна. Бүс нутаг даяар үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд халджээ. Олон нийтийн жагсаал цуглааныг төрөл бүрээр хязгаарлаж, цагдаа хүч хэтрүүлэн хэрэглэж тарааж байна. Засгийн газрууд терроризмийн эсрэг арга хэмжээ авч байна хэмээн аюулаас хамгаалах нэрийдлээр иргэдийн эрхийг зохисгүйгээр хязгаарласаар. Нийгмийн хамгаалал багасч, сая сая хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн байдал доройтсоноор, тэгш бус байдал, системтэйгээр ялгаварлах явдал улам газар авав. Улс орнууд дүрвэгч, цагаачдыг хамгаалах хариуцлагаа умартсаар байна. Охид, эмэгтэйчүүд эрүү шүүлт, зүй бус харьцаа, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг системээс үүдэлтэй хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлд өртсөөр байна. Цөөнхүүд ялгаварлагдан, адлагдаж, заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн хэвээр. Үзэл санааны зарим хоригдлуудыг суллалаа.

60 гаруй жилийн түүхэнд анх удаа 2017 онд Эмнести Интернэшнлийн секцийн дарга, захирал хоёр үзэл санааны хоригдол боллоо. 6 дугаар сард Туркийн Эмнести Интернэшнлийн дарга Танер Киликийг баривчлав. “Станбулын 10” хэмээн алдаршсан Туркийн Эмнести Интернэшнлийн захирал Идил Эзер зэрэг хүний эрхийн хамгаалагчдыг 7 дугаар сард сургалтанд оролцож байхад нь баривчлан саатуулжээ. Станбулын 10 болон Танер Килик нарыг дараа нь терроризмийн эсрэг үйл ажиллагаа явуулсан хэмээн яллаж буйгаа мэдэгдсэн нь 2016 онд төрийн эргэлт хийх оролдлого нурснаас хойш иргэний нийгмийг дарангуйлах гэсэн хандлага түгсэнийг илэрхийлнэ. Оны эцсээр Станбулын 10-ыг батлан даалтаар сулласан ч, Танер Киликийг хорьсон хэвээр байна. Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх нотолгоо олж чадаагүй ч хилс ял тулган 15 хүртэлх жил хорих ял төлөвлөн шүүх ажиллагаа үргэлжлэх төлөвтэй байна.

Туркэд эсэргүүцэгчдийн дуу хоолойг нухчин дарж байгаа нь Европ, Төв Азид иргэний нийгмийн орон зайг хумьж буй нийтлэг үзэгдлийн нэг юм. Хүний эрхийн хамгаалагчид олон сорилт бэрхшээлтэй тулгарч, ялангуяа эвлэлдэн нэгдэх, цуглах эрх чөлөөнд халдах боллоо. Зүүн бүсэд хүний эрхийн хамгаалагчид, улс төрийн сөрөг хүчнийхэн, авлигын эсрэг кампанит ажил, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэгчид, бэлгийн цөөнхийг байнга дарангуйлж хүний эрхэд дайсагнасан хандлага их байна. Дайсагнасан хандлага баруун зүг чиглэн Унгар улсад гадаадаас санхүүжилт авдаг ТББ-ыг хязгаарласан хууль баталснаар эрх зүйн орчныг боомилж эхэлсэн юм.

Барселон, Брусель, Лондон, Манчестр, Парис, Стокхольм, Санкт Петербург хотууд болон Туркийн олон хэсэгт халдлага гарч хүмүүсийг бэртээж, аминд нь хүрчээ. Үүний хариуд засгийн газрууд аюулаас хамгаалах, терроризмийн эсрэг нэрийн дор хүмүүсийн эрхийг зохисгүйгээр хязгаарлах болов.

Олон сая хүн эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдэлж чадахгүй болоод байна. Улмаар олон оронд нийгмийн хамгаалал буурч, тэгш бус байдал гүнзгийрч, ялгаварлал системтэй явагдах боллоо. Ядууралд хамгийн их нэрвэгдсэн хүмүүст эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуу эсвэл цалин багатай ажилчид, хөгжлийн бэршээлтэй хүмүүс, цагаачид, орогнол эрэгчид, үндэсний цөөнх, тэтгэврийн болон ганц бие хүмүүс орж байна.

Бүс нутаг даяар засгийн газрууд дүрвэгсэд, цагаачдыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй тохиолдол удаа дараа гарав. Европын Холбоонд хууль бусаар хүрч ирсэн дүрвэгч, цагаачдын тоо жилийн хагасаас эрс буурсан нь Ливи улсын эрх баригчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан тус улсад гацсан хүмүүс хүчирхийлэлд өртөж байгаад харалган хандах, зарим нөхцөлд хавсарч эрхийг нь зөрчсөнөөс

болжээ. Европт ирж чадсан хүмүүст ч амь нас, эрх чөлөө нь эрсдэлд орох Афганистан зэрэг улс руу хүчээр буцаагдах аюул тулгарчээ.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл дээр Орос улс Сирийн засгийн газрын дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс гарах үр дагаварт хариуцлага тооцогдохоос хайцаалан ес дэх удаагаа хориг тавилаа. Оросын удаа дараагийн энэ хориг нь Сирийн мөргөлдөөнд оролцогч талууд ял шийтгэл хүлээлгүй өнгөрч байхад ард иргэд нь хамгийн их төлөөс төлөхөд хүргэн дайны гэмт хэрэгт найр тавьж байгаатай дүйж байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Зүүн Европ, Төв Азид иргэний нийгмийг төрөл бүрээр заналхийлж, хязгаарлаж байна. Беларусь, Орос улсад хэдэн арван хүн хэвлэл мэдээлэл, ТББ, жагсаал цуглааныг хориглосон хуулиас болж тайван замаар идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлсний төлөө хоригдож, үзэл санааны хоригдол болжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үл хүндэтгэн, Тажикстаны эрх баригчид шүүмжлэлт дуу хоолойг дарахын тулд хатуу хязгаарлалт тогтоож байдлыг дордуулж байна. Цагдаа, аюулаас хамаалах хүчнийхэн сэтгүүлчдийг сүрдүүлж, заналхийлжээ. Хүний эрхийн өмгөөлөгчид заналхийлэлд өртөх, хууль бусаар баривчлагдах, улс төрийн сэдлээр яллагдаж, хоригдох ялаар шийтгүүлж байна.

Казакстанд сэтгүүлч, идэвхтнүүдийг улс төрийн сэдлээр яллаж, заналхийлжээ. Чөлөөт хэвлэл мэдээллийг аль хэдийн боомилсны дээр интернэт, социал мэдээллийн хэрэгслээр аливаа шүүмжлэлт дуу хоолой дэгдэхийг зогсоохын тулд эрх баригчид сайтар төлөвлөсөн, түрэмгий арга хэрэглэх нь ихэслээ. Азербайжан улсад шүүмжлэлт дуу хоолойг дарах зорилгоор кибер кампанит ажил явуулсан байна.

Узбекийн засгийн газар сэтгүүлч, идэвхтнүүдэд дайсагнасан орчныг дэвэргэн, Европт байгаа Узбек хүмүүсийг айдаст автуулан гадаад болон дотооддоо байгаа иргэдээ хууль бусаар цагдаж байна. Хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлчийг цагдаагийн байгууллага байцахаар дуудах, гэрийн хорионд оруулах, биед нь халдах зөрчил гарсаар байв.

Кремид одоогийн эрх баригчид өөр үзлийг нухчин дарсаар байгаа бөгөөд Орос улс тус хойгийг хууль бусаар авч, эзэрхийлж байгааг шүүмжилсэн Татар хүмүүсийг цөллөг болон шорон руу илгээж байна.

2016 оны төрийн эргэлт хийх оролдлого нурснаас хойш засгийн газрыг шүүмжилсэн олон мянган хүнийг Турк улс хорьсоор байна. Засгийн газрыг шүүмжлэх нь хэвлэлийн мэдээнээс бараг арчигдлаа. 100 гаруй сэтгүүлчдэд хилс хэрэг тулган шоронд хадаж байгаа нь бусад улсаас тоогоороо давжээ.

Зүүн Европ, Төв Азид гарсан эхний эерэг дэвшлийг онцолбол Узбек улсад үзэл санааны болон урт хугацаатай хоригдогсдыг сулласан явдал байв. Азербайжанд зарим үзэл санааны хоригдлыг сулласан ч үл төгсөх дарангуйллын бодлогоороо оронд нь шинэ хүмүүсийг хорьжээ. Орост саяхнаас хэрэгжсэн олон нийтийн цугларалтад тавьсан хатуу хязгаарлалтыг удаа дараа зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулиар шийтгэгдсэн анхны бөгөөд одоогийн байдлаар цор ганц хүн болоод байсан үзэл санааны хоригдол Илдир Дадин Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дараагаар гэм буруугийд тооцогдож суллагдав.

ХЯЗГААРЛАСАН ХУУЛИУД

Европ, Төв Ази даяар хязгаарласан хуулиуд батлагдлаа. 2012 онд Орост баталсан хуулиас санаа авч Унгар улс гадаадаас шууд болон шууд бус замаар 24000 еврогоос давсан санхүүжилт авсан ТББ “гадаадаас санхүүжилттэй иргэний нийгмийн байгууллага” гэж дахин бүртгүүлэх, хэвлэл бүртээ ийм шошго хадаж байхыг заасан гадаадаас санхүүжилттэй байгууллагуудын ил тод байдлын тухай хуулийг баталлаа. Засгийн газрын энэ алхам нийгэмд хийрхэл дэгдээсэн шившигт үйлдэл юм. Ижил төстэй хуулийг Украин, Молдав гаргахаар санаархсан ч иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын эсэргүүцэлтэй тулгарч буцаалаа.

Польш улсад парламентын гишүүд хараат бус шүүх ажиллагаанд заналхийлсэн, шударга шүүхээр шүүлгэх болон бусад эрхийг эрсдэлд хүргэх хоёр хуульд нэмэлт өөрчлөлтийг 11 дүгээр сард оруулсны дараа томоохон эсэргүүцэл гарсан юм. Ерөнхийлөгч Андрес Дуда 7 дугаар сард уг нэмэлт өөрчлөлтөд хориг тавьсан ч, 9 дүгээр сард дахин засварлан парламентад өргөн барьжээ.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Зүүн Европ, Төв Азид эрх баригчид тайван замаар жагсахыг хориглож байна. Орост 3 дугаар сард авлигын эсрэг улс даяар олныг хамарсан жагсаалд цагдаа хүч хэтрүүлэн хэрэглэж, Орос улс нийслэл Москвад тайван замаар жагссан сөрөг хүчний удирдагч Алексей Навальный зэрэг олон зуун хүнийг, бусад газар нутагт мянга гаруй жагсагчдыг баривчилан өмнөх хоморголон баривчилсан рекордоо эвдлээ. Улс даяар 6 дугаар сард болон ерөнхийлөгч Владимир Путиний төрсөн өдөр буюу 10 дугаар сарын 7-нд авлигын эсрэг жагсаалын үеэр олон зуун хүнийг дахин баривчилж зүй бус харьцжээ.

Эрх баригчдын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр тайван замаар жагсаал зохион байгуулах, үүнд оролцох нь Казахстанд хууль зөрчсөн үйлдэл болж байна.

Киргизийн цагдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дордуулсныг эсэргүүцсэн тайван жагсаалыг тарааж, хэд хэдэн оролцогчийг баривчилжээ. Беларусийн эрх баригчид татвар, ажилгүйдлийн эсрэг олныг хамарсан жагсаалыг хүчээр тараав.

Польшид тодорхой жагсаалуудыг хориглож, харин засгийн газрын төлөөх цугларалтыг дэмжих ялгавартай нөхцөл бүрдүүлсэн өөрчлөлтийг хуульд оруулжээ. Засгийн газрын бодлогын эсрэг жагссан хүмүүсийг хууль сахиулах ажилтнууд мөрдөн шалгаж, заналхийлж, улс төрийн сөрөг хүчний тайван замаар цугларах эрх чөлөөг хязгаарлаж байна.

Баруун Европын зарим улсад олон нийтийн жагсаалыг төрөл бүрээр хязгаарлах арга хэмжээ авч байна. Герман, Франц, Польш, Испани олон нийтийн цугларалтыг хязгаарлах бодлого гаргаж хүний эрх зөрчжээ. Эдгээр зөрчил нь олон нийтийн газрыг битүүмжлэх, цагдаа хэтрүүлэн хүч хэрэглэх, жагсагчдыг бүслэн хаах, нэгжиж шалгах, захиргааны болон эрүүгийн арга хэмжээ авахаар сүрдүүлэх зэрэг юм. Францын засгийн газар олон нийтийн цугларалтыг хориглохын тулд онц байдлын арга хэмжээ авч, иргэдийг жагсаалд оролцохыг хориглож шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж байна.

10 дугаар сард Каталаны тусгаар тогтнолын талаар санал хураалт явуулахыг хориглох тушаал авсан Испанийн аюулаас хамгаалах хүчин жагсагчдын эсрэг шаардлагагүй, тохиромжгүй хүч хэрэглэж олон зуун хүнийг бэртээжээ.

АЮУЛААС ХАМГААЛАХ БА ТЕРРОРИЗМИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭ

Баруун Европын улсууд терроризмийн эсрэг ялгаварласан, тохиромжгүй хуулиуд батлуулахаар оруулж байна. Европын холбоо нь Терроризмтай тэмцэх тухай удирдамжийг 3 дугаар сард баталсан нь 2018 онд улс орнууд удирдамжаа болгон дотоодын хуульдаа суулгах арга хэмжээ авах ажлыг эцэглүүлжээ.

Эдгээр хуульд терроризмийг ерөнхий тодорхойлж, хүний эрхийн хамгаалагч, байгаль орчны идэвхтэн, дүрвэгч, цагаач, сэтгүүлчид зэрэг өргөн хүрээний хүмүүст хамааруулж терроризмийн эсрэг хуулиа урвуугаар ашиглах явдал тухайлбал Турк төдийгүй Баруун Европт гарсаар байна. Франц, Испани, Их Британи зэрэг улсад идэвхтэн, иргэний нийгмийн бүлгүүдийг интернэт болон социал мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлсний төлөө терроризмийг “алдаршуулсан” эсвэл “өмөөрсөн” хэмээн шийтгэж яллахад ашиглаад байна.

Хоёр жил орчим үргэлжилсэн Францын онц байдал 11 дүгээр сард зогслоо. 9 дүгээр сард Франц терроризмтай тэмцэх шинэ хууль баталсан нь энгийн үед ч онц байдлын үед хэрэглэгдэх олон арга хэмжээ, дэглэм тогтоохоор заасан байна.

Халдлагад сэжиглэгдсэн гэмт этгээдийг мөрдөн шалгахын оронд улс орнууд хүн бүрийн эрхийг хязгаарлах захираганы хяналтын арга хэмжээ авч ихэвчлэн шашны итгэл үнэмшил, нийгэмлэгийн харьяалалтай холбон тодорхойгүй үндэслэлээр арга хэмжээгээ авч байна. Франц, Голланд, Швецарь зэрэг хэд хэдэн улсад ял оноохгүйгээр юмуу шүүхгүйгээр цагдан хорьж байгаа туршлага Баварь, Герман улсад нэвтрээд байна.

ЕХ-ны гишүүн олон орон дүрвэгсдийн хямралыг терроризмын аюул заналтай холбох гэж оролдож байна. Унгарийн шүүх Кипрт оршин суугч “Ахмед Х”-д хилсээр терроризмийн ял оноосон болохыг тогтоосон ч Ахмед Х-д шинэ хавтаст хэрэг үүсгэн хорьсоор байна. Шүүн таслах ажиллагаа оны сүүлээр үргэлжилсээр байв. Түүнийг хил дээр цагдаа нартай мөргөлдөж байх үеэр чулуу шидэж, чанга яригчаар олонд хандан үг хэлсний төлөө “терроризмийн үйлдэл” хийсэн хэмээн буруутгаад байгаа юм.

Европ, Төв Азийн улс орнууд терроризмтай холбогдох юмуу “хэт туйлшрагч” байж болзошгүй хэмээн цахим үйл ажиллагаанд анхаарлаа хандуулахаа эрчимжүүлээд байна. Их Британид “терроризмтай холбогдох” агуулгыг онлайнгаар давтан үзсэн байвал дээд тал нь 15 жил хүртэл эрүүгийн ял оноохоор хуульд тусгах төсөл гаргажээ. Францад Үндсэн хуульд нь харшилсан ижил төстэй арга хэмжээг аль хэдийн авсан байна.

Зүүн Европ, Төв Азид террорист, хэт туйлшрах үзлээр бодитой үйлдэгдсэн болон илт заналхийлсэн явдалд засгийн газруудын хариу үйлдэл нь бүгд нэг хэв маягаар явагдаж байна. Эрүү шүүлт, хэрцгийлэлд өртөх газар сэжигтнийг шилжүүлэх, илгээхдээ шуурхай, давталттай үйлдэж байна. Хувь хүмүүсийг хүчээр буцааж байгаа нь олон улсын хуулийг зөрчиж байна. Оросын Хойд Кавказид хүчээр сураггүй алга болгох, хууль бусаар цагдан хорих, хоригдогсдод эрүү шүүлт тулгаж хэрцгий харьцсан, шүүхээс гадуур цаазалсан явдлаа аюулаас хамгаалах үйл ажиллагаанд хамааруулан мэдэгдэв. Оросын эзэрхийлсэн Кремд одоогийн эрх баригчид эсэргүүцсэн бүх хэлбэрийг мөрдөж терроризмийн эсрэг, экстремизмийн эсрэг хуулийн дагуу Кремиин Татар ард иргэдийг онилсоор байна.

ДҮРВЭГЧ, ЦАГААЧИД

2016 онд 362753 дүрвэгч цагаач Европт ирж байсан бол 2017 онд 171332 ирсэн байна. Ийнхүү буурсан нь Европын холбооны улсууд Ливи болон Турк улстай хамтран ажиллах болсонтой илүү холбоотой. Наанадаж 3119 хүн Газар дундын тэнгис гатлаж байхдаа амь үрэгджээ. Европын холбооны улсууд хууль бусаар нэвтрэхийг хориглосон хоригоо чангатгаж, эх орондоо болон дамжин өнгөрөх оронд хэрцгийлэл, эрүү шүүлт бусад хүчирхийллээс хамгаалагдах шаардлагатай хүмүүс, цагаачдыг буцаах нь ихэслээ.

Дүрвэгч, цагаачдын эрхийг системтэйгээр, их хэмжээгээр зөрчдөг болохыг баримтжуулсан байгаа ч дамжин өнгөрөх орнуудад Европын засгийн газрууд туслалцаа үзүүлэх, худалдааны болон бусад хөшүүрэг ашиглан хүний эрхийн зохистой баталгаагүйгээр хилийн хатуу хяналтын арга хэмжээ авахыг нь дэмжиж, өдөөж байна. Ингэснээр олон мянган дүрвэгч, цагаачдыг зохистой хамгаалалт дутагдалтай, хүний эрхийн ноцтой зөрчил гардаг оронд мухардуулж байгаа юм.

Италийн эрх баригчид 2017 оны эхний хагаст Газар дундын тэнгисийн төв

хэсгээс дүрвэгсдийг илүү аварч чадсан ТББ-уудыг олон нийтийн хэвлэл мэдээллийн нэвтрүүлэгч, улс төрчид дайрч доромжлон шинэ ёс зүйн дүрмээрээ үйл ажиллагааг нь хязгаарлаж байна.

Европ, Төв Азийн бусад орон шиг Орос улс орогнол эрэгчид, дүрвэгчдийг эрүү шүүлт, бусад хэрцгий харьцаа тулгадаг орнууд руу буцааж байна.

ЛИВИ ЕВРОПЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Ихэнхи дүрвэгч, цагаачид Ливийг дайран Европ руу далай гаталдаг байсныг ЕХ болон Итали тэргүүтэй Европын засгийн газрууд Ливийн эргийн хамгаалалт болон бусад байгууллагатай хамтран нэвтрэх замыг хаахыг эрмэлзжээ. Тэд Хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээх ёстой Ливийн эрх баригчид, онцолбол Ливийн Эргийн Хамгаалалт болон Хууль бус Цагаачидтай Тэмцэх Ерөнхий Газар (ЛХЦТЕГ)-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж зальхай арга хэрэгжүүлжээ.

Итали болон бусад засгийн газар энэ гэрээндээ хүний эрхийн гол баталгааг тусгаагүй байх бөгөөд хамтран ажиллаж байгаа байгууллагуудын үйлдсэн дүрвэгч, цагаачдыг эрүүдэн шүүх, хөөн гаргах зөрчилд харц бурууллаа. Европын засгийн газруудын энэ үйлдэл олон хүний найдлагыг зогсоох, дундаас нь баривчлагдах нөхцлийг бий болгож байна. Ингэснээр Европын засгийн газрууд, ялангуяа Итали олон улсын үүргээ умартаж санхүүжүүлж хамтран ажилласан Ливийн эрх баригчдын үйлдсэн зөрчилд холбогдож байна.

ЕХ-ТУРКИЙН ЦАГААЧЛАЛЫН ТОХИРОЛЦОО, ГРЕК ДЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

2016 оны 3 дугаар сард байгуулсан ЕХ-Туркийн цагаачлалын тохиролцоо хэвээр хадгалагдаж ЕХ-нд орогнол эрэх, газар нутагт нэвтрэхийг хатуу хориглосоор байна. Тохиролцоо нь Турк руу орогнол эрэгчдийг дамжин өнгөрөхөд “аюулгүй орон” хэмээн худал хэлж буцаах зорилготой юм. Европын удирдагчид 2016 оны төрийн эргэлтээс хойш дүрвэгсдэд илүү аюултай болсон байхад Туркийг ЕХ-той дүйх хамгаалалттай хэмээн хуурамч баталгаа гаргасан байна.

2017 оны турш тус тохиролцоо Грекийн арлуудад бөөнөөр, бохир, аюултай нөхцөлд олон мянган хүнийг хүлээлгэж, бодит байдал нь дутагдал гачигдал болон хувирчээ. Цагаачид, орогнол эрэгчид өргөдлийг нь хүлээн авна хэмээн олон сараар хүлээнэ. Зарим нь үзэн ядалтын гэмт хэргийн золиос болов. 2016 онтой харьцуулахад Грект ирэгсэд эрс багассан бөгөөд энэ нь голчлон дээрх тохиролцооноос үүдсэн байна. Үүн дээр зуны улиралд ирэх хүн ихэссэн нь аль хэдийн хүчин чадлаа шавхан ажиллаж байгаа арлыг дахин нэрвэгдэхэд хүргэжээ. 12 дугаар сард 13000 орчим орогнол эрэгчид арлууд дээр гацаж там диваажингийн орны дунд үлдсэн юм.

Грекийн арал болон эх газрын аль аль дээр нөхцөл хүртээмжгүй, олон хүн одоо ч өвлийн хүйтэнд зуны майханд амьдарч, хуарангийн эрсдэлтэй нөхцөл охид эмэгтэйчүүдийг ялангуяа эмзэг болгож байна.

Энэ жил Туркийг дүрвэгсдэд аюулгүй хэмээн төсөөлж Грекийн орогнолын асуудлыг хариуцсан газрын шийдвэрээр Туркийн арлууд руу буцаах замыг Грекийн захиргааны дээд шүүх нээжээ. 11 дүгээр сарын байдлаар Европын улсууд ердөө 32%-ийг нь авчээ. 2017 оны эцэст 66400 орогнол эрэгчдээс 21703 нь Грекээс, Италиас 35000 хүнээс 11464 хүнийг шилжүүлжээ.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ СХЕМ

Хүлээн авагч орнууд олноор ирэгсдийг эв санаагаар нэгдэн дэмжлэг үзүүлэх нь бага байна. Европын орнууд 2015 оны 9 дүгээр сард баталсан онц байдлын үед нүүлгэн шилжүүлэх схемийн дагуу Грек, Италиас ирсэн орогнол эрэгчдийг нүүлгэн шилжүүлээгүй байна. 11 дүгээр сарын байдлаар Европын улсууд ердөө 32%-ийг нь авчээ. 2017 оны эцэст 66400 орогнол эрэгчдээс 21703 нь Грекээс, Италиас 35000 хүнээс 11464 хүнийг шилжүүлжээ.

Польш, Унгар хамгийн муу буюу хоёул оны төгсгөлд нэг ч орогнол эрэгчийг

хүлээн аваагүй байна.

Европын Үнэн шударгын Шүүх Словак, Унгарын дүрвэгсдийг байршуулах зайлшгүй үүргийнх нь талаар гомдол гаргасныг хүлээн аваагүй юм. Европын Комисс нь Польш, Унгар, Чехийн Бүгд Найрамдах Улсыг дүрвэгсдийг байрлуулах үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасныг хэлэлцэж эхлэв.

ОРОГНОЛ ЭРЭХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ, БУЦААСАН НЬ

Унгар улс Европын холбооны хуулиа зөрчин эх орондоо хууль бус нөхцөлд байгаа нь илэрсэн бүх хүнийг буцаах тухай хууль баталж, орогнол эрэгчдийг шууд цагдан хорих болсноор доогуур үнэлэгдэж байна. Эрх баригчид орогнол эрэгчдийг хил дээр нь ирэхэд агуулахад түгжиж байна. Унгар улс дүрвэгч, орогнол эрэгчид, цагаачдын эрхийг системтэйгээр хязгаарлаж байна. Тухайлбал хоёр хилийн “дамжин өнгөрөх бүс”-д зөвхөн ажлын өдрүүдэд 10 хүний орогнол эрэх хүсэлтийг хүлээн авч нэвтрэн орохыг хязгаарлаж байна. Энэ нь олон мянган хүмүүсийг орон гэргүй байх, бүсийн өмнөд хэсэг Македон болон Болгар руу хүчээр буцаагдах эрсдэл бүхий Сербийн түр хуаранд орхигдоход хүргэж байна.

Европын холбооны Болгар, Грек, Польш зэрэг захын орнуудын хил дээр эрхийг нь зөрчиж буцаах явдал гарсаар. Польшийн засгийн газар Польш болон Беларусийн хил дээр хэрэгжүүлж хэвшсэн нутаг буцаах үйлдлээ хууль ёсны болгох тухай хуулийн төсөл санаачилжээ. Харин Испанийн хаалттай бүсийн Мелилагаас Морокко руу шуурхай буцаан хоёр цагаачийг албан ёсны хамгаалалтад орох эрхийг зөрчсөн, олноор нь хөөн гаргахыг хориглосон заалтыг мөрдөөгүй хэмээн буруушаасан шийдвэр Европын Хүний эрхийн шүүх гаргасан нь дэвшил байв.

Словень улс хууль бусаар нэвтэрсэн дүрвэгч, цагаачдын орогнол эрэх хүсэлтийг үл харгалзан шууд хөөх, хил дээр ирэгсдийг нэвтрүүлэхээс татгалзах хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа.

ХҮЧЭЭР БУЦААХ

Европын холбооны гишүүн орнууд зарим тохиолдолд *refoulement* (дүрвэгч, цагаачдыг эрсдэлтэй оронд нь буцаах)—аас зохистой хамгаалахгүй, дахин гаргасан өргөдлийг хүлээн авахгүй байх дарамтыг бусад засгийн газруудад үзүүлж байна.

Афганистанд энгийн иргэд мөргөлдөөнд өртөх нь өмнө байгаагүйгээр ихсэж байгаагаас Афган орогнол эрэгчид нэмэгдэж Афганаас зугтан гарсан үед Европын засгийн газрууд аюул руу түлхэн буцааж байна. Австри, Голланд, Норвеги зэрэг улс Афганистан руу нь хүчээр буцаажээ.

ХУУЧИН ЮГОСЛАВ ДАХЬ ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ӨНГӨРӨӨХ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ БАЙДАЛ

Хуучин Югославын хэргийг хэлэлцэх Олон Улсын Эрүүгийн Тусгай Шүүх 23 жил амжилттай ажиллан дайны гэмт хэрэг үйлдэгсэдтэй хариуцлага тооцсон үйл ажиллагаагаа хааш сүүлчийн шийдвэрээ 2017 оны 11 дүгээр сарын 29-нд гаргалаа. Гэхдээ энэ сардаа Боснийн армийн командлагч Ратко Младичийг геноцид, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгаж бүх насаар нь хорих ялыг тус шүүхээс оноосон юм.

Босни Герцеговинд ахиц бага гарч байгаагаас гадна үндэсний түвшинд шүүх нь хязгаарлагдмал нөөц, чадавхитай, улс төрийн дарамт шахалт дор ажиллаж байгаа нөхцөлд ял шийтгэлгүй өнгөрөх явдал хэвийн үзэгдэл болов. Прокурор ажлаа гүйцэтгэхэд дэмжлэг дутмаг, үйл ажиллагааг нь үндэсний хийрхэлд автуулж, бүсийн тогтвортой хамтын ажиллагааг хангах улс төрийн чармайлт дутмаг байна.

Жилийн эцэст ч Балкан дахь зэвсэгт мөргөлдөөний үеэр сураггүй алга болсон 11500 гаруй хүмүүсийн хувь заяаг анхаарч үзэхийн төлөө эрх баригчид ямар ч ахиц

гаргасангүй. Хүчээр сураггүй алга болгосон хохирогчийн ар гэрийнхний үнэнийг мэдэх, шударга ёсыг тогтоолгож, нөхөн төлбөр авах эрхийг нь үгүйсгэж байна. Хэд хэдэн оронд дайны үеийн бэлгийн хүчирхийллийн хохирогч нарт нөхөн төлбөр олгох хуульд нэр төдий өөрчлөлт хийжээ.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИД 'УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛААР'-ААР ХААЦАЙЛАХ

Зүүн Европ, Төв Азийн орнуудын засгийн газрууд ялгаварлан гадуурхсан, дарангуйлсан сахилгын арга хэмжээгээ 'уламжлал'-аа баримтлах нэрээр хаацайлж ужгирсан асуудлыг улам өөгшүүлж дэвэргэсээр байна. 'Уламжлал' зан заншлыг гадныхныг үзэн ядах, эмэгтэйчүүдийг дорд үзэх, гадуурхах, ижил хүйстний эсрэг үзэл болгон дэвэргэхэд ашиглаж байна. Тажикстанд энэ хандлагаар ЛГБТИ хүмүүсийг 'ёс суртахуунгүй' авиргласан гэж шийтгэх, ялангуяа эмэгтэйчүүд, шашны цөөнхийн эсрэг хувцаслалт, хэл, шашны хэм хэмжээг албадан тулгасан шинэ хууль дүрэм гаргахад хэрэглэжээ.

Орос, Казакстан улсад 'хэт туйлшрахын эсрэг' хуулиар шашны цөөнхтэй ёс бус харьцах, эрүүгийн хэрэг үүсгэх явдал нэмэгдэж байна. 'Уламжлалт үнэ цэнэ'-ээр хаацайлан Чеченьд эрх мэдэлтнүүд гей залуучуудыг нууцаар эрүүдэн шүүж, аминд нь халдаж айдаст автуулаад байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

АНУ-д шоу бизнесийн салбарт Холливудын продюсер Харви Вайнштейн болон бусад хүмүүс бэлгийн дарамт үзүүлсэн нь илэрсний дараа дэлхий даяар сая сая эмэгтэйчүүд #MeToo (Би ч бас) гэсэн онлайн хаштаг (чагталж онцлох) аяныг ашиглан дарагдмал бэлгийн хүчирхийллийн хохирогчдын үзэж туулсныг илчиллээ. Энэ аян хүчирхийлэлд өртөгсдийг буруутгасан хандлагыг өөрчилж, гэмт хэрэгтнүүдийг хариуцлагад татахыг уриалан дуудсан юм. Мөн өнгөрсөн он аюулгүй, хууль ёсны үр хөндөлт хийлгэх эрхийг засгийн газар цаашид хориглохгүй байхад түлхэц үзүүлж чадсан Европ даяар өрнөсөн Нэгдүгээр сарын эмэгтэйчүүдийн алхалт, Польш улсад болсон Хар Даваа гарагийн жагсаал зэрэг эмэгтэйчүүд, феминистүүдийн хөдөлгөөн өрнөсөн жил байлаа. Гэвч Европ, Төв Ази даяар охид эмэгтэйчүүд тогтолцооноос үүдсэн хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн хохирогч болсоор байна.

Ирландад үр хөндүүлэх ихэнх тохиолдлыг гэмт хэрэгт тооцож, үр хөндүүлэхийг хатуу хориглосоор байна. Польшид аюулгүй, хууль ёсны үр хөндөлт хийлгэхэд бэрхшээл байнга тулгарч байгаа бол, Мальтад бүх нөхцөлд эрүүгийн гэмт хэрэгт тооцсоор.

Эмэгтэйчүүд, гэр бүлийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх Конвенц (Истанбулын Конвенц)-д Европын холбоо, Молдав улс гарын үсэг зурлаа. Кипр, Эстони, Гүрж, Герман, Норвеги, Швейцарь зэрэг 28 орон энэ конвенцийг баталжээ. Украин улс 2011 онд гарын үсэг зурсан ч соёрхон батлаагүй байна.

Хуулийн хамгаалалт нэмэгдэж байгаа ч Албани, Хорват, Румын зэрэг орнуудад эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл өссөн хэвээр. 'Уламжлал, ёс заншил'- гэдгээр халхавчилсан олон нийтийн шүүмжлэлтэй тулгарсан ч гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэрийг гэмт хэрэгт тооцох хуулийн шинэчлэлийг ОХУ-ын парламент баталж, ерөнхийлөгч Путин үзэглэлээ. Норвеги, Швед зэрэг орнуудад бэлгийн хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан хүчирхийлэлд төрийн хариу арга хэмжээ хангалтгүй ноцтой асуудал хэвээр байна.

ЦӨӨНХИЙН ЭРХ

Цөөнхийн хэд хэдэн бүлэг хавчлага, хүчирхийлэлд өртөж, элдэв саадтай тулгарсан бөгөөд тэднийг алагчлах, шившиглэх явдал Европ, Төв Азид тархжээ.

Цыганчуудын эсрэг ялгаварлан гадуурхалт Словакад түгээмэл байна. Европын

Комиссоос Словак, Унгар улсын цыган хүүхдүүдийг тусгай сургуульд хамруулах, ялгаварлан гадуурхаж байгаагын эсрэг тогтоолоо үргэлжлүүлэн гаргасаар байна. Тусгаарлагдсан хуаран, нийтийн орон сууцаар хангагдахад ялгаварлан гадуурхагдах, албадан нүүлгэх нь Итали улсад амьдарч байгаа 170.000 Цыганчуудын хувьд өдөр тутмын бодит байдал болсон бөгөөд тэдгээрийн 40.000 гаруй нь ядуусын хороололд амьдарч байна. Европын Комиссоос Цыганчуудын эсрэг ялгаварлан гадуурхалтыг эцэслэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч чадахгүй байна.

Мусалминчуудыг ялангуяа ажил хайх, ажил дээрээ болоод төрийн болон хувийн байгууллагаас боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авахад ялгаварлан гадуурхаж байна.

Австрид шинэ хуулиар олон нийтийн газарт нүүрээ бүрэн халхлахыг хориглосон нь үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшил, шашны эрх чөлөөг хязгаарласан хэрэг болов. Уламжлалын тухай хуулиа хэрэгжүүлэн Тажикстаны эрх баригчид мянга, мянган исламын шашинт эмэгтэйчүүдийг олон нийтийн газарт толгойн гивлүүрээ авахыг шаарджээ.

ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР, ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ

Дорно дахинд ЛГБТИ хүмүүс хүчирхийлэл, хууль бус баривчилгаа саатуулалт зэрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтанд өртөх нь ихэслээ. Азербайжаны нийслэл Баку хотод 100 гаруй ЛГБТИ хүнийг нэг өдөр баривчилжээ. Узбекистан, Туркестанстанд эрэгтэйчүүдийн харилцан тохиролцсон баривчилгээ шоронд хоригдох гэмт хэрэгт тооцдог. Гүржийн шинэ үндсэн хуулиар ижил хүйсний хосуудын гэрлэлтийг хориглов. Литва улсын парламент ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах хууль дүрмийг баталжээ. Европын хүний эрхийн шүүхээс ялгаварлан гадуурхалтад хяналт тавьсан хэдий ч Оросод 'гей суртлын хууль' хэрэгжсэн хэвээр байна.

Дөрөвдүгээр сард Чечений эрх мэдэлтнүүд гей залуучуудыг нууцаар, дур зоргоороо баривчилж, эрүүдэн шүүж, амь насанд нь халдаж байна гэсэн мэдээ гарав. Олон улсын эсэргүүцлийн хариуд холбооны эрх баригчид үр дүнтэй хяналт тавьж чадахгүй байх хооронд Чеченд гей залуус байхгүй хэмээн эрх мэдэлтнүүд нь мэдэгдэж байлаа.

Гэвч хүмүүсийн эв санааны нэгдэл, эр зоригийг илтгэх олон жишээ, ахиц дэвшил гарсан. Оросын ЛГБТИ хүмүүсийн сүлжээнээс Чечень болон Хойд Кавказад ЛГБТИ хүмүүсийг аюулгүй нүүлгэн шилжүүлэхэд туслах ажиллагааг зохион байгуулав. Мөн Украйнд өмнө нь болж байгаагүй томоохон цуглаан болжээ. Малтийн парламент ижил хүйстнүүдийн гэрлэлтийн тухай хууль баталж ижил хүйстэн хосуудад гэрлэх эрхийг олгосон байна. Харин Германд хүйс, жендэрийн чиг хандлагаас үл хамааран эдгээр хүмүүст гэрлэх эрхийг олгосон төдийгүй тэдний гэрлэлтийг хүлээн зөвшөөрч тэгш эрхээр хангажээ.

ТРАНСЖЕНДЭР БОЛОН БЭЛГИЙН ЯЛГААТАЙ ЧИГ БАРИМЖААТАЙ ХҮМҮҮС

Европ, Төв Ази дахь трансжендэр хүмүүс жендэрийн чиг хандлагыг хуулиар хүлээн зөвшөөрүүлэхэд бэрхшээлтэй тулсаар байна. Бэлгийн чиг хандлагын хувьд ялгаатай хүүхэд болон насанд хүрэгчдэд хүний эрхийн зөрчлийн асуудал тулгарсаар. Ялангуяа хүүхдийн бие махбодь, сэтгэлзүйд халдсан хор нөлөөтэй эмчилгээг шаардлагагүй үед хийлгүүлэн хохирч байна.

Европын 18 оронд трансжендэр хүмүүсийг үргүйдүүлэхийг шаарддаг бол 35 оронд хүйсээ солиулахын тулд сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоонд оруулж байна.

Бельги, Грек орнуудад шуурхай, ил тод, хүртээмжтэй захиргааны үйл ажиллагаа удаашралтай байгаа хэдий ч үргүй болгохыг болиулах болон сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоо хийлгэхийг шаардахаа больсон Европын орнууд болов.

ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Энэ бүсийн зарим улс сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагчид руу чиглэсэн дарангуйллын эрс арга хэмжээ авч цахим хуудсанд нь хатуу хяналт тогтоогоод байна. Зарим улсад иргэний нийгмийн төлөөлөгчдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд төрөөс хязгаарлалт тогтоох санаархлыг таслан зогсоож чадсан юм. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхэд зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, засгийн газраас халдах тохиолдол мөн гарсан. Зарим улсад эмэгтэйчүүдийн эрхийн тэмцлийн үр дүнд хуулиар болон практикт ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэхийг хассан нэмэлт өөрчлөлтийг хуульдаа тусгуулсан. Гэхдээ бүсийн хэмжээнд хуулиар болон практикт зохих ёсоор хамгаалагдаж чадахгүй байна. Бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэж баривчлах, мөрдөн мөшгөх, олон улсад ижил хүйстний харилцааг эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож, зарим улсад бүр цаазаар авах ял оноож байна. Мөн хэд хэдэн улсад үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг нь хязгаарлаж, цагаач ажилчдын эрхийг ноцтойгоор зөрчсөөр байна. Нөгөө талаасаа зарим улсад хийгдсэн өөрчлөлт шинэчлэл цагаач иргэнийг хамгаалахад нөхцлийг нь сайжруулсан байв. Зэвсэгт мөргөлдөөний явцад энгийн иргэд ихээр зовж, олон халдлагад өртөж, тэдний, хууль бусаар зорчих эрхийг нь хязгаарлаж, шууд халдах байдал гарсаар байна. Бүсийн хэд хэдэн улсад цаазаар авах ялыг ногдуулж, 100 гаруйг нь гүйцэтгэжээ. Гэмт хэрэг үйлдсэн этгээд ял шийтгэлгүй үлдэх тохиолдол байгаа ч хохирогчийн эрхийг хамгаалах, шударга ёсыг тогтоох талаар зарим ахиц гарсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Ойрх Дорнод болон Хойд Африкт хүний эрхийн зөрчлийг мэдээлэх, эсхүл төр, тэдний холбоотнуудыг шүүмжилснийх нь төлөө эсхүл иргэний нийгмийнхний цахим болон цахим бус үйл ажиллагаанд хяналт тавьж үүнийгээ үндэсний аюулгүй байдлыг хангах, авлигатай тэмцэж байна хэмээн зөвтгөдөг аж. Энэ бүсийн зарим улс гудамж талбайд өрнөсөн эсэргүүцлийн жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараасан юм.

ЕГИПЕТ БОЛОН САУДЫН АРАБ

Зарим улс, хүч нөлөөгөө олон улсын хэмжээнд харуулах, олон улсын анхаарлын төвд байх зорилгоор олон улсын чиг хандлагаас зориуд гажих нь нэмэгдсээр байна. Египетийн Ерөнхийлөгч Абдэл Фата Ал Сиси төрийн бус байгууллагын дансыг нь царцааж, татан буулгах, төрийн зөвшөөрөлгүйгээр судалгаа тайлан гаргасан нөхцөлд таван жилээр хорих ялаар шийтгэх хүртэл хууль батлуулж онцгой аргаар хүний эрхийн хамгаалагчдын ажилд саад болж байна. Египетийн эрх бүхий байгууллага нь 15 сэтгүүлчийг “худал мэдээлэл” цацсан хэмээн хорьж, бие даасан хэвлэл мэдээллийн болон хүний эрхийн байгууллагын 400 гаруй цахим хуудсыг хаасан юм. Мөн аюулгүй байдлын асуудал хариуцсан хүчний байгууллагууд Муслимын ахан дүүсийн холбооны гишүүн эсхүл гишүүн байх магадлалтай гэсэн үндэслэлээр 100 гаруй хүнийг баривчилсан юм. Улс төрийн тэрс үзэлтнүүдийг шийтгэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар хорих хугацааг сунгаж, тодорхойгүй хугацаагаар ганцаарчилсан байдлаар хорих, мөн тэнсэн суллагдсан нөхцөлд өдөр бүр цагдаагийн хангарч 12 цагаар байх зэрэг байдлаар хууль бусаар эрх чөлөөг нь хязгаарласан тохиолдол

олон гарсан.

Саудын Араб улсад Мухамед бин Салман зургадугаар сард хаанаар өргөмжлөгдсөнөөр, улс төрийн нөхцөл байдалд ихээхэн өөрчлөлт авчирсан юм. Түүнийг томилсноос хойш хэдхэн сард үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ихээхэн хязгаарлаж, есдүгээр сард 20 гаруй нэр төртэй шашны тэргүүн, зохиолч, сэтгүүлч, эрдэмтэн, зүтгэлтнийг нэг долоо хоногийн дотор баривчилсан байв. Мөн хүний эрхийн хамгаалагчдыг терроризмын гэмт хэргийг шүүн таслах зориултаар байгуулагдсан тусгай эрүүгийн шүүхээр шүүн шийтгэсэн байна.

СЭТГҮҮЛЧ БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ЭСРЭГ ХАЛДЛАГА

Хүний эрхийн хамгаалагчид болон төрийн байгууллагыг шүүмжилсэн сэтгүүлчдийг баривчилж, хорьсноос гадна төрийн байгууллагаас зохион байгуулалттайгаар тэдний эсрэг гүтгэлэг явуулж байна.

Иранд эмэгтэйчүүдийн эрх, цөөнхийн эрх болон хүрээлэн буй орчныг хамгаалах тэмцэгч, үйлдвэрчний эвлэл, хуульч, үнэн, шударга ёсны төлөө тэмцэгч, 1980-д оны олныг хамарсан хэлмэгдүүлэлтийн хохирогчдод нөхөн төлбөр олгохыг шаардсан шүүмжлэгчдийг хэд хэдэн удаа хорьсон.

Бахрейнд хүний эрхийн хамгаалагч, засгийг шүүмжлэгчдийг албадан хорьж, зорчих эрхэд нь хориг тавьж, иргэний харьяаллаас гаргах хараат бус Ал-Васат сонингийн газар, улс төрийн сөрөг хүчин Ваадыг татан буулгаж, нийслэл Манамад аливаа жагсаал цуглааныг хориглож, аливаа эсэргүүцлийн жагсаалыг хүч хэрэглэн тараасан юм.

Морокко болон Баруун Сахарт сэтгүүлч, блоггер болон авлига, хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлсэн, хойд хэсэгт болсон жагсаал цуглааны үеэр хүмүүсийг олноор, тэр дотор хүүхдүүдийг хүч хэрэглэн баривчилсныг шүүмжилсэн олон хүнийг мөрдөн мөшгөж, хорьсон.

Кувейтэд төр засгийг шүүмжилсэн цахим болон цахим бус идэвхтнүүдийг Эмирын нэр төрийг гутаасан, хөрш орнуудтай харилцааг муутгах аюултай гэсэн үндэслэлээр олноор нь баривчилж, хорьсон байв. Иракийн Курд тусгаар тогтнох талаар есдүгээр сард олон нийтийн санал асуулга явуулахын өмнө хэд хэдэн сэтгүүлч, цахим идэвхтнийг баривчилж, амь насанд нь заналхийлж, гүтгэсэн байв. Йеменд мөн хуту зэвсэгт бүлэглэл Сана болон бусад өөрийн эзэмшлийн бүсэд шүүмжлэгч, хүний эрхийн хамгаалагчдыг баривчилж, саатуулсан байв.

Израиль болон Палестины эзлэгдсэн бүс нутагт Израйлийн эсрэг аливаа ажиллагааг дэмжсэн, мэдэгдэл гаргасан, уриалсан хувь хүн, байгууллагын гишүүдийг нэвтрэхийг хориглож, Палестин, Израйлийн хүний эрхийн төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нь халдаж, Баруун эрэг болон Газын зурваст болсон Палестиний эсэргүүцэгчдийн эсрэг галт зэвсэг хэрэглэсний улмаас 20 хүн алагдаж, олон мянган хүн шархаджээ.

ЦАХИМ ХАЛДЛАГА

Египет гэлтгүй бусад улсын засгийн газрууд цахим ертөнц дэх хяналтаа нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна. Палестин улс нь Цахим эрүүгийн хуулийг долдугаар сард баталж, тус хуулиар төрийг цахимаар шүүмжилсэн сэтгүүлч, мэдээлэл задруулагчдыг баривчлах эрх олгосон. Энэ хуулиар нийтийн дэг журам, үндэсний эв нэгдэл, нийтийн амгалан тайван байдлыг зөрчсөн хүн бүрийг хорих ялаар шийтгэх, 25 жил хүнд хөдөлмөр хийлгэх эрх олгосон юм. Хэд хэдэн Палестин сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагчдад энэ хуулийн дагуу ял тулгасан.

Йорданд тодорхой цахим хуудсанд нэвтрэх эрхийг хориглосоор байна. Оманд “Моватэн” сонинг цахимаар гаргахыг хориглож, “Азамн” сонины газар болон түүний зарим сэтгүүлчдийг 2016 оны төрийн байгууллага болон шүүхийн авлигын талаарх нийтлэлтэй нь уялдуулан хэрэг үүсгэжээ. Иранд Телеграмын алдарт мессэж программыг хаахыг шүүхээс оролдсон ч засгийн газраас эсэргүүцсэн учир хэрэгжүүлж

чадаагүй. Нийтэд түгээн тархсан нийгмийн сүлжээний хэрэгсэл facebook, twitter, youtube хориотой байна.

ПЕРСИЙН БУЛАНГИЙН УЛС ТӨРИЙН ХЯМРАЛ

Саудын Араб улс, Арабын Нэгдсэн Эмират улс, Бахрейн болон Египет нь Катарыг террористуудыг санхүүжүүлж, дэмжиж, хөрш болон бусад улсын дотоод хэрэгт оролцож байна гэж үзэн харилцаагаа тасалснаар Персийн булан дахь улс төрийн хямрал зургадугаар сард эхэлснээр. Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөл зогсонги байдалд ороход нөлөөлсөн юм. Бахрейн, Саудын Араб улс болон Нэгдсэн Эмират улс нь Катарын үйл ажиллагааг эсэргүүцсэн талыг дэмжиж, Катар болон түүний иргэдийг дэмжсэн хэн бүхнийг хорих ялаар шийтгэнэ гэжээ.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЭСЭРГҮҮЦЭЛ

Иргэний нийгмийн төлөөлөгчид үзэл бодлоо илэрхийлэх эрхэд нь халдах аливаа үйл ажиллагааг эсэргүүцэж олон арга хэмжээ авсан юм. Тунист хүний эрхийн тэмцэгчид шаардлагагүй үед хүч хэрэглэн хүний аминд халдсаныхаа төлөө хариуцлагаас мултарч үлдэхгүй байх хуулийн хориг тавиулж чадлаа.

ШАШИН ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

ЗЭВСЭГТ БҮЛЭГЛЭЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хэд хэдэн улсад зэвсэгт бүлэглэл шашны цөөнх рүү халдсан тохиолдол гарсан. Исламын улс гэж өөрсдийгөө нэрлэсэн зэвсэгт бүлэглэл Ирак, Сирийн энгийн иргэдийг Шийтийн сүм болон ойролцоох олон нийтийн газарт тэсрэх бөмбөгтэй амиа хорлогчдыг илгээн амь нас, эрүүл мэндээр хохироосон. НҮБ-ын мэдээлснээр 1 сарын байдлаар Яждий үндэсний 2000 эмэгтэйчүүд, хүүхдүүд Ирак болон Сирид Исламын улсын барьцаанд байлган боолчилж, хүчирхийлж, эрүүдэн шүүсэн юм. Египетэд Исламын улс бүлэглэл Дөрөвдүгээр сард 44 хүний амийг хохироосон хоёр сүмийг дэлбэлснээ хүлээн зөвшөөрч, 300 мөргөлчдийн амь насанд хүрч, Египетийн 2011 оноос хойшхи хамгийн аймшигт халдлага болсон юм.

ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХЯЗГААРЛАЛ

Алжир улсад төр нь шашны Ахмади хөдөлгөөнийхөн рүү халдахад оролцсон байна. Жилийн дотор 280 Ахмади төлөөлөгчдийг итгэл үнэмшлийнх нь төлөө мөрдөн мөшгөсөн байв. Энэ бүсийн улсад нийтлэг дур зураг ажиглагдсан нь шашнаар ялгаварлан гадуурхаж, эрх чөлөөг нь хязгаарлаж, шүүхэд хандах эрхэд нь халдах, хууль бусаар хорих, хөдөлмөрлөх, төрийн үйлчилгээ хүртэх эрхийг нь хязгаарласан явдал юм. Шийтүүдийг баривчлах, саатуулах, зарим тохиолдолд цаазаар авах хэрэг олон гарсан байна. Иранд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх байнга зөрчигдсөөр байна. Бусад шашныг, тухайлбал Яаресан Ахл Э Хак шашныг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрдөггүй тул тэднийг боловсролын салбар, ажил эрхлэхэд нь ялгаварлан гадуурхаж, шашны үйл ажиллагааг нь хориглодог. Шашин болон итгэл үнэмшлээ өөрчлөх эрхийг зөрчих тохиолдол ч байна. Хэд хэдэн христэд итгэгчийг 10-15 жилээр хорих ялаар шийтгэсэн аж.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө олон жилийн тэмцлийн үр дүнд энэ жилд зарим нааштай ахиц гарсан. Йордан, Ливан, Тунист хохирогчтой гэрлэсэн нөхцөлд хүчирхийлэгч ял шийтгэлгүй үлдэх, эсхүл ялаа хөнгөрүүлэх боломжтойг зогсоон хуульд нэмэлт өөрчлөлт

орсон, хууль бус үйлдэл гаргасан, хүчирхийллийн хохирогч болсон ураг төрлийнхөө эмэгтэйг алсан эрийн ялыг хөнгөлдөг хуулийн заалтыг хүчингүй болгосон ч гэр бүлээс гадуур явалдсан ураг төрлийнхөө эмэгтэйг нэр төрөө хамгаалах зорилгоор алсан этгээд шийтгэгдэхгүй үлдэх заалтыг хэвээр үлдээжээ. Тунисийн парламент нь Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэхийг хориглосон тухай хуулийг баталсан нь эмэгтэйчүүд, хүүхдийг хүйсээр ялгаварлан хүч хэрэглэхээс хамгаалах зарим баталгааг бий болгосон юм. Харин Ерөнхийлөгч нь Тунис эмэгтэйг Муслим биш эрэгтэйтэй гэрлэхийг хориглосон зарлиг баталсан. Катар Катар эмэгтэй болон Катар бус эрэгтэйгээс төрсөн хүүхдүүдэд байнга оршин суух эрх олгосон хуулийг баталсан.

Саудын Араб улсад 2018 оны хоёрдугаар хагасаас эхлэн эмэгтэйчүүдэд машин жолоодох эрх олгосон хааны зарлигийг баталсан ч амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар асуудал үүсээд байна. Дөрөвдүгээр сард тус зарлигаар бүх төрийн байгууллагад эмэгтэйчүүд төрийн үйлчилгээг авахад заавал эрэгтэй асран хамгаалагчийн зөвшөөрөл авсан байхыг хуульд өөрөөр заагаагүй бол шаардахгүй байхыг үүрэг болгосон юм. Тэгэхээр гадаад улсад аялах, паспорт авах болон гэрлэх нөхцөлд зөвшөөрөл авах ёстой шаардлага нь хэвээр үлдсэн гэсэн үг.

Нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч энэ бүсэд хуулиар болон практикт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, ялангуяа гэрлэх, гэрлэлтээ цуцлах, өв залгамжлах, хүүхдээ асрахад ялгаварласаар байна. Мөн бэлгийн хүчирхийлэл, хүйсийн байдалд нь үндэслэн үйлдэх гэмт хэрэг тухайлбал бага насандаа гэрлэх болон хүчээр гэрлүүлэхээс хамгаалж чадахгүй байна.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа илэрхийлэл, тодорхойлолтын хүний эрхийн хөдөлгөөний асуудалд эзлэх байр суурь нэмэгдэж байгаа Засгийн газрууд энэ эрхийг нь хуулиар ч, практикт ч хатуу хязгаарласан хэвээр байна.

Египет улсад есдүгээр сард Кайрт болон Ливаны Машроу Лэйла хамтлагийн тоглолтын үеэр солонгын өнгөтэй туг гаргасны төлөө хэд хэдэн хүмүүсийг тэдгээрийн хүйсийн чиг хандлагыг нь төлөө баривчилж, мөрдөн мөшгөх ажиллагаа эхлүүлсэн юм. Хууль сахиулагчид 76 хүнийг баривчилж 5 хүнд нь эрүү шүүлтэнд тооцогддог үзлэг хийсэн байв. Шүүхээс 48 хүнийг 3 сараас 6 жил хүртэл хорих ялаар шийтгэсэн. Аравдугаар сард, парламентийн гишүүд ЛГБТИ хүмүүсийн харилцаа тэдгээрийн цуглаан, бэлгэ тэмдэг, тугийг эрүүгийн хуулиар хориглохыг санал болгосон.

ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

Зарим улсын засгийн газар нь үйлдвэрчний эвлэлийн эрхийг ноцтойгоор зөрчсөн юм. Египетэд жагсаал цуглаан хийсэн, үйлдвэрчний эвлэл байгуулсны төлөө сахилгын арга хэмжээ авах, ажлаас нь халах, цэргийн шүүхээр шүүх, баривчлах зэрэг арга хэмжээ авдаг. 12 дугаар сард, Парламент нь 50-100 гишүүдтэй байж сая үйлдвэрчний эвлэл байгуулж, хууль зүйн статустай болох хууль батлав.

ЦАГААЧ ИРГЭДИЙН ЭРХ

Персийн булан болон бусад улс болох Йордан, Ливанд барилга болон бусад салбарт ажиллаж байгаа цагаач ажилчдын эрх ноцтойгоор зөрчигдөж байна. Нөгөө талаасаа зарим улсад нааштай өөрчлөлт гарсан. Катар улсад наймдугаар сард хоёр хууль батлагдсан. Нэг хуулиар нь ажилчдын шүүхээр шүүлгэх эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй бэрхшээлийг арилгах зорилгоор хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх механизмыг бий болгосон. Хоёрдахь хуулиар анх удаа дотоодын ажилчдын эрхийг хамгаалах, амралтын мөнгө олгох, ажиллах цагийг хязгаарлах зохицуулалт хийж өгсөн. Аравдугаар сард тус улсад цалингийн доод хэмжээг тогтоох, цалингүй

ажилчдад цалин олгох сан байгуулах шинэ хөтөлбөрийг танилцуулсан бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллага Катар улстай тохиролцсон кафала санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэх талаар хөтөлбөрийг нийтлүүлсэн юм. Гэвч ажилчдад хуулиар тогтоосон цагаас илүү цагаар ажиллахыг өөрсдөө зөвшөөрч болох зохицуулалт оржээ. Тус хөтөлбөр цагаач ажилчдыг зөвхөн ажил олгогчдын зөвшөөрлөөр ажлаа өөрчлөхийг зөвшөөрсөн тогтолцоог мөн өөрчлөх зорилготой. Арабын Нэгдсэн Эмират улс ажилчдын ажиллах цагийг хязгаарласан болон ажлаас халагдсаны тэтгэмж олгох, хувийн бичиг баримтаа буцаан авах эрхийг олгосон хуулийг есдүгээр сард баталсан.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ, УСААР ХАНГАГДАХ БОЛОН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

ИЗРАЙЛЬ БОЛОН ПАЛЕСТИНИЙН ЭЗЛЭГДСЭН НУТАГ ДЭВСГЭР

Палестиний нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлснээс хойшхи 50 жилийн, Газын зурвасыг хууль бусаар бүсэлснээс хойшхи 10 жилийн ой энэ жил тохиож байна. Израйлийн эрх бүхий байгууллагууд Баруун эрэг болон зүүн Иерусалимд өөрийн суурьшлыг өргөжүүлэх, дэд бүтэц бий болгох ажиллагааг хэрэгжүүлж, Палестиний эд хөрөнгийг устгах, 660 гаруй иргэдийг албадан нүүлгэх тохиолдол гарсан. Израйлийн төр засаг нүүлгэх зорилгоор Бедуин нутагт иргэдийн болон малчдын эд хөрөнгийг олноор устгасан байна.

Израйль Газын зурваст агаар, хуурай газар, далайн бүслэлт хийснээр нутгийн иргэдэд хүндрэл учруулж, удаан хугацаагаар гадагш зорчуулахгүй, худалдаа хийхэд нь саад учруулж, Газын нийт хүн ам болох 2 сая орчим иргэдийг шийтгэж байгаа юм.

Энэ жил Египетийн Рафа хилийг хаасантай адил, Зүүн эргийн эрх баригчдын шийтгэх арга хэмжээ болох Израйлийн бүслэлт эрчим хүч тасалдан, хэдэн хоногоор гэрэл цахилгаангүй байх, цэвэр усны хангамж тасалдах, эрүүл мэндийн үйлчилгээ авахад саад учруулах зэргээр хүмүүнлэгийн хямрал үүсгэж байна. Бүсийн бусад хэсэгт ч Палестиний дүрвэгсэд, мөн уугуул иргэдийг ялгаварлан гадуурхах бодлого хэрэгжсээр байна. Ливанд гэхэд тэд хөдөлмөрлөх, эд хөрөнгө өмчлөх, залгамжлах, сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхээ эдэлж чадахгүй байгаа.

УС, АРИУН ЦЭВРИЙН ХАНГАМЖ БОЛОН ЭРҮҮЛ МЭНД

Ливийн шүүхэд эрүүл мэндээ хамгаалуулах, цэвэр усаар хангуулах, төрийн өмчит эмнэлэгт хугацаа хэтрүүлсэн эм худалдсан болон хог хаягдлын зохион байгуулалтын асуудлаар Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид удаа дараа гомдол гаргасан.

Тунист усны хомсдлын асуудал маш хурц байна. Усыг нийтэд хүртээх талаар үндэсний стратеги байхгүйгээс бүгдэд ус тэгш олгох боломжгүйг тус улсын засгийн газар хүлээн зөвшөөрөв. Алсын бүсэд мөн усны хангамжийн хомсдол үүссэн нь удаа дараагийн жагсаал цуглааны эх болоод байна.

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Терроризмтой тэмцэх үйл ажиллагаа явуулсны дараагаар хэд хэдэн улсад хүний эрхийн ноцтой зөрчил бий болоод байна. Египет улсад, ихэвчлэн Хойд Синайд аюулгүйн хүчний 100 гаруй гишүүд рүү зэвсэгт бүлэглэлүүд халдаж, Үндэсний аюулгүй байдлын агентлагийн гишүүд сураггүй алга болж, улс төрийн шалтгаанаар шүүхийн бус замаар цаазлуулсан байв. 100 гаруй хүнд шударга бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсны дараа цаазлах ял ногдуулсан. Иракт терроризмын гэмт хэрэгт холбогдон сэжиглэгдэж байгаа сэжигтэнд өмгөөлөлдөө бэлдэх, гэм

буруугүйгээ тогтоолгох хангалттай хугацаа өгөхгүй, гэрчийн мэдүүлэг авахгүй байна. Эрүүдэн шүүх замаар авсан мэдүүлгийг нотлох баримтад тооцох нь шүүхэд хэвээр байна. Ийнхүү шударга бус хэрэг шүүн шийдвэрлэх ажиллагааны дараа яллагдагчид цаазаар авах ял ногдуулдаг. Бахрейн, Израйль болон Кувейт улсад ч үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэж байгаа этгээдийн эсрэг түр саатуулах газар эрүү шүүлт тулгасан талаар гомдол гарсаар байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийг сайтар шалгахгүй байна. Тунист мөн энгийн иргэдийн зорчих эрхийг үргэлжлүүлэн хязгаарлаж байгаагаа тэднийг зэвсэгт мөргөлдөөнд нэгдэхээс хамгаалах зорилготой гэж тайлбарладаг.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Иран, Ирак, Саудын Араб цаазаар авах ялыг хэрэгжүүлж байгаа дэлхийн улсын тоог тэргүүлдэг бөгөөд ингэхдээ уг ялыг ихэвчлэн шударга бус шүүх ажиллагааны дараа ногдуулдаг. Иранд гэхэд 18 нас хүрээгүй дөрвөн хүнд цаазын ял оноож гүйцэтгэсэн ба, олон нийтийн кампанит ажлын дараа зарим насанд хүрээгүйчүүдийн ялыг хойшлуулсныг Эмнести Интернэшнл тогтоосон юм. Цаазаар авах ялын эсрэг аливаа кампанит ажил нь Исламын шашны эсрэг гэж үзэж, тус санааг сурталчилж байгаа идэвхтнүүдийг сүрдүүлэх, хорих хүртэл арга хэмжээ авч байна. Саудын Арабт мансуурах бодистой холбоотой гэмт хэрэг болон олон улсын хэм хэмжээнд гэмт хэрэг гэж тооцогддоггүй үйлдэл, тухайлбал илбэдэх, садар буюу эр нөхрөө хуурах хэргийг гэмт хэрэг гэж үзэн цаазаар авах ял ногдуулдаг. Ирак улсад Исламын бүлэглэлийн дараа олон нийтийн эмх замбараагүй байдлын хариуд цаазаар авах ялыг идэвхитэй хэрэгжүүлж байгаа. Бахрейн болон Кувейт улсад 2010 болон 2013 оноос хойш анх удаа цаазаар авах ялыг буцаан хэрэгжүүлж, хүн амины гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулжээ. Йордан, Ливи, Газын зурвасын Хамасын засгийн газар нь мөн цаазаар авах ялыг хэрэгжүүлж байна. Израйль болон Оманаас бусад улсууд цаазаар авах ялыг ногдуулж ирсэн олон жилийн түүхтэй ч хэрэгжүүлээгүй байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Олон улсын зэвсгийн худалдааны уршгаар тус бүсийн Йемен, Ливи, Сири, Ирак зэрэг улсуудад хүний амь нас хэдэн саяар үрэгдэж байгаа. Зэвсэгт мөргөлдөөн бүрт дайны гэмт хэрэг гарч, олон улсын эрх зүйн хэм хэмжээг ноцтойгоор зөрчин, тухайлбал энгийн иргэдэд халдах, цэргийн объект руу онилох болон дэд бүтцийг устгах үйлдлүүд гарсаар байна. Сири болон Йемен улс олон улсын эрх зүйгээр хориглосон зэвсэг болох цацардаг сум, Сирид химийн зэвсэг хэрэглэсэн.

ЙЕМЕН ДЭХ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Ойрх дорнод болон хойд Африкийн хамгийн ядуу орон болох Йеменд 2015 оны гуравдугаар сарын өмнөх зэвсэгт мөргөлдөөнөөс өмнө ч дэлхийн хамгийн хүнд хүмүүнлэгийн хямрал болж буй газар нутагт тооцогдож байна. НҮБ-ын мэдээлснээр нийт 28 сая иргэдийн гуравны нэгд нь тусламж хэрэгтэй байна. Тухайлбал орчин үе дэх хамгийн аймшигт олон тоог хамарсан холер тус улсад гарч, усны хангамжийн дутагдал болон өлсгөлөн дээд цэгтээ хүрсэн. Зэвсэгт мөргөлдөөний улмаас усны хангамж, боловсрол болон эрүүл мэндийн тогтолцоо сүйрлийн байдалтай байгаа. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Йемений засгийн газрыг дэмжиж буй Саудын Арабын улс тэргүүтэй эвсэл нь хоол хүнс, түлш, эмийн тусламжийн ачааг саатуулсан. Арваннэгдүгээр сард уг эвслийн цэргүүд Йемений хойд боомтыг 2 долоо хоноогоос дээш хугацаагаар хаасан. Эвслийн хүчний цэргүүд оршуулгын ёслолын цуглаан, сургууль, зах, оршин суугчдын газар, иргэний усан онгоцыг агаараар бөмбөгдсөн. Хутигийн эсэргүүцлийн хөдөлгөөн нь өмнөх Ерөнхийлөгч Али Абдулах

Салехийн ивээлд байдаг хүчний бүлэглэлтэй хамт Та Иж хотын иргэдийг бөмбөгдөж, Саудын Арабын хил дээр байгаа иргэдийн амь нас болон эрүүл мэндэд халдсан.

ИСЛАМЫН УЛСЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН АЖИЛЛАГАА

АНУ тэргүүтэй олон улсын эвсэл нь Сири, Ирак улсын аль алинд нь байгаа хүний эрхийг ноцтойгоор зөрчигч Исламын улс гэгчид нэлээд их анхаарал хандуулж байна. Мосул, Ирак улсад Исламын улс нь өөрийн байлдагчдыг хамгаалах зорилгоор олон мянган иргэдийг халхавчлах зорилгоор зэвсэгт мөргөлдөөний талбарт албадан нүүлгэж, зугтаахыг оролдсон иргэдийг олноор нь алж, бусдад анхааруулах зорилгоор олон нийтийн газар дүүжлэн алсан байв. Иракийн зэвсэгт хүч нь өргөн хүрээг хамарсан болон энгийн иргэд өртөх өндөр магадлалтай дэлбэрэх зэвсэг болох пуужингийн зэвсэг хэрэглэсэн байна. Сирийн Курд болон Арабын зэвсэгт хүчнээс бүрдэж буй Сирийн Ардчилсан хүчний үйл ажиллагааны үр дүнд Исламын улс нь Ракка захиргааны нэгж дэх хяналтаа алдсан. Исламын улс нь энгийн иргэдийг халхавч болгон ашиглаж, тэднийг дайны бүсээс гарахад нь саад учруулж, энгийн иргэдийн эсрэг халдлага үлдэж, амь нас эрүүл мэндэд хохирол учруулсаар байна. Иран болон Хезболлахын тэмцэгчид болон Оросын агаарын хүчний дэмжлэгтэй Сирийн засгийн газрын хүч өмнө нь Исламын улсын мэдэлд байсан нутаг дэвсгэрийг өөрийн хяналтанд оруулж чадсан. Энэ чөлөөлөх ажиллагааг явуулахдаа байлдааны объектыг ялган оноилохгүйгээр орон байр, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад халдан энгийн иргэдийн амь нас болон эрүүл мэндийг хохироосон.

СИРИ ДЭХ БҮСЛЭЛТ БА СУРАГҮЙ БОЛСОН ЭНГИЙН ИРГЭД

Сирийн засгийн газар энгийн иргэд оршин сууж байгаа нутгийг удаан хугацаагаар бүсэлж, 400 000 орчим хүнийг эрүүл мэндийн тусламж, авах, наад захын бараа үйлчилгээ, хүмүүнлэгийн тусламжаас салгаад байгаа юм. Мөн тэдгээрийн эсрэг агаарын цохилт, буудлага, бусад халдлагыг хийсээр байна. Эсрэг талын зэвсэгт бүлэглэл нь мөн хэдэн мянган иргэдийн оршин байгаа газрыг бүсэлж, тэдний эсрэг зэвсэг хэрэглэж, иргэдийн эрүүл мэнд болон амь насанд халдсан. Мөн 2016 оны хоёрдугаар хагас болон 2017 оны эхээр “нэгдэх” гэрээний хүрээнд олон иргэдийг албадан нүүлгэн шилжүүлсэн. Эдгээр нь 2011 оноос 2017 оны хооронд Сири улсад нүүлгэн шилжүүлсэн 6,5 сая иргэдийн хэдхэн хувийг л эзэлж байгаа. Хагас сая гаруй хүн Сири улсыг жилийн дотор орхиж, нийтдээ Сирийн дүрвэгсдийн тоо 5 саяд хүрээнд байна.

ИРАКИЙН КУРДУУД

Иракийн Курдийн бүсэд болсон тусгаар тогтнолын талаар санал асуулгыг эсэргүүцэж Засгийн газрын хүч Исламын улстай байлдах явцдаа маргаантай байгаа Киркук болон Курдийн Пешмергийн хүчний эзэлсэн нутгийг буцаан эзэлсэн юм. Аравдугаар сард олон үндэстэнтэй Туз Хурмату хотод болсон Иракийн засгийн газрын хүч болон Пэшемэргэ хүчний байлдааны явцад хэдэн арван мянган энгийн иргэд орон гэрээ орхин зугтаж, 11 иргэн амь насаа алджээ.

ЛИВИ ДЭХ ДОРОЙТОЛ

Ливийн худалдааны зам, цэргийн стратегийн байршилд хяналтаа тогтоохын төлөө тэмцэл засгийн газар, армийнхан болон зэвсэгт бүлэглэлийн хооронд үргэлжилсээр байна. Цэргийнхэн, зэвсэгт бүлэглэл байлдах явцдаа энгийн иргэд рүү халдаж, эсрэг талын бүлгийн байлдагчдийг олзолж, цаазалж, хүний эрхийн хамгаалагч, улс төрийн идэвхтнийг гарал үзүүл, үзэл бодол, улс төрийн байр суурь, эд хөрөнгөнөөс нь болж олзолж, хууль бусаар хорьсон. Төрийн эрх бүхий байгууллага болон армийнхан хорин мянган орчим дүрвэгсэд болон цагаачдыг хууль бусаар баривчилж, хэтэрхий олноор нь, ариун цэврийн шаардлага хангаагүй газар хорьж, эрүү шүүлт тулгаж,

албадан хөдөлмөр эрхлүүлж, хууль бусаар амь насыг нь хохироожээ. Европын холбооны гишүүн улс, тухайлбал Итали улсаас Ливийн хилийн хяналтын алба болон дүрвэгсдийн хорих төвд үзүүлж буй тусламж нь зохих ёсоор хүрч чадахгүй байна.

ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭХ

Хүний эрхийг ноцтой зөрчигчид хариуцлага хүлээхгүй үлдэх нь өнөөгийн хамгийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээхгүй байдал үндэсний түвшинд хадгалагдсаар байна. Ирак улс зэвсэгт мөргөлдөөний үеэр армийнхан болон засгийн газрын талын зэвсэгт хүчний үйлдсэн хүний эрхийн ноцтой зөрчил эрүү шүүлт, шүүхээс гадуур цаазалсан болон сураггүй алга болгосон талаар мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн ч үр дүнг нь олон нийтэд тайлагнасангүй. Ливи улсад ч шүүхийн тогтолцоо нь үр дүнтэй ажиллаж чадахгүй, шүүгч нар өс хонзонгоос айж гэм буруутай этгээдийг хариуцлагад татаж чадахгүй байна. Сири улсад мөн зэвсэгт хүчний бүрэлдэхүүний үйлдсэн гэмт хэрэгтнүүдийг шийтгэх шүүхийн тогтолцоо хараат бус байж чадахгүй, үр дүнтэй ажиллахгүй байна. Йемен улсад Хүний эрхийн зөрчлийн талаар гомдлыг шалгах зорилготой засгийн газрын байгуулсан үндэсний комисс Йемен дэх зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн гэмт хэргийг олон улсын стандартын дагуу шалгаж чадсангүй.

АХИЦ

Бүсийн хэмжээнд байгаа цорын ганц шилжилтийн үеийн хэрэг хянан шийдвэрлэх механизм болох *Тунисын Шударга ёс ба нэр төрийн комисс* нь 1995 оноос 2013 онд үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийг шалгах зорилгоор байгуулагдсан бөгөөд нийт 11 олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. Уг хэлэлцүүлгээр сонгуулийн залилан, сураггүй алга болгосон, эрүүдэн шүүсэн хэргийн талаар мэдүүлэг авсан. Гэвч эдгээр хэргийг шүүхэд шилжүүлэх талаар ямар нэгэн ахиц гараагүй бөгөөд хууль сахиулах байгууллага Комисст мөрдөн шалгах ажиллагаа явуулахад нь тус болох мэдээллээр хангаж чадахгүй байгаа.

Олон улсын хэмжээнд зарим арга хэмжээ авч байгаа ч эдгээр нь маш удаан байна. Олон улсын эрүүгийн шүүхийн Прокурорын алба 2014 оны 6 дугаар сарын 13-наас хойш Палестиний эзлэгдсэн нутаг дэвсгэр болон 2014 оны Газ Израйлийн мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн холбогдох гэмт хэргийг олон улсын эрх зүйн дагуу урьдчилан шалгах ажиллагааг үргэлжлүүлж байна.

Ливи улсад тус алба нь цагаачдын эрхийг олноор зөрчсөн хэрэгт холбогдуулан улс төрийн цэргийн албан тушаалтнуудыг шалгасан нь ахиц хэдий ч бүрэн хэрэгжсэнгүй. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нь есдүгээр сард Ирак улсад Исламын улс гэгчийн үйлдсэн дайны гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчилд хариуцлага ногдуулах нотолгоог бүрдүүлэхэд чиглэсэн тогтоол баталсан ч Иракийн арми, АНУ-ын тэргүүтэй эвслийн хүчний албан тушаалтнуудад хариуцлага ногдуулах талаар тусгаж чадсангүй. НҮБ болон Химийн зэвсгийг хориглох байгууллагын хамтарсан мөрдөн шалгах механизмын үйл ажиллагааны үр дүнд Сирид химийн зэвсэг хэрэглэсэн гэм буруутай этгээдийг хариуцлагад татах талаар зарим нэгэн байдлаар урагшилж байсан ч ОХУ нь тус байгууллагын эрх хэмжээг Аюулгүйн Зөвлөлийн хурлаар нэмэгдүүлэхийг эсэргүүцсэн.

Нөгөө талаасаа үргэлжилж байгаа хоёр ч зэвсэгт мөргөлдөөний үеийн гэмт хэргийн хохирогчдод шударга ёсыг тогтоох найдвар төрж байна. Үүнд 2016 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор байгуулагдсан бөгөөд Сирид 2011 оны 3 дугаар сараас хойш үйлдэгдсэн хамгийн ноцтой гэмт хэргийг шалгах, мөрдөх зорилготой олон улсын хараат бус механизмийг дурдаж болно. Мөн НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл Йемен дэх хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах шинжээчдийн бүлгийг байгуулсан бөгөөд эдгээр механизм нь хүний эрхийг хамгаалах зорилготой.



МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: Халтмаагийн Баттулга (7 дугаар сард Цахиагийн Элбэгдоржийн дараа сонгогдсон)
Засгийн газрын тэргүүн: Ухнаагийн Хүрэлсүх (9 дүгээр сард Жаргалтулгын Эрдэнэбатын дараа томилогдсон)

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжсэнээр цаазаар авах ялыг халсан. Хоригдсон, саатуулагдсан иргэдтэй зүй бус харьцсан, эрүүдэн шүүсэн хэрэгт хариуцлага тооцохгүй байх, хүний эрхийн хамгаалагчид руу халдах явдал үргэлжилсээр байна. Уул уурхайн үйл ажиллагаанд нэрвэгдсэн нутгийн иргэд, шаардлагатай үйлчилгээ хүртээмжгүй гэр хорооллын иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрх зөрчигдөх эрсдэл байна.

Цаазаар авах ял

2015 оны 12 дугаар сард батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсноор цаазаар авах ялыг бүх гэмт хэрэгт халсан.¹ Гэвч хүчиндэж, амь насыг нь хохироосон жигшүүрт хэргүүдэд цаазаар авах ялыг сэргээн хэрэглэх саналыг шинээр сонгогдсон Ерөнхийлөгч 11-р сард Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлжээ.

Хүний эрхийн хамгаалагч

Сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг илчилсэн шүгэл үлээгч хөгжлийн бэрхшээлтэй сурагч, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний эрхийн талаар мэдээлж буй сэтгүүлч, хүний эрхийн хамгаалагчдыг хувийн корпораци, хууль сахиулах албан тушаалтнууд айлган сүрдүүлж, бие махбодид нь халдсан тухай мэдээлсэн. Тэдний хувийн нууцад нь халдах, айлган сүрдүүлэх явдлаас одоогийн хууль тогтоомж хамгаалж чадахгүй байна.

Эрүү шүүлт, зүй бус харьцаа

Хараат бус, тусгай мөрдөн шалгах механизм байхгүйн улмаас хоригдогсодтой тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй, гадаадын иргэдтэй зүй бус харьцсан, эрүүдэн шүүсэн хэргийг нуун дарагдуулах, ял шийтгэлгүй үлдээх явдал үргэлжилсээр. Иргэний нийгмийнхний нөлөөллийн хүчин чармайлтыг үл харгалзан 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин

төгөлдөр болсон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өмнө нь татан буулгасан хараат бус мөрдөн шалгах албыг дахин байгуулах тухай тусгасангүй.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө

7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн тухай хуульд хувь хүн, бизнесийн байгууллагын нэр төрд халдсан, худал мэдээлэл нийтэлсэн бол оногдуулах торгуулийг нэмэгдүүлсэн байна. Хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагууд энэ шинэ хуулийг тодорхой биш, хэт ерөнхий хэмээн шүүмжлэхийн зэрэгцээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дарахын тулд гуйвуулан хэрэглэх эрсдэлтэй хэмээн эмээж байлаа. Хэвлэл мэдээллийн байгууллагууд 4 дүгээр сарын 26-ны өдөр энэ хуулийг эсэргүүцэж байгаагаа мэдэгдсэн ба хожим батлагдсан хуульд торгуулийн хэмжээг багасгасан байв.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх

Эрх баригчид цэвэр ус, газар, бэлчээр ашиглах, эзэмших болон уламжлалт өв соёл, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас малчдыг хамгаалж чадсангүй. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт овоорон ажиллах уул уурхайн компаниуд болон ачаа тээвэрлэх машинуудын нүсэр их шороо, тоос нь малын бэлчээрийг доройтуулж, хүн, малын эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж байна. Хэвлэлийнхэн уул уурхайн компанийн төлөөлөл сэтгүүлчид болон малчдыг заналхийлж байгааг баримтжуулжээ. НҮБ-ын хүний эрх, байгаль орчны асуудлаарх Тусгай Илтгэгч 9 дүгээр сард Монголд айлчилсныхаа дараа олборлолтын зөвшөөрөл өгөхийн өмнө орон нутгийн хүмүүстэй зөвлөлдөх, аюулгүй ажиллагааг баталгаажуулсан стандарт бий болгохыг шаардсан байна.

Орон байртай байх эрх – албадан нүүлгэлт

Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчид хот дахин төлөвлөлтийн төлөвлөгөө, зохистой, шударга нөхөх олговор, бодитой зөвлөлдөх талаар шинэ мэдээ мэдээлэлгүй байгаа нь хот дахин төлөвлөлтийн улмаас албадан нүүлгэлтэд өртөх эрсдэл байна. Оршин суугч иргэд 2016 оны 6 дугаар сард шинээр сонгогдсон хотын захиргаа өмнөх Засгийн газрын гаргасан хот дахин хөгжүүлэх төлөвлөгөөг санхүүжилт дутсан хэмээн хэрэгжүүлсэнгүйд гомдолтой байлаа. Уг төлөвлөгөөнд цэвэр ундны ус, бохир ус зайлуулах хоолой, цахилгаан зэрэг шаардлагад нийцсэн орон байраар хангагдах үндсэн нөхцөлийг багтаасан байжээ.

¹ Монгол: Шинэ Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болсноор цаазаар авах ял түүхэнд үлдэв (АСТ 50/6646/2017)

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНИЙН

ТАЙЛАН 2017/18

ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Эмнести Интернэшнлийн Тайлан 2017/18 нь 159 улс орон, газар нутаг дахь 2017 оны дэлхийн хүний эрхийн нөхцөл байдлыг баримтжуулсан. Энэ нь Эмнести Интернэшнлийн анхаарал татсан асуудлуудыг тусгасан бөгөөд бодлого боловсруулагчид, идэвхтнүүд болон хүний эрхийг сонирхогч хүн бүрийн зайлшгүй үнших ёстой тайлан юм.

2017 онд мөргөлдөөн, эрс хатуу арга хэмжээ, байгалийн гамшиг олон хүнийг аюултай байдал, ядуурал руу түлхэж, олон сая хүн гэр орноо орхин дүрвэж, улс орон дотроо, бусад улс орон руу орогнол эрэхэд хүрлээ. Дэлхийн бүс нутаг бүрд ялгаварлан гадуурхалт өргөн тархаж, зарим тохиолдолд хохирогчид амь насаа алдах хүртэл үр дагавар авчирсан. Засгийн газрууд байгаль орчны идэвхтэн, хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлчид руу халдах, заналхийлэх зэргээр эвлэлдэн нэгдэх, хуран чуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг нүхчин дарсаар байна.

Бүх бүс нутагт хүмүүсийн эр зориг, шийдэмгий байдал олон сая хүн шударга бүс байдлын эсрэг зогсож, дуу хоолойгоо хүргэн, эрхээ эдлэхийг шаардсанаар илэрлээ. Эдгээр хүмүүс гэмт хэрэгт шударга ёсыг баталгаажуулахад тусалж, эрх баригч нарт хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээх ёстойг өдөр бүр сануулж байлаа.

www.amnesty.org
www.amnesty.mn

